



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

ЦУВРАЛ 5



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

ЦУВРАЛ 5

Улаанбаатар, 2022

ННА 67.408
ДАА 345
Ш-978



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА ЦУВРАЛ 5

СУДЛААЧИД:

1. Э.Ганцэцэг, О.Мөнхцэцэг, Б.Ариунтуяа
2. Б.Эрдэнэбэлэг, Б.Эрдэнэбат

Дугаар хариуцсан редактор Г.Оюунболд

© Нээлттэй Нийгэм Форум, 2022.

Энэхүү цувралд багтсан судалгаануудын дүгнэлт, санал нь судалгааг хийж гүйцэтгэсэн судлаачдын байр суурь, үзэл бодол бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN 978-9919-9840-8-3

Шүүхийн шийдвэрийн судалгаа

ЦУВРАЛ 5



1

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ШИНЭЭР ТУСГАСАН
ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭЖ БҮЙ ШҮҮХИЙН ПРАКТИК
ЗАНАЛХИЙЛАХ ГЭМТ ХЭРЭГ БА ӨРСӨЛДӨХ ХЭМ ХЭМЖЭЭ

9

2

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР
ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН
ДҮН ШИНЖИЛГЭЭ

79

ӨМНӨХ ҮГ

Нээлттэй Нийгэм Форум шүүхийн шийдвэрийн судалгааны тавдугаар цувралаараа эрүүгийн шүүхийн шийдвэрийн судалгааг хүргэж байгаадаа баяртай байна. 2015 оны Эрүүгийн хууль, 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд олон зохицуулалт шинээр орсныг иргэд төдий л сайн мэдэхгүйгээс өөрт тохиолдсон гэмт хэргийн шинжтэй үйлдэлд хуулийн байгууллагад хандан хохирлоо барагдуулж, зөрчигдсөн эрхээ сэргээлгэж тэр бүр чадахгүй байна.

Хөгжлийн эрх зүйн төв ТББ болон Санхүү, бизнесийн эрх зүйн судалгааны хүрээлэнгийн зүгээс дээрх хуулиудын чухал ач холбогдол бүхий зүйл, заалтуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, улмаар тайлангийн мөрөөр олон нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхээр ажиллаж байгааг тэмдэглэхэд таатай байна.

Энэхүү цувралд багтсан тайлангуудыг хянан тохиолдуулж, шүүмж бичин судлаачдад зөвлөгөө өгч хамтран ажилласан Нээлттэй Нийгэм Форумын дэргэдэх Шүүхийн шийдвэрийн судалгааны Редакцын зөвлөлийн гишүүн, эрүүгийн эрх зүйн судлаач Г.Оюунболдод гүн талархал илэрхийлье.

Цаашид бид эрүүгийн шүүхийн шийдвэрт хараат бусаар судалгаа хийж, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлуудыг тодорхойлон шийдэл эрэлхийлэх, хуулийн хэрэглээг нэг мөр болгох чиглэлээр судлаачидтай хамтран ажиллахдаа үргэлж нээлттэй байх болно.

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал
П.Эрдэнэжаргал

РЕДАКЦЫН ЗУРВАС

Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд нийгмийн харилцаанд тулгамдаж, иргэдийн эрх ашгийг хөндөж буй 45 асуудлыг Эрүүгийн хуульд шинээр гэмт хэрэгт тооцон оруулсан бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх зэрэг ажиллагааг шинэлэг агуулгаар тусган хэрэгжүүлж эхлээд байна. Эдгээр шинэ зохицуулалт амьдралд хэрхэн хэрэгжиж байгааг тогтмол үнэлэх нь түүнийг зөв агуулгаар хэрэгжүүлэх, хууль хэрэглээний нэгдмэл ойлголтод хүрэх зэрэг ач холбогдолтой.

Энэ удаагийн шүүхийн шийдвэрийн судалгааны цувралд дээр дурдсан шинэ зохицуулалтыг шүүхэд хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар судалсан дараах хоёр тайланг багтаалаа. Хөгжлийн эрх зүйн төвийн гүйцэтгэсэн Эрүүгийн хуульд шинээр тусгасан “Заналхийлэх” гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдийн судалгаа нь иргэдэд тулгардаг хэдий ч тэр бүр гэмт хэрэг хэмээн таньж, хуулийн дагуу эрхээ хамгаалуулж чадахгүй байгаа, олон хэлбэрээр, бусад гэмт хэрэгтэй хавсарч илэрдэг онцлогтой заналхийлэх гэмт хэргийг шүүх хэрхэн шийдэж байгааг авч үзсэн юм. Өмнөх Эрүүгийн хуульд “өмч хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлэх” үйлдлийг л гэмт хэрэгт тооцож байсан бөгөөд бусад байдлаар тодорхой

үйлдэл, эс үйлдэхүйгээр шаардаж заналхийлэх (рекет, шантаж) үйлдлийг гэмт хэрэгт тооцдоггүй, эсвэл зарим тохиолдолд “танхайрах” гэмт хэрэг гэж үзэж шийдвэрлэж байжээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд шинээр зохицуулсан “Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”-ны хэрэгжилтийг үнэлэхдээ өмнө нь хэрэгжиж байсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд яллагдагч, шүүгдэгчид ямар нэгэн хөнгөлөлт, ашигтай нөхцөл тусгаагүйгээс энэ ажиллагаа тэр бүр хийгддэггүй байсан бол одоогийн зохицуулалтаар талуудад илүү нааштай нөхцөл бий болгосон гэдгийг онцолжээ. Гэвч энэхүү хуулийн боломжийг талууд ашиглах явдал хангалтгүй байгаа тул энэ мэт судалгааны ажлыг олон нийтэд таниулан мэдээлэл түгээх нь чухал байна.

Дугаарыг эрхэлсэн редактор
Г.Оюунболд

1

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ШИНЭЭР ТУСГАСАН ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ШҮҮХИЙН ПРАКТИК

ЗНАЛХИЙЛАХ ГЭМТ ХЭРЭГ БА
ӨРСӨЛДӨХ ХЭМ ХЭМЖЭЭ

СУДЛААЧДЫН ТАНИЛЦУУЛГА



ЭРХЭМБАЯРЫН ГАНЦЭЦЭГ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүхийн статистик хариуцсан референт. МУИС-ийн Хууль зүйн сургуульд эрх зүйн бакалавр, хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан.

Баянгол дүүргийн ЗДТГ-д нийгмийн ажилтан, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүгчийн туслахаар ажиллаж байсан. 2016 оноос Шүүхийн ерөнхий зөвлөлд шүүхийн статистик хариуцсан референтээр, 2021 оноос Хөгжлийн эрх зүйн төв ТББ-д судлаачаар ажиллаж байна.



ОТГОНБАЯРЫН МӨНХЦЭЦЭГ

Хөгжлийн эрх зүйн төв ТББ-ын Гүйцэтгэх захирал, судлаач.

2015 онд АНУ-ын St.Thomas-ийн их сургуульд олон улсын хүний эрхийн хуульч мэргэжлээр магистрын зэрэг хамгаалсан. 2011-2018 он хүртэл прокуророор ажиллаж байсан.

Судалгааны
багийн ахлагч:

Э.Ганцэцэг (LL.M)

Судлаачид:

О.Мөнхцэцэг (LL.M)
Б.Ариунтуяа



БАТ-ӨЛЗИЙН АРИУНТУЯА

2018 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн.

Хуульч, судлаач.

ГАРЧИГ

УДИРТГАЛ	14
НЭГ. ЗАНАЛХИЙЛЭХ ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭЖ ИРСЭН ЭРХ ЗҮЙН УЛАМЖЛАЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	20
1.1. Заналхийлэх гэмт явдалтай тэмцэж ирсэн эрх зүйн уламжлал	20
1.2. Заналхийлэх гэмт явдалтай тэмцэх өнөөгийн эрх зүйн орчин	23
ХОЁР. ЗАНАЛХИЙЛЭХ ГЭМТ ХЭРГИЙН БҮРТГЭЛ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААРХ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ	26
2.1. Бүртгэгдсэн гэмт хэргийн статистик	26
2.2. Гэмт хэрэг, ял шийтгэл	29
2.3. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол	36
ГУРАВ. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ	38
3.1. Заналхийлэх гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдал	38

3.2. Заналхийлэх гэмт явдал ба өрсөлдөх хэм хэмжээ	51
3.3. Заналхийлэх гэмт хэргийн нуугдмал байдлын судалгаа	59
ДҮГНЭЛТ	60
САНАЛ	65
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	66
ХАВСРАЛТ	71

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БЗД	Баянзүрх дүүрэг
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
СХД	Сонгинохайрхан дүүрэг
УДШ	Улсын Дээд шүүх
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ЭХ	Эрүүгийн хууль

УДИРТГАЛ

Судалгааны үндэслэл, шаардлага

Монголын нийгмийн хөгжлийн “сүүдэр” талд нь өдрөөс өдөрт өсөн даамжирч буй нэгэн сөрөг үзэгдэл бол заналхийлэх гэмт явдал юм. Статистикаас үзвэл 2010 оноос хойш тухайн үеийн Эрүүгийн хууль (ЭХ)-ийн 149 дүгээр зүйлд заасан Бусдын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлэх гэмт хэрэг бүртгэл төдий л өндөр биш буюу жилд дунджаар дөрвөөс есөн гэмт хэрэг шийдвэрлэгдсэн байна. Тухайлбал, 2010-2017 он хүртэлх долоон жилийн хугацаанд заналхийлэлтэй холбоотой нийт 25 гэмт хэрэг шүүхээр шийдвэрлэгджээ.

2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар энэ төрлийн гэмт хэргийг гурван зүйл гэмт хэрэг болгон дараах байдлаар хуульчилсан. Үүнд:

- 13.5 дугаар зүйл. Заналхийлэх;
- 17.6 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх;
- 23.7 дугаар зүйл. Нийтийн албан тушаалтныг заналхийлэх.

Дээр дурдсанаар 2010-2017 онд бусдын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлсэн нийт 25 гэмт хэрэг шийдвэрлэгдэж байсан бол Эрүүгийн хууль шинэчлэгдсэний дараа 2018-2020 онд буюу шинэ хууль үйлчилж эхэлснээс хойших 2.5 жилийн

хугацаанд заналхийллийн 80 гэмт хэрэг шийдвэрлэгджээ. Үүнээс харахад энэ төрлийн гэмт хэрэг нийгэмд далд, нуугдмал хэлбэрээр ихээхэн “бугшиж” байсан нь эрүүгийн хариуцлагын эрх зүйн шинэ орчин бий болсноор ийнхүү ил тод болсон гэж дүгнэж болохоор байна.

ЭХ-ийн 13.5 дугаар зүйлд заасан заналхийлэх гэмт хэрэг 8 жилийн турш 25 хэрэг (2018 онд дөрөв, 2019 онд 14, 2020 онд 13 хэрэг, ЭХ-ийн 17.6 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэрэг 2018 онд 4, 2019 онд 7, 2020 оны эхний хагас жилд 10 хэрэг, ЭХ-ийн 23.7 дугаар зүйл. Нийтийн албан тушаалтныг заналхийлэх гэмт хэрэг 2020 онд нэг¹) шийдэж байсан атлаа шинэ хууль үйлчилж эхэлсэн 2.5 жилийн хугацаанд 80 хэрэг шийдвэрлэснээс үзвэл энэ төрлийн гэмт хэрэг нийгэмд далд, нуугдмал хэлбэрээр ихээхэн бугшаад байсныг эрүүгийн хариуцлагын эрх зүйн орчин бий болсноор ийнхүү илэрч гарч ирсэн нь харагдаж байна. Цаашид энэ төрлийн гэмт явдалтай үр дүнтэй тэмцэхийн тулд эдгээр хэргийг шийдвэрлэж буй шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх шаардлагатай гэж бид үзэв.

Судалгааны зорилго, зорилт

Бид энэхүү төслийн хүрээнд заналхийлэх гэмт хэргийг² шүүхээр шийдвэрлэж буй байдлыг судлан тухайн шийдвэртэй холбоотой эрх зүйн асуудлыг тодруулах, хэргийн онолыг тодорхойлох, шүүхийн практикийг тогтоох, улмаар эрүүгийн эрх зүйн хөгжилд хувь нэмэр оруулах зорилго дэвшүүлсэн.

¹ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном, 2019, УБ., 178 дахь тал.

² Цаашид энэхүү судалгааны тайланд Эрүүгийн хууль дахь 13.5 дугаар зүйл. Заналхийлэх; 17.6 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх; 23.7 дугаар зүйл. Нийтийн албан тушаалтныг заналхийлэх гэмт хэргүүдийг объектив шинжийн нийтлэг байдлаар нь “заналхийлэх гэмт хэргүүд” хэмээн томъёолсон болно.

Энэ зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьж уг судалгааг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Заналхийлэх гэмт хэргийг шийдвэрлэсэн анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэрүүдийн агуулга, хэлбэрт дүн шинжилгээ хийх;
- Заналхийлэх гэмт хэрэгтэй ойролцоо төрлийн гэмт хэргүүд буюу өрсөлдөх хэм хэмжээ бүхий эрүүгийн хуулийн зүйл, хэсэг, заалтыг шүүхээс хэрэглэж буй практикт дүн шинжилгээ хийх;
- Заналхийлэх гэмт хэрэгтэй давхар зүйлчлэгдэх хувь хүний нууцад халдах, зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийж дамжуулах, тараах, хувь хүний нууцыг задруулах, хууль бусаар мөрдөж мөшгөх, худал мэдээлэл тараах зэрэг нийлмэл гэмт хэргийг шүүхээс хэрхэн шийдвэрлэсэн байдлыг судлан, дүн шинжилгээ хийх зэрэг болно.

Сэдвийн судлагдсан байдал

Эрүүгийн хуулийн 2015 оны шинэчилсэн найруулгад хуульчилсан заналхийлэх гэмт хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн тохиолдол 80 байгаа боловч энэ төрлийн хэрэг судалгааны эргэлтэд ороогүй байгаа бөгөөд заналхийлэх гэмт хэргийн бүхий л хэлбэрийг цогц байдлаар судалсан судалгааны тайлан, бүтээл одоогоор хомс байна.

Гэр бүлийн хүчирхийллийн хүрээнд ЭХ-ийн 13.5 дугаар зүйлд заасан заналхийлэх гэмт хэргийн бүрэлдэхүүн, шийдвэрлэлтийн байдалд судалгаа хийснийг дурджээ³. Энэхүү

³ Нээлттэй Нийгэм Форум (ННФ)-ын дэмжлэгтэйгээр Хүчирхийллийн эсрэг үндэсний төв (ХЭҮТ)-өөс хийсэн “Шинэ төрлийн гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдал” судалгааны тайлан.

судалгаагаар 2017-2020 онд бүртгэгдэн шүүхээр шийдвэрлэсэн гэмт хэргийн статистикт үндэслэн энэ төрлийн гэмт хэргийн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийжээ. Үүнд:

- Шүүхээс гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг хэрхэн ойлгож хэрэглэх талаар Улсын Дээд шүүх (УДШ)-ээс шүүхийн практик тогтоосон байдал, шүүхээс ял оногдуулсан байдал, нийт шийдвэрлэсэн хэргүүдийн гэмт хэргийн бүрэлдэхүүний аль шинжүүд хангагдсанаар гэм буруутайд тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэснийг нэгдсэн байдлаар судалж дүгнэлт өгсөн байна.
- Заналхийлэх гэмт хэргийн бүрэлдэхүүнд задлан шинжилгээ хийж, өмнө мөрдөгдөж байсан ЭХ-ийн 149-р зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлэх гэмт хэрэг”-тэй харьцуулан судаллаа. Мөн бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх; хүчиндэх; нийтийн албан тушаалтныг заналхийлэх; бэлгийн мөлжлөг; хүн худалдаалах; хүн хулгайлах; хүн барьцаалах; албадан хөдөлмөрлүүлэх; шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хэрэгжүүлэхэд саад учруулах; гэрч, хохирогч, шинжээч, орчуулагч, хэлмэрчид хууль бусаар нөлөөлөх; шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчид хууль бусаар нөлөөлөх зэргийг ойролцоо төрлийн гэмт хэрэгт тооцож, тэдгээр гэмт хэргээс заналхийлэх гэмт хэргийн ялгагдах шинжийг тодорхойлжээ.

Бидний хийж буй судалгааны зорилт ХЭҮТ-ийн судалгааны зорилттой давхардахгүй бөгөөд харин ч заналхийлэх гэмт хэргийг өөр өөр өнцгөөс судлан, асуудлын мөн чанарыг бүрэн дүүрэн гаргахад харилцан бие биеэ нөхөх ач холбогдолтой байх болно гэж бид үзэж байна.

Судалгааны хүрээ, арга зүй

Энэхүү судалгаа нь Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан (www.shuukh.mn)-д байршуулсан 2017 оны 7 дугаар сарын 1-нээс 2021 оны 6 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс шийдвэрлэсэн хэргийн хүрээнд хийгдэнэ. Судалгааг ШЕЗ-өөс баталсан “Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлал”⁴, Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллагын зөвлөмж⁵ зэрэгт үндэслэн боловсруулсан аргачлалаар хийж гүйцэтгэв.

Хүснэгт 1. 2018-2020 онд шийдвэрлэгдсэн заналхийлэх гэмт хэргийн тоон мэдээлэл

№	Заналхийлэх гэмт хэрэг	Шийдвэрлэсэн хэрэг		
		2018 он	2019 он	2020 он
1	Эрүүгийн хуулийн 13.5 дугаар зүйл. Заналхийлэх	6	14	13
2	17.6 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх	4	7	10
3	23.7 дугаар зүйл. Нийтийн албан тушаалтныг заналхийлэх	0	0	1
4	13.8 дугаар зүйл. Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийж дамжуулах, тараах	0	0	0

⁴ ШЕЗ, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлал, 2015.

⁵ “Шүүх эрх мэдэл” эмхэтгэл. 2017, №2, 113-122 дахь тал.

Хүснэгт 1-ийн үргэлжлэл

5	13.10 дугаар зүйл. Хувь хүний нууцад халдах	0	2	2
6	13.11 дүгээр зүйл. Хувь хүний нууцыг задруулах	1	1	2
7	13.14 дүгээр зүйл. Худал мэдээлэл тараах	0	0	10
8	16.8 дугаар зүйл. Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах	0	4	3



НЭГ. ЗАНАЛХИЙЛЭХ ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭЖ ИРСЭН ЭРХ ЗҮЙН УЛАМЖЛАЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1. ЗАНАЛХИЙЛЭХ ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭЖ ИРСЭН ЭРХ ЗҮЙН УЛАМЖЛАЛ

Монгол Улс эрүүгийн хууль тогтоомжийнхоо хүрээнд аливаа хэлбэрийн заналхийлэх гэмт хэрэгтэй тэмцэж ирсэн уламжлалтай.

Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлалыг мөшгөвөл бүр 1914 оноос Богд хааны зарлигаар батлан мөрдүүлж ирсэн жинхэнэ дагаж явах хууль дүрэм болох “Аливаа хулгай худлын зэрэг хэрэгт зарлигийг дагаж одоо явуулах цааз хууль арван зүйл”-д “аливаа ялт ард хэлмэгдүүлэн айлгаж хүний мал, эд юмыг авбаас битүү хулгайн ялаас нэгэн зэрэг нэмэгдүүлэн ялласугай”⁶ хэмээжээ. Улмаар 1915 онд Богд хааны зарлигаар эхлүүлсэн төрөлжүүлэн нэгтгэх (кодификаци) ажлын хүрээнд 1918 оноос мөрдөгдөж эхэлсэн Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичгийн 51 дүгээр дэвтэрт “аливаа ялт ард хэлмүүлэн айлгаж хүний эд юмыг авбаас битүү хулгайн ялаас нэгэн зэрэг нэмүүлэн яллагтун. Аливаа хэлмүүлэн айлгаж хүний эдийг авбаас авсан эдийг бодож битүү хулгай болгож хэлэлц... Эд олсонгүй болбоос мөн

⁶ Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал 1911-2009, УБ., 138 дахь тал.

битүү хулгайд бодож эд олсонгүй ялын дээр зэрэг нэмэгтүн”⁷ хэмээн хуульчилж байжээ.

1926 оны шүүх цаазын бичгийн 65 дугаар зүйлд “аливаа хүн, аливаа албан тушаалтны оноосон албыг гүйцэтгэхэд тушаалыг эсэргүүцэн үл дагах буюу тэрхүү тушаалтны аливаа хэргийг зүй бусаар шийтгүүлэхийг хичээж хүчирхэн албадахдаа алах аваас цаазаар авбал зохино. Түүнчлэн шархдуулан дутуу тахир болгох буюу бусад зүйлээр дарлан доромжилбоос зургаан сараас таван жил хүртэл гянданд хорино”⁸. Мөн хуулийн 214 дүгээр зүйлд “ашгийг хичээж залилан мэхэлж бусдын эрхийг эдлэх буюу эсхүл эд юмыг ашиглан шингээвээс...” гэмт хэрэгт тооцохоор зааж харин 216 дугаар зүйлд “энэхүү цааз бичгийн 214 дүгээр зүйлд заасан гэмт явдлыг үйлдэхэд айлган доромжлох зэрэг арга хэрэглэвээс нэгээс зургаан жил хүртэл гянданд хорино”⁹ гэж заажээ. Тэгвэл энэ уламжлал хэвээр хадгалагдаж 1929 оны шүүх цаазын бичгийн 216, 218 дугаар зүйлд тусгасан.

Харин БНМАУ-ын 1942 оны Эрүүгийн хуулийн 95 дугаар зүйлд “албан тушаалтан хүмүүс буюу олон нийтийн ажилчдыг ална, хөрөнгө хогшлыг бутраан сүйтгэнэ гэх зэргээр өөр аливаа нэгэн хүчирхэн дарлах явдлыг гаргана гэж албан тушаалтан буюу олон нийтийн үүрэгт ажил явуулгыг орхиулахын тулд эсвэл занан сүрдүүлэгчийн эрх ашгийн тулд үзлээ өөрчлүүлэх зорилгоор занавал...” хэмээн, 181 дүгээр зүйлд “Албадан хавчих нь аливаа хүнийг айлган сүрдүүлэх буюу жигшүүртэй хэргийг задруулна хэмээн бачимдуулах эсвэл шашин шүтлэгийн явдлыг далимдуулан ашиглаж эд хөрөнгө ба мөнгийг эзэмшиж эдлэх эрхийг шилжүүлэн авч бүрэлгэх бол...” хэмээн томъёолон хуульчилсан бол 1961 оны Эрүүгийн

⁷ Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал 1911-2009, УБ., 225 дахь тал.

⁸ Мөн тэнд, 291 дэх тал.

⁹ Мөн тэнд, 307 дахь тал.

хуулийн 78-р зүйлд “бусдыг ална гэж заналхийлсэн...”, 113-р зүйлд “бусдын эд хөрөнгө, түүнийг эзэмших эрхийг шилжүүлэн авахын тулд хүч хэрэглэнэ гэж заналхийлэх, хохирогч ба түүний ойрын хүмүүсийн нэр алдарт харш мэдээ баримтыг задруулах эсхүл тэдний хөрөнгийг устгана гэж далайлган сүрдүүлбэл...”, 156-р зүйлд “Улс, олон нийтийн байгууллагын албан тушаалтан идэвхтнүүдийг тэдний гүйцэтгэж байгаа үүрэгтэй нь холбогдуулан ална, бие махбодод хүнд гэмтэл учруулна, хөрөнгийг устгана гэж заналхийлбэл...” 195-р зүйлд “Цэргийн албаны хувьд гүйцэтгэж байгаа ажил үүрэгтэй нь холбогдуулан даргаа ална, бие махбодод гэмтэл учруулна, зодно гэж заналхийлбэл...” тус тус гэмт хэрэгт тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заажээ.

БНМАУ-ын Эрүүгийн хуулийг 1986 онд шинэчлэн найруулахад эдгээр үйлдлийг эрүүлжүүлэх уламжлал хэвээр хадгалагдаж 101 дүгээр зүйл. Алах, хүнд гэмтэл учруулахаар заналхийлэх, 130 дугаар зүйл. Улс, хоршоолол, олон нийтийн эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлэх, 159 дүгээр зүйл. Далайлган сүрдүүлэх, 223 дугаар зүйл. Албан тушаалтан болон олон нийтийн журамт үүргээ биелүүлж байгаа иргэнийг заналхийлэх буюу тэдэнд хүч хэрэглэх, 273 дугаар зүйл. Даргаа заналхийлэх үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тус тус заажээ.

БНМАУ 1990 онд зах зээлийн эдийн засагт шилжихтэй холбогдуулан Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай БНМАУ-ын Бага хурлын тогтоол гарсан юм. Уг нэмэлт өөрчлөлтийн хүрээнд Эрүүгийн хуулийн 130 дугаар зүйл болох “Бусдын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлэх үйлдэл” гэмт хэрэгт тооцогдох болсон. Үүнээс хойш Монгол Улсын Эрүүгийн хууль 2002 онд шинээр батлагдсан. Чөлөөт нийгмийн тогтолцоонд нийцүүлэн үйлдэл, эс үйлдэхүйг эрүүжүүлэх, эс эрүүжүүлэх хүрээнд энэ хуулиар олон шинэчлэл хийсэн

билээ. Гэхдээ заналхийлэх аливаа хэлбэртэй тэмцэх эрүүгийн бодлогын хувьд энэ хууль дэвшил гаргасан гэж үзэхэд хэцүү.

2020 оны Эрүүгийн хуулиар бусдыг алах, гэмтэл учруулахаар заналхийлэх болон нийтийн албан тушаалтныг заналхийлэх үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцохгүй болсон юм. Харин бусдын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлэх үйлдлийг гэмт хэрэгт тооцсон хэвээр үлдээсэн. Мөн хуулийн 232 дугаар зүйлээр “олон нийтийн сонгуультаан, түүнчлэн гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг таслан зогсоход оролцож байгаа иргэнийг алахаар болон бие махбодод нь гэмтэл учруулахаар заналхийлэх үйлдлийг гэмт хэрэгт тооцсон нь бий.

1.2. ЗАНАЛХИЙЛЭХ ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ ӨНӨӨГИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13.5 дугаар зүйлд “Заналхийлэх”, 17.6 дугаар зүйлд “Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх”, 23.7 дугаар зүйлд “Нийтийн албан тушаалтныг заналхийлэх” гэсэн гурван төрлийн заналхийлэх гэмт хэргийг хуульчилсан байна. Эдгээр гэмт хэргийн объектив шинжийг задлан шинжилбэл ЭХ-ийн 13.5 дугаар зүйлд заасан заналхийлэх гэмт хэрэг нь “Бусдыг тодорхой үйлдэл хийх эсхүл хийхгүй байхыг шаардах, ингэхдээ:

- Хүч хэрэглэсэн;
- Хүч хэрэглэхээр заналхийлсэн;
- Эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь хохирол учруулж болохуйц баримт мэдээлэл тараахаар сүрдүүлсэн гэх гурван төрлийн үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор хуульчилжээ.

Харин ЭХ-ийн 17.6 дугаар зүйл - эд хөрөнгө авахаар заналхийлэх гэмт хэргийн объектив шинж нь заналхийлэх гэмт хэргээсээ зөвхөн “бусдын эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийн эрхээ шилжүүлэн өгөхийг шаардах шинжээрээ ялгаатай байна. Тэгвэл ЭХ-ийн 23.7 дугаар зүйл - нийтийн албан тушаалтныг заналхийлэх гэмт хэрэг нь нийтийн албан тушаалтныг албан үүрэгтэй нь холбогдуулан заналхийлж, тодорхой шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргахгүй байх, үйл ажиллагаа явуулахгүй байхыг шаардаж буй шинжээрээ ялгаатай.

Иймд эдгээр гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн агуулгад дүн шинжилгээ хийхдээ уг хэргийн объектив талын шинж болох дараах шинж чанаруудыг задлан шинжлэх нь зүйтэй. Үүнд:

А. Тодорхой үйлдэл хийхийг шаардсан эсхүл тодорхой үйлдэл хийхгүй байхыг шаардсан хоёрын аль нь болох эсхүл эд хөрөнгө, эдийн, эдийн бус хөрөнгийн эрхээ шилжүүлэхийг шаардсаны аль нь болох;

Б. Үйлдэл нь:

- Хүч хэрэглэсэн үйлдэл байсан эсэх;
- Хүч хэрэглэхээр заналхийлсэн эсэх;
- Эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь хохирол учруулахуйц баримт мэдээлэл тараахаар сүрдүүлсэн эсэх.

Ингэснээр ЭХ-ийн тухайн зүйл, хэсэг, заалтыг шүүх хэрэглэхэд бодит амьдрал дээр болсон үйл баримттай нийцэхүйцээр хуульд томъёолсон эсэхийг үнэлэх боломжтой болох юм. Улмаар шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн үйл баримтаас ургуулан ЭХ-ийн холбогдох зүйл, хэсэг, заалтад эрх зүйн баримт буюу гэмт хэргийн шинж болгон хуульчилбал

зохих үйлдэл, эс үйлдэхүй байгаа эсэхийг тодруулах боломжтой. Үүнээс гадна заналхийлэх гэмт хэрэг үйлдэхдээ эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь хохирол учруулахуйц баримт мэдээллийг хууль бус аргаар олж авах, хүч хэрэглэсэн үйлдлийнхээ явцад хохирогчид эрүүл мэндийн хохирол учруулах, хүчиндэх болон бэлгийн харилцааны шинжтэй бусад хэлбэрийн гэмт үйлдэл хийх зэрэг өөр хэд хэдэн гэмт хэрэг давхар үйлдэгдэж байдаг нийлмэл шинж, онцлогтой.

Иймд бидний судалгааны явцад энэ төрлийн хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн агуулгаас давхар зүйлчлэгдсэн гэмт хэрэг байгаа эсэх, хувь хүний нууцыг ямар арга замаар олж авсан эсхүл хүч хэрэглэсэн үйлдлийнхээ улмаас эрүүл мэндийн хохирол учруулсан бол түүгээр нь давхар зүйлчилсэн эсэх, заналхийлэх гэмт хэргийг үйлдсэнийхээ дараа хувь хүний нууцыг задруулах, худал мэдээлэл тараах зэрэг гэмт хэрэг үйлдсэн эсэх, тэдгээрт шүүх дүгнэлт хийж шийдвэрлэсэн эсэхийг цаашид нарийвчлан судлах шаардлагатай гэж үзлээ.

ХОЁР. ЗАНАЛХИЙЛЭХ ГЭМТ ХЭРГИЙН БҮРТГЭЛ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААРХ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

(2017 оны 7 дугаар сарын 1-нээс 2020 он хүртэл)

2.1. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИК

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бөгөөд энэхүү судалгаагаар уг хуулийн үйлчлэлийн хүрээнд цагдаагийн байгууллагад ЭХ-ийн 13.5 дугаар зүйлд заасан заналхийлэх, 17.6 дугаар зүйлд заасан бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх, 23.7 дугаар зүйлд заасан нийтийн албан тушаалтныг заналхийлэх гэмт хэрэг тус бүр бүртгэгдсэн талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийв. 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны эхний таван сарын хугацаанд заналхийлэх 175; бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх 59; нийтийн албан тушаалтныг заналхийлэх таван гэмт хэрэг тус тус; нийт 239 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.



Гэмт хэргийн гаралтыг нутаг дэвсгэрийн байдлаар нь авч үзвэл заналхийлэх (ЭХ-ийн 13.5 дугаар зүйл) дөрвөн гэмт хэрэг, нийтийн албан тушаалтныг заналхийлэх (ЭХ-ийн 23.7 дугаар зүйл) хоёр, нийт зургаан хэрэг орон нутагт, бусад нь нийслэлд үйлдэгдэж бүртгэгдсэн байна. Нэг гэмт хэргийн үйлдсэн газар тодорхойгүй байв.

Хүснэгт 2. Бүртгэгдсэн хэргийн нутаг дэвсгэрийн мэдээлэл

Зүйл анги		13.5	17.6	23.7
Гэмт хэрэг үйлдэгдсэн нутаг дэвсгэр	Баянзүрх	49	11	0
	Баянгол	41	5	0
	Сүхбаатар	39	21	0
	Чингэлтэй	1	7	3
	Хан-Уул	13	9	0

Хүснэгт 2-ын үргэлжлэл

Гэмт хэрэг үйлдэгдсэн нутаг дэвсгэр	Сонгинохайрхан	26	4	0
	Багахангай	0	1	0
Гэмт хэрэг үйлдэгдсэн нутаг дэвсгэр	Налайх	1	0	0
	Багануур	0	1	0
	Орон нутаг	4	0	2
	Тодорхойгүй	1	0	0

Гэмт хэрэг гарсан газрыг байршлаар нь авч үзвэл 41.4 хувь нь (99 хэрэг) гэр, орон сууцанд, 13.4 хувь нь (32 хэрэг) аж ахуйн нэгжийн байранд, 10.5 хувь нь (25 хэрэг) олон нийтийн газарт, 9.6 хувь нь (23 хэрэг) гудамж талбайд, 3.8 хувь нь (9 хэрэг) төрийн байгууллагын байранд, 2.9 хувь нь (7 хэрэг) төрийн бус байгууллагын байранд, 18.4 хувь нь (44 хэрэг) бусад газар тус тус үйлдэгдсэн гэж бүртгэгджээ.

Хүснэгт 3. Бүртгэгдсэн хэргийн үйлдэгдсэн газар

Зүйл анги		13.5	17.6	23.7
Гэмт хэрэг үйлдэгдсэн газар	Аж ахуйн нэгжийн байранд	22	9	1
	Бусад газар	32	11	1
	Гудамж талбайд	16	7	0
	Гэр, орон сууцанд	74	25	0
	Олон нийтийн газарт	17	6	2

Гэмт хэрэг үйлдэгдсэн газар	Төрийн байгууллагын байранд	7	1	1
	Төрийн бус байгууллагын байранд	7	0	0

2.2. ГЭМТ ХЭРЭГ, ЯЛ ШИЙТГЭЛ

2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Эрүүгийн хуулийн (шинэчилсэн найруулга) үйлчлэлийн хүрээнд эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны, хяналтын шатны шүүхүүд тус хуулийн 13.5, 17.6, 23.7 дугаар зүйлүүдэд заасан заналхийлэлтэй холбогдох гэмт хэргийг тус тус хүлээн авч шийдвэрлэсэн талаарх статистик мэдээллийг График 2-т харуулав.



Анхан шатны шүүхүүд тайлант хугацаанд эдгээр гурван зүйл ангиар 99 хүнд холбогдох 73 хэргийг хүлээн авснаас 81 хүнд холбогдох 58 хэрэг буюу 79.5 хувийг эцэслэн шийтгэх, цагаатгах тогтоолоор хянан шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 4. Хянан шийдвэрлэсэн, ял шийтгэл оногдуулсан талаарх статистик мэдээлэл

Эрүүгийн хуулийн бүлэг, зүйл		17.6	13.5	17.6	23.7	13.5	17.6	23.7	13.5	17.6	23.7
Он		2017	2018		2019			2020			
Хянан шийдвэрлэсэн	Хэргийн тоо	3	6	4	-	14	7	-	13	10	1
	Холбогдсон хүний тоо	9	7	10	-	16	10	-	14	14	1
Хорих ял оногдуулах-гүйгээр тэнсэх	Бүгд	-	2	-	-	-	-	-	0	6	0
	Үүнээс	ЭХ-ийн 6.7-гийн 1.1; 1.2	-	-	-	-	-	-	0	0	0
		ЭХ-ийн 7.1	-	-	-	-	-	-	0	6	0
Эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн	Зорчих эрхийг хязгаарлах ялаас чөлөөлсөн	-	-	-	-	-	-	-	0	0	0
	Хорих ялаас чөлөөлсөн	-	-	-	-	-	-	-	0	0	0

Хүснэгт 4-ийн үргэлжлэл

Ял шийтгүүлсэн- бүгд	Хүний тоо	9	5	10	-	15	9	-	14	8	0	
	Үүнээс	Эмэгтэй	-	1	1	-	3	2	-	1	1	0
		Өсвөр насны- хан	-	1	-	-	-	-	-	0	0	0

Гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдсон иргэдэд оногдуулсан ялын төрлийг авч үзвэл 31.4 хувьд нь хорих ял (22 хүнд), 57.2 хувьд нь торгох ял (40 хүнд), 11.4 хувьд нь (найман хүнд) нийтэд тустай ажил хийлгэх ял тус тус оногдуулж шийдвэрлэжээ.


Хүснэгт 5. Оногдуулсан ял шийтгэлийн төрөл

Эрүүгийн хуулийн бүлэг, зүйл	17.6	13.5	17.6	23.7	13.5	17.6	23.7	13.5	17.6	23.7
Он	2017	2018			2019			2020		
Торгох ялаар шийт- гүүлсэн хүн-бүгд	1	1	9	-	10	2	-	13	4	0
Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн хүн- бүгд	-	2	-	-	5	-	-	1	0	0

Хүснэгт 5-ын үргэлжлэл

Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн хүн-бүгд	-	-	-	-	-	-	-	0	0	0
Хорих ял шийтгүүлсэн хүн-бүгд	8	2	1	-	-	7	-	0	4	0

Ял шийтгэл авсан иргэдийн насны ангиллыг авч үзвэл 45.7 хувь нь (32 хүн) 35-аас дээш насныхан, 34.3 хувь нь (24 хүн) 22-29 насныхан, 14.3 хувь нь (10 хүн) 30-34 насныхан, 4.3 хувь нь (гурван хүн) 18-21 насныхан, 1.4 хувь нь (нэг хүн) 16-17 насны иргэн байна (График 3-ыг харна уу).



Хүснэгт 6. Ял шийтгүүлэгчдийн насны ангилал, зүйл ангийн задаргаагаар

Эрүүгийн хуулийн бүлэг, зүйл	Он	Насны ангилал					
		14-15	16-17	18-21	22-29	30-34	35-аас дээш
17.6	2017	-	-	-	1	2	6
13.5	2018	-	1	1	1	-	2
17.6		-	-	-	3	2	5
23.7		-	-	-	-	-	-
13.5	2019	-	-	-	4	4	7
17.6		-	-	-	6	-	3
23.7		-	-	-	-	-	-
13.5	2020	0	0	2	6	1	5
17.6		0	0	0	3	1	4
23.7		0	0	0	0	0	0

Ял шийтгүүлсэн иргэдийн боловсролын түвшнийг авч үзвэл 44.3 хувь нь (31 хүн) бүрэн дунд, 37.1 хувь нь (26 хүн) дээд боловсролтой, 4.3 хувь нь (гурван хүн) тусгай мэргэжлийн дунд, 11.4 хувь нь суурь (найман хүн) боловсролтой иргэд байгаа бол 1.4 хувь нь (нэг хүн) бага боловсролтой болон 1.4 хувь нь (нэг хүн) боловсролгүй иргэд эзэлж байна (Хүснэгт 7-г харна уу).

*Хүснэгт 7. Ял шийтгүцүлэгчдийн боловсролын түвшин,
зүйл ангийн задаргаагаар*

Эрүүгийн хуулийн бүлэг, зүйл	Он	Дээд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Бүрэн дунд	Суурь	Бага	Боловсролгүй
17.6	2017	6	-	-	3	-	-	-
13.5	2018	1	-	-	2	2	-	-
17.6		4	-	1	5	-	-	-
23.7		-	-	-	-	-	-	-
13.5	2019	7	-	-	7	1	-	-
17.6		-	-	2	4	2	-	1
23.7		-	-	-	-	-	-	-
13.5	2020	5	0	0	7	2	0	0
17.6		3	0	0	3	1	1	0
23.7		0	0	0	0	0	0	0

Ял шийтгүүлсэн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг авч үзвэл 47.1 хувийг (33 хүн) ажилгүй иргэд эзэлж байгаа бол 1.4 хувь нь (нэг хүн) төрийн захиргааны албан хаагч, 5.7 хувь нь (дөрвөн хүн) төрийн үйлчилгээний албан хаагч, 1.4 хувь нь (нэг хүн) төрийн бус байгууллагын ажилтан, 4.3 хувь нь (гурван хүн) аж ахуйн нэгжийн албан тушаалтан, 5.7 хувь нь (дөрвөн хүн) малчин, 24 хүн буюу 34.3 хувь нь бусад гэсэн ангилалд багтаж байна (Хүснэгт 8-ыг харна уу).

*Хүснэгт 8. Ял шийтгүүлэгчдийн хөдөлмөр
эрхлэлт, зүйл ангийн задаргаагаар*

Эрүүгийн хуулийн бүлэг, зүйл	17.6	13.5	17.6	23.7	13.5	17.6	23.7	13.5	17.6	23.7
Он	2017	2018			2019			2020		
Улс төрийн албан тушаалтан		-	-	-	-	-	-	0	0	0
Төрийн захиргааны албан хаагч		-	-	-	-	-	-	1	0	0
Төрийн тусгай албан хаагч		-	-	-	-	-	-	0	0	0
Төрийн үйлчилгээний албан хаагч		-	-	-	3	-	-	1	0	0
Төрийн бус байгууллагын ажилтан		-	-	-	-	-	-	0	1	0
Аж ахуйн нэгжийн албан тушаалтан		-	1	-	1	-	-	1	0	0
Оюутан		-	-	-	-	-	-	0	0	0
Сурагч		-	-	-	-	-	-	0	0	0
Малчин		1	-	-	3	-	-	0	0	0
Ажилгүй	2	2	5	-	5	8	-	6	5	0
Ялтан		-	-	-	-	-	-	0	0	0
Бусад	7	2	4	-	3	1	-	5	2	0



2.3. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ

Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиуд 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор шүүхийн шүүн таслах ажиллагааны статистикийн тайлан мэдээ гаргах маягт шинэчлэгдэн 2018 оны 4 дүгээр сард батлагджээ. Үүнтэй холбоотойгоор шүүхээр хянан шийдвэрлэсэн хэрэг, учирсан хохирол, хохирогч иргэдийн мэдээлэл бүртгэгдсэн байна. Гэмт хэргийн улмаас нийт 58 иргэн хохирогчоор тогтоогджээ.

Хүснэгт 9. Хохирсон иргэдийн насны ангилал

Эрүүгийн хуулийн бүлэг, зүйл		13.5	17.6	23.7	13.5	17.6	23.7	13.5	17.6	23.7	
Он		2018			2019			2020			
Гэмт хэргийн улмаас хохирогч хүн-бүгд		11	7	0	12	4	0	14	10	0	
Эмэгтэй		2	4	0	10	0	0	8	3	0	
Хохирогч хүн, насны ангиллаар	Өсвөр насны хохирогч	0-4	0	0	0	0	0	0	0	0	
		5-9	0	0	0	0	0	0	0	0	
		10-14	0	0	0	0	0	0	0	1	0
		15-17	7	0	0	2	0	0	1	0	0
	18-21		0	0	0	2	0	0	3	0	0
	22-24		0	0	0	0	0	0	0	0	0
	25-29		0	0	0	5	1	0	3	0	0
	30-34		1	3	0	0	0	0	2	5	0
	35-39		2	2	0	2	1	0	1	1	0

Хүснэгт 9-ийн үргэлжлэл

Хохирогч хүн, насны ангиллаар	40-44	1	0	0	1	1	0	3	1	0
	45-49	0	1	0	0	0	0	1	1	0
	50-54	0	0	0	0	1	0	0	1	0
	55-59	0	1	0	0	0	0	0	0	0
	60-64	0	0	0	0	0	0	0	0	0
	65-69	0	0	0	0	0	0	0	0	0
	70 түүнээс дээш	0	0	0	0	0	0	0	0	0



ГУРАВ. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

3.1. ЗАНАЛХИЙЛЭХ ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

Эрүүгийн хуулийн 13.5.1 дүгээр зүйлээр нийт 33 хэрэг анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэнээс тодорхой үйлдэл хийхийг шаардсан тохиолдол 30, гэрээсээ гарахгүй байхыг тулган шаардсан, өөрийн гэрийн ойролцоо мал бэлчээхгүй байхыг шаардсан, гэртээ архи ууж байхад нь хамт сууж байхыг шаардсан буюу тодорхой үйлдэл хийхгүй байхыг шаардсан гурван тохиолдол байна. Харин эдгээр 33 хэргийн 12 тохиолдолд хүч хэрэглэсэн, 14 тохиолдолд хүч хэрэглэхээр заналхийлсэн бол 14 хэрэгт эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь хохирол учруулахуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлжээ.

Шүүхээс заналхийлэх гэмт хэргийг шийдвэрлэхдээ хүч хэрэглэн эрүүл мэндийн хохирол учруулсан таван тохиолдолд заналхийлэх болон бусдын эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэгт нь давхар зүйлчилж шийдвэрлэжээ. Харин нэг хэрэгт буюу Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс Т-д холбогдох хэргийг шийдвэрлэхдээ “бусдыг тодорхой үйлдэл хийхийг шаардаж өөрт нь хүч хэрэглэн заналхийлэн хохирогчийн биед хөнгөн гэмтэл учруулсан нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан заналхийлэх гэмт хэргийн үндсэн шинжид хамаарч байх тул шүүгдэгчийг хүний

биед хөнгөн хохирол учруулсан гэх Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар давхар зүйлчлэх шаардлагагүй” гэж дүгнэсэн байна.

Үүнээс үзвэл заналхийлэх гэмт хэргийг үйлдэх явцдаа хүч хэрэглэж бусдын эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэгт давхар зүйлчлэх эсхүл Чингэлтэй дүүргийн шүүхийн шийдвэрлэсний адил гэмт хэргийн үндсэн шинжид хамаарч байгаа гэж үзэн давхар зүйлчлэх шаардлагагүй гэсэн ялгаатай практик үүсээд байна.

Давж заалдах шатны шүүхээр заналхийлэх болон бусдын эрүүл мэндэд хохирол учруулсан гурван хэргийг шийдсэн байх ба тэдгээрийг бусдын эрүүл мэндэд хохирол учруулсан тохиолдолд заналхийлэх гэмт хэрэгтэй давхар зүйлчилж шийдвэрлэхээр тусгажээ.

Харин хяналтын шатны шүүхээс шүүгдэгч А-д холбогдох хэргийг шийдвэрлэхдээ “...заналхийлэхдээ бусдыг тодорхой үйлдэл хийхийг шаардаж сүрдүүлсэн үйлдлийг хэрэгжүүлсэн эсэхээс үл хамаарч заналхийлэх гэмт хэргийн шинж хангагдсанд тооцогдох бөгөөд хэрэв уг үйлдлээ хийсэн нь тусдаа гэмт хэргийн шинжийг хангасан тохиолдолд Эрүүгийн хуульд заасан тохирох зүйл, хэсгээр давхар зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэх учиртай”¹⁰ хэмээн тайлбарлаж энэ төрлийн хэрэгт нийлмэл гэмт хэргийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх шүүхийн практикийг амжилттай тогтоожээ.

а. Бусдын хувийн мэдээллийг тараахаар заналхийлэх гэмт хэргийн шийдвэрлэлт

Заналхийлэх гэмт хэрэг үйлдэх явцад хувь хүний нууцад хамаарах мэдээ, баримт сэлтийг хууль бусаар олж явсан

¹⁰ УДШ-ийн 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 553 дугаар тогтоол. shuukh.mn

тохиолдол цөөнгүй байна. Тодруулбал, ЭХ-ийн 13.5.1-ээр зүйлчилсэн 33 гэмт хэргийн 11 тохиолдолд нууцаар зураг авсан, бичлэг хийсэн, хувь хүний нууцад хамаарах баримт сэлтийг хууль бус аргаар олж авсан үйлдлүүд байна. Гэтэл шүүхээс заналхийлэх арга хэрэгсэл болсон хувь хүний нууцад хамаарах мэдээлэл, баримт хууль бус аргаар олж авсан эсэхэд нь эрх зүйн дүгнэлт хийсэн тохиолдол байхгүй байна. Тухайлбал:

Эрүүгийн ...дугаартай хэрэгт хохирогч Э мэдүүлэгтээ: *“...над руу “.....” гэх хуурамч фейсбүцк хаягаас “хүн, хүн шиг зан гаргаж байхад өөдөөс нохой шиг зан гаргах юм аа” гээд миний цаашаа хараад хэвтчихсэн, бөгс нь гарчихсан, дээгүрээ цамцтай байгаа нүцгэн зургийг харуулснаа буцаагаад устгачихсан. Тэр зургийг нь харчхаад би өөрийгөө тэр оройн явж байсан хувцастай мөн байна гэж шууд таньсан. Өөрийнхөө биеийг ч мөн болохыг таньсан. Тэгээд шүүгдэгч Г намайг шууд дарамтлаад эхэлсэн. Чи өдөөд байна уу, аятайхан ярьж байхад уур хүргэлээ, энд зураг, бичлэг байгаа, Э-гийн чамтай унтаж байгаа бичлэг байгаа. Тэгэхдээ Э-г хэн ч танихгүй бичлэг байгаа. Тэгэхээр чамайг яаж ч болно. Энэ бичлэг, зургийг чинь үнэ хүргэж болох зөндөө арга байгаа. Тэрэнтэй дүйцэхүйц миний сэтгэлд нийцэхээр ашигтай зүйл хэл, тэгэхгүй бол порно сайт, фейсбүцк группүүдэд зарна. Фейсбүцкээр тараана гэж сүрдүцлж эхэлсэн юм...”¹¹* гэх хэрэг.

Мөн Ч.Д-д холбогдох заналхийлэх гэмт хэрэгт: *“... шүүгдэгч Ч.Д нь 2019 оны 06 дугаар сарын 15-ны өдөр Сүхбаатар дүцргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах ...дугаар байрны ...тоотод хуучин найз эмэгтэй О.Г-г биеэ хамгаалж чадахгүй (архи, согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэсэн) байх үед нь нүцгэн зураг, бичлэгийг зөвшөөрөлгүй*

¹¹ Б.Г-д холбогдох Заналхийлэх гэмт хэргийн тухай Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 03 дугаар сарын 02-ны 39 тоот шийтгэх тогтоол.

авч түүнийг өөртэйгөө уулзах, церхэхийг шаардаж, эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь хохирол учруулж болохуйц баримт, мэдээлэл буюу дээрх нүцгэн гэрэл зураг, бичлэгийг бусдад тараахаар сүрдүцлсэн...”¹² гэмт хэрэг үйлдсэн байхад энэ үйлдэлд нь шүүхээс ямар нэгэн эрх зүйн дүгнэлт хийлгүй зөвхөн заналхийлэх гэмт хэргээр зүйлчилж шийдвэрлэжээ.

Түүнчлэн тодорхой үйлдэл хийхийг эсхүл хийхгүй байхыг шаардаж заналхийлэх гэмт хэрэг үйлдэгдэж төгссөний дараа тухайн мэдээллээ олон нийтэд тарааж хувь хүний нууцыг задруулах эсхүл худал мэдээлэл тараах эсхүл зөвшөөрөлгүйгээр гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийж дамжуулах, тараах гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийсэн нийт таван тохиолдол гарчээ.

Тухайлбал, эрүүгийн ...дугаартай хэрэгт хохирогчийн хууль ёсны төлөөлөгч Ү мэдүүлэгтээ: “...миний дүц А-тай церхэж байхад миний дүцгийн зарим зураг бичлэгийг авч дөрвөөс таван жил дарамт шахалт үзүүлж байсан. Watsapp болон Facebook хаягийн нууц үгийг нь авч нэвтэрч орж байсан ба тус хаягт байдаг бүлгэмүүдэд орж хүмүүсийн дугаарыг нь авсан. Дээрх зураг бичлэгүүдийг нь багш нарт нь болон найз нарт нь удаа дараа явуулж байсан. Миний охин дүц одоо “D” ангиллын сэтгэц мэдрэлийн өвчтэй болсон ба 2017 оноос хойш тогтмол намар хаврын цед хэвтэн эмчлүүлдэг нь үнэн болно гэсэн Казахстан Улсын эмч нар тодорхойлолт явуулсан. Нийт долоо дахь удаагаа эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа. Өмнө нь эрүүл саруул байдаг байсан. 18-22 насны бага насны охин хүчхэд яагаад сэтгэц мэдрэлийн өвчнөөр өвдсөн бэ гэхээр энэ шүүгдэгчийн дарамтаас болж байнга нойргүй хонож

¹² Ч.Д-д холбогдох Заналхийлэх гэмт хэргийн тухай Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 10 дугаар сарын 02-ны 865 тоот шийтгэх тогтоол.

дарамтад байсан...”¹³ гэх зэргээр мэдүүлсэн хэргийн дээрх үйлдлүүдэд бусдыг заналхийлж мөн хувь хүний нууцад халдах, хувь хүний нууцыг задруулах хэрэг үйлдэгдсээр байхад үүнд нь мөн л шүүхээс эрх зүйн дүгнэлт хийж, давхар зүйлчилж шийдвэрлэсэн тохиолдол гараагүй байна.

Түүнчлэн тодорхой үйлдэл хийхийг эсхүл хийхгүй байхыг шаардаж заналхийлэх гэмт хэрэг үйлдэгдэж төгссөний дараа хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн тохиолдол нэг гарчээ.

Эрүүгийн ...дугаартай хэргийн хохирогч Г.Б мөрдөн байцаалт болон шүүх хуралдаанд өгсөн мэдүүлэгтээ “...Г.А нь над руу залгаад “чи надтай ирж уулз, чиний секс хийж байгаа бичлэг надад байгаа, би бүх сайтад тавилаа” гэхээр нь би чиний гар утсан дээр байсан бүх бичлэгийг устгасан биз дээ, чи яагаад худлаа яриад байгаа юм бэ гэж хэлсэн чинь би чамайг устгахаас өмнө өөр хүн рүү чатаар явуулчихсан байсан юм. Тэр бичлэг надад байгаа, чи намайг гомдоосон, чи надад өртэй, чи манай гэрт эсвэл хоёулаа танай гэрийн ойролцоо уулзъя гэж хэлсэн. Тэгэхээр нь би Г.А-д бичлэг байгаа юм байна гэж бодоод айсандаа уулзахыг зөвшөөрсөн... Тэгсэн чинь хөнжлөө миний толгой дээрээс авснаа миний дээр болон хажуу талд хэвтээд миний хоёр гарыг мушгиж, гараараа барьчихаад миний өмдний товчийг тайлаад миний бэлэг эрхтнийг оролдоод байсан. Дээр нь намайг хүчээр үнсээд байсан. Хөхийг минь бол бариагүй. Тэгтэл гаднаас жолооч ах цагдаа нартай хамт орж ирсэн” гэх мэдүүлгээс үзвэл энэ гэмт хэргийг үйлдсэн этгээд бичлэг тараана гэж заналхийлэн гэртээ авчран, улмаар хүч хэрэглэн бэлгийн харилцааны шинжтэй үйлдэл хийж хүчиндэх гэмт хэрэг давхар үйлдсэнийг шүүхээс нийлмэл гэмт хэрэгт тооцож шийдвэрлэсэн байна.

¹³ А-д холбогдох заналхийлэх гэмт хэргийн тухай Баян-Өлгий аймгийн сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 08 дугаар сарын 14-ний 165 тоот шийтгэх тогтоол.

Заналхийлэх гэмт хэргийн хүндрүүлэх шинжид:

- Бүлэглэж;
- Зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж үйлдсэн.

Онц хүндрүүлэх шинжид:

- Албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж;
- Зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн гэх нөхцөлүүдийг хуульчилсан байдаг.

Мөн заналхийлэх гэмт хэргийг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар буюу бүлэглэж үйлдсэн нэг; зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж үйлдсэн тав; нийт зургаан тохиолдлыг анхан шатны шүүхээс шийдвэрлэсэн бөгөөд заналхийлэх гэмт хэргийг албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглах болон зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн тохиолдол гараагүй байна. Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдэгдсэн заналхийлэх гэмт хэргийн зургаан тохиолдол нь бүгд давхар зүйлчлэгдсэн бөгөөд хүчингийн гэмт хэргийг үйлдэх явцдаа бусдыг тодорхой үйлдэл хийхгүй байхыг шаардсан хоёр; зэвсэг ашиглаж үйлдсэн бусдыг тодорхой үйлдэл хийхийг шаардсан хоёр; бусдын орон байранд хууль бусаар нэвтрэн орж үйлдсэн бусдыг тодорхой үйлдэл хийхийг шаардсан хоёр хэрэг байна.

Шүүхээс ЭХ-ийн 13.5.2 хэсгээр нийт зургаан хэрэг шийдвэрлэсэн байна. Эдгээрийг шүүх шийдвэрлэхдээ нийлмэл гэмт хэргүүдийг давхар зүйлчлэн, заналхийлэх гэмт хэргийн хүндрүүлэх шинжийг тухайн тохиолдол бүрд үнэлж эрх зүйн дүгнэлт өгч шийдвэрлэжээ.

Тухайлбал, Б, Э, Ц нар бүлэглэн 2019 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр 05 цагийн орчимд СХД-ийн 15 дугаар хороо, ...дүгээр байрны ...дугаар орцны ...давхарт ...тоотод иргэн Д-гийн хүсэл зоригийн эсрэг боох, алгадах зэргээр хөнгөн хохирол учруулан хүч хэрэглэж хүчээр бэлгийн харилцаанд орж хүчиндсэн, хүчээр бэлгийн харилцаанд орж хүчиндэх явцдаа түүний эсэргүүцэх үйлдлийг хийхгүй байхыг өөрт нь шаардаж, эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь хохирол учруулж болохуйц баримт, мэдээлэл буюу хохирогчийн бусдад хүчиндүүлж буй бичлэгийг олон нийтэд тараахаар сүрдүүлж заналхийлсэн үйлдлийг ЭХ-ийн 12.1.2.2, 13.5.2.1 дүгээр зүйл, хэсгээр давхар зүйлчлэн¹⁴; шүүгдэгч Г.Г нь 2019 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр БЗД-ийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 13 настай О.Б-гийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэн, хүч хэрэглэхээр заналхийлж, бэлгийн харилцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн, тодорхой үйлдэл хийхгүй байхыг шаардаж, цаасны хутга хэрэглэн өөрт нь хүч хэрэглэхээр заналхийлсэн хууль ёсны ашиг сонирхолд нь хохирол учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн үйлдэлд нь ЭХ-ийн 12.1.4, 11.6.2, 13.5.2.2 дүгээр зүйл, хэсэгт давхар зүйлчилж¹⁵ шийдвэрлэжээ.

Энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэх явцад шүүхээс гаргаж буй илэрхий алдаа гэж хэлж болохуйц нэг асуудал байгаа нь бусдаас мөнгө, эд зүйл шаардаж заналхийлсэн үйлдлийг ЭХ-ийн 17.6-аар бус 13.5-аар зүйлчлэн шийдвэрлэсэн долоон тохиолдол байна. Тухайлбал, Ц.М-д холбогдох хэрэгт хохирогч мэдүүлэхдээ: “...Ц.М-тэй бэлгийн харилцаанд орсон юм. Гэтэл

¹⁴ Э, Ц нарт холбогдох заналхийлэх гэмт хэргийн тухай Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 0815 тоот шийтгэх тогтоол.

¹⁵ Г.Г-д холбогдох заналхийлэх гэмт хэргийн тухай Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 407 тоот шийтгэх тогтоол.

Ц.М би тухай цед бичлэг хийсэн байгаа, уг бичлэгийг хүмүүст болон чиний хүүхдэд үзүүлнэ гэж айлган сүрдүүлж долоо хоногт нэгээс хоёр удаа ирж бай, энэ бичлэгээ устгуулахын тулд 30,000,000 төгрөг өг гэж хэлсэн...”¹⁶. Шүүх эдгээр хэрэгт авагдсан мэдүүлэг, бусад нотлох баримтаар илэрхийлэгдсэн энэ мэт үйл баримтыг үнэлэхгүйгээр зүйлчлэл, шийдвэр гаргаж буйг энд онцолж байна.

Эдгээр тохиолдолд шүүх хэргийг буруу зүйлчилж шийдвэрлэсэн гэхээсээ илүү хэрэгт авагдсан үйл баримтад эрх зүйн дүгнэлт хийгээгүй гэдгийг цохож буйг анхаарна уу. Өөрөөр хэлбэл, эдгээр долоон хэрэгт бусдыг заналхийлэхдээ эд хөрөнгө авахаар заналхийлсэн тухай хохирогчийн мэдүүлэг нь өөр бусад баримтаар тогтоогдоогүй, иймд ЭХ-ийн 17.6 дугаар зүйлээр зүйлчлэх боломжгүй байсан байж болно. Гагцхүү ийнхүү эд хөрөнгө өгөхийг шаардсан нь нотлогдоогүй учир ЭХ-ийн 13.5-аар зүйчилсэн үү эсхүл өөр ямар үндэслэлийг удирдлага болгон хууль зүйн дүгнэлт хийсэн тухай шийдвэртээ дурдах шаардлагатай юм.

б. Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэргийн шийдвэрлэлт

Эрүүгийн хуулийн 17.6.1 дүгээр зүйлээр нийт 21 хэрэг анхан шатны шүүхээр шийдвэрлэгджээ. Эдгээр 21 хэргийн 11 хэрэгт давж заалдсан байна.

Энэ гэмт хэргийн объектив шинжийг задлан шинжилж үзвэл:

А. Бусдаас:

- Эд хөрөнгө шилжүүлэн өгөхийг шаардсан тохиолдол - 21;

¹⁶ Ц.М-д холбогдох заналхийлэх гэмт хэргийн тухай Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 632 тоот шийтгэх тогтоол.

- Эдийн, эдийн бус хөрөнгийн эрхээ шилжүүлэн өгөхийг шаардсан тохиолдол байхгүй.

Б. Ингэхдээ:

- Хүч хэрэглэсэн тохиолдол - 3;
- Хүч хэрэглэхээр заналхийлсэн - 2;
- Эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулж болохуйц баримт мэдээлэл тараахаар сүрдүүлсэн 20 тохиолдол байна.

Энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэх шүүхийн практик харьцангуй тогтсон болох нь шүүхийн шийдвэрүүдээс харагдаж байна. Үүний шалтгаан нь урьд өмнө дагаж мөрдөж байсан 2002 оны ЭХ-ийн 149 дүгээр зүйлийн бусдын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлэх гэмт хэрэг; түүнээс ч өмнөх ЭХ-д дээрхийн ижил бусдын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлэх гэмт хэргийг эрүүжүүлэн хуульчилж хэрэглэж ирсэн, үүнтэй холбоотой үйл баримтыг үнэлэх, эрх зүйн дүгнэлт хийх туршлага шүүхэд нэгэнт хэвшин тогтсонтой холбоотой болов уу.

Түүнчлэн энэ гэмт хэргийг үйлдэх явцдаа өөр гэмт хэрэг давхар үйлдсэн тохиолдол бүрд холбогдох нийлмэл гэмт хэргийг давхар зүйлчлэн шийдвэрлэсэн байна. Тухайлбал, Х.Б-д холбогдох Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэрэгт “...шүүгдэгч Х.Б нь нийт гурван удаагийн үйлдлээр алт, бэлэн мөнгө өгөхийг шаардаж хохирогч Н.Д, С.Э, Г.Э нарын үцсэгэн байгуулсан болон хариуцан ажилладаг хамаарал бүхий уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг хууль ёсоор үйл ажиллагаа явуулж байхад нь хууль бусаар үйл ажиллагаа явуулдаг, байгаль орчныг сүйтгэж байгаа мэтээр нийтэд ойлгуулах зорилгоор дүрс бичлэг хийн өөрийн болон өөрийн үцсэгэн байгуулсан төрийн бус байгууллагын

цахим хаягуудаар цахим орчинд байршуулан, үйл ажиллагааг чинь эрх бүхий төрийн байгууллагуудаар шалгуулж зогсооно гэж эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулж болохуйц баримт мэдээлэл тараахаар сүрдүүлэн, заналхийлж хохирогч С.Э, Г.Э нараас нийт 78,000,000 төгрөг авсан гэмт үйлдэлд нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 17.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн, мөн хохирогч Б.З-г хууль ёсоор үүргээ биелүүлэн албан ажлаа хийж байхад нь “хүнд даацын техникийг байгаль сүйтгэж, хулгайн алт олборлуулахаар байгаль орчинд нэвтрүүлж байна” гэж нэр төр, алдар хүндэд нь халдсан, “Барилга орд” ХХК-ийг дүрэм журам, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байхад нь “гол ус, ойн сан бүхий хуулиар хориглосон газар байгаль сүйтгэж алт олборлож байна” гэж ажил хэргийн нэр хүндэд нь халдсан зэрэг илт худал мэдээллийг өөрийн цахим хаягаар олон нийтэд буюу цахим орчинд байршуулан тараасан гэмт үйлдэлд нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн...”¹⁷ гэм буруутайд тооцож давхар зүйлчилж шийдсэн, мөн шүүгдэгч Х.Ч нь Ч.Г-тэй бчлэглэн 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороо ... тоотод оршин суух иргэн Д.М-ийн фейсбүцк хаягт “Татгалagch Татгалagch” гэсэн цахим хаягаас түүний нүүцэн хоёр ширхэг зургийг илгээж “чиний 12 ширхэг зураг надад байна, тэр зургуудыг чинь хамгийн эхлээд гэр бүл рүү чинь, дараа нь олон нийтийн сүлжээнд тавина, нэг ширхэг зургийг 10 сая төгрөгөөр үнэлнэ” гэж эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулж болохуйц баримтыг тараахаар сүрдүүлсэн гэмт хэрэг, мөн хохирогчийн зургийг

¹⁷ Х.Б-д холбогдох бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэргийн тухай Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 2021 (ШЦТ) 193 тоот тогтоол.

өөрийн найз Ч.Г-д илгээж хувь хүний нууцыг задруулсан хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон, түүнчлэн Ц.А нь хохирогч Б, Ц нартай уулзах цедээ өөрийгөө сахартай болсон, эмчилгээний мөнгө хэрэгтэй байна, туслаач гэж хоёроос гурван удаа уулзах цедээ нууцаар бичлэг хийж уг бичлэгүүдээ эвлүүлэн, хохирогч Б-гээс эд хөрөнгийн эрхээ шилжүүлэн өгөхийг шаардан түүний эрх, хууль ёсны ашиг сонирхолд ноцтой хохирол учруулж болохуйц баримт мэдээлэл тараахаар сүрдүүлж 35 сая төгрөг авсан, хохирогч нарын яриаг нууцаар аудио бичлэг хийж авч мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөн мөшгөсөн хэрэгт холбогдсон¹⁸ хэргүүдийг эд хөрөнгө авахаар заналхийлэх, хувь хүний нууцыг задруулах, хууль бусаар мөрдөж мөшгөх гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож давхар зүйлчлэн шийдвэрлэсэн зэргээс үзвэл бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх бүрэлдэхүүний шинжийг хэрэгт авагдсан үйл баримтад үндэслэн эрх зүйн дүгнэлт хийх, ойролцоо төрлийн гэмт хэрэг болон нийлмэл үйлдэлд нь мөн эрх зүйн дүгнэлт хийх чадамж шүүхүүдэд нэгэнт төлөвшсөн гэж дүгнэж болохоор байна.

в. Нийтийн албан тушаалтныг заналхийлэх гэмт хэргийн шийдвэрлэлт

Эрүүгийн хуулийн 23.7 дугаар зүйлээр нэг хэрэг анхан шатны шүүхээр шийдвэрлэгджээ. Энэ хэргийг давж заалдах болон хяналтын шатны шүүхээр мөн хянан шийдвэрлэсэн байна.

Энэ гэмт хэргийн объектив шинжийг задлан шинжилж үзвэл:

А. Нийтийн албан тушаалтныг:

- тодорхой шийдвэр гаргах эсхүл гаргахгүй байх;

¹⁸ Ц.А-д холбогдох бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэргийн тухай Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 2020 (ШЦТ) 766 тоот тогтоол.

- үйл ажиллагаа явуулах эсхүл явуулахгүй байхыг шаардаж.

Б. Ингэхдээ:

- өөрт болон ойр дотнын хүнд нь хүч хэрэглэсэн;
- хүч хэрэглэхээр заналхийлсэн;
- эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулж болохуйц баримт мэдээлэл тараахаар сүрдүүлсэн гэх шинжийг хуульчилсан байна.

Бидний судалгаанд авагдсан хэргийн товч утгыг дурдвал: *“...шүүгдэгч Д.Б нь 2020 оны 3 дугаар сарын 24-ний өдөр нийслэлийн Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны нутагт үйл ажиллагаа явуулдаг “...” үйлчилгээний төвийн байрнаас өөрийн эзэмшлийн цэрэн холбооны ...дугаараас хохирогч буюу нийтийн албан тушаалтан болох Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын орлогч даргын цэрэг гүйцэтгэгч Д.Т-гийн цэрэн холбооны ...дугаар руу залгаж, “...” үйлчилгээний төвийн хэвийн үйл ажиллагаа буюу цахилгаан, дулаан, ус хязгаарласан үйл ажиллагаагаа таслан зогсоож, Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн ... оны ...дугаар сарын ...-ний өдрийн ... дугаартай “захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай” шүүгчийн захирамж биелүүлэхийг шаардан маргалдаж, улмаар дүүжилж ална гэж хүч хэрэглэхээр заналхийлсэн”¹⁹* гэх хэрэгт холбогджээ. Гэмт хэргийн объектив шинжийг задлан шинжилж үзвэл “нийтийн албан тушаалтныг тодорхой үйл ажиллагаа явуулахыг шаардаж хүч хэрэглэхээр заналхийлсэн” үйл баримт хэрэгт авагдсан байна.

¹⁹ Д.Б-д холбогдох нийтийн албан тушаалтныг заналхийлэх гэмт хэргийн тухай Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 2020 (ШЦТ) 859 тоот тогтоол.

Харин уг хэргийг шийдвэрлэхдээ шүүх: “Гэмт этгээдийн хувьд хүч хэрэглэхээр заналхийлж буй заналхийллийг бий болгох, гүйцэлдүүлэх боломж нөхцөл болоод төрийн албан хаагч нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд саад болохуйц байж чадах нөхцөл байдал, гэмт хэрэгтэн бие хүний хувийн байдал, гэр бүлийн болоод түүний ойр дотнын хүмүүс, хамтран ажиллагсад зэрэг нь заналхийллийг бодитой болгож чадахуйц нөхцөл байдал зэргийг харгалзан үзэх нь зүйтэй” гэж үзээд “...дүцжилж ална гэж хэлсэн сүрдүүлэг нь бодит байдал дээр биелэгдэх боломж, хохирогчид сүрдүүлэг бий болгосон эсэх нь тогтоогдоогүй” гэж дүгнэн цагаатгах тогтоол гаргажээ. Гэтэл давж заалдах шатны шүүхээс “Урт цагаан үйлчилгээний төвийн үйл ажиллагааг зогсоох тухай” захирамжийн биелэлтийг түдгэлзүүлэхээр шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийг биелүүлэхийг шаардаж, тус төвийн цахилгаан, ус хязгаарласан үйл ажиллагаагаа таслан зогсоохыг шаардаж маргалдсан нь хохирогчийн Эрүүгийн хуулиар хамгаалсан эрх ашигт хохирол учруулаагүй, “нийгэмд аюултай” үйлдэл биш байх тул Д.Б-гийн үйлдлийг хэрэгсэхгүй болгож, түүнийг цагаатгасан анхан шатны шүүхийн шийдвэр үндэслэл бүхий болжээ” хэмээн дүгнэсэн байна. Харин УДШ-ээс уг хэргийг хяналтын журмаар хянан хэлэлцэхдээ: “Шүүгдэгч Д.Б-гийн зүгээс нийтийн албан тушаалтныг тодорхой үйл ажиллагаа явуулахыг шаардаж, хохирогч Д.Т-г дүцжилж ална гэж хүч хэрэглэхээр заналхийлсэн хэдий ч энэ нь бодитой хэрэгжих боломжтой байсныг нотолсон баримт хэрэгт авагдаагүй, түүний үйлдэл гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан байх тул ЭХ-ийн 2.1 дүгээр зүйлийн 4-т зааснаар гэмт хэрэгт тооцогдохгүй” гэж дүгнэсэн нь сонирхолтой. УДШ-ийн эл шийдвэрээс үндэслэн ЭХ-ийн 13.5 дугаар зүйлийн заналхийлэх, 17.6 дугаар зүйлийн бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэргүүдэд мөн аливаа хэлбэрээр заналхийлсэн үйлдэл нь

бодитой хэрэгжих боломжтой байсан эсэхийг заавал нотлох, хэрэв бодитой хэрэгжих боломжтой нь нотлогдохгүй бол цагаатгах ёстой юу гэсэн асуулт зүй ёсоор тавигдаж байна. Цаашид энэ асуудлыг нэг мөр болгон шүүхийн практикт хэвшүүлэх нь зүйтэй. Учир нь бусад төрлийн заналхийлэх гэмт хэргийг шийдвэрлэхдээ шүүх заналхийлэл бодитой хэрэгжих боломжтой байсан эсэхийг үнэлэхгүй байна.

3.2. ЗАНАЛХИЙЛЭХ ГЭМТ ЯВДАЛ БА ӨРСӨЛДӨХ ХЭМ ХЭМЖЭЭ

Өмнөх бүлгүүдэд дурдсанчлан заналхийлэх гэмт хэрэг нь ихэвчлэн өөр төрлийн гэмт хэрэгтэй нийлмэл байдлаар үйлдэгддэг онцлог шинжтэй. Уг үзэгдлийн өөрийн онцлогоос хамаарч эхлээд хувь хүний нууцад хамаарах мэдээ баримтыг хууль бусаар олж авах, зөвшөөрөлгүйгээр бусдын эрхэмсэг оршихуйд халдаж гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийх, хууль бусаар мөрдөж мөшгөх зэрэг гэмт үйлдэл хийж, улмаар олж авсан баримт сэлтийг бусдыг заналхийлэх, ийнхүү заналхийлсэн үйлдлийнхээ дараа худал мэдээлэл тараах, хувь хүний нууцыг задруулах, зөвшөөрөлгүй хийсэн дуу, дүрс бичлэгээ тараах, хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах, хүч хэрэглэх замаар заналхийлэхдээ хүний эрүүл мэндэд хохирол учруулах зэрэг нийлмэл гэмт хэрэг үйлдэх нь түгээмэл байна. Бидний өмнөх бүлэгт судалсан шүүхийн шийдвэрүүдээс ийнхүү нийлмэл үйлдэлтэй, давхар зүйлчлэл бүхий гэмт хэргүүдийг шийдвэрлэсэн байдлыг үндэслэн ерөөс заналхийлэх гэмт хэрэгтэй хамт үйлдэгддэг болон ойролцоо төрлийн гэмт хэргүүд буюу өрсөлдөх хэм хэмжээг шүүхээс хэрэглэж буй байдлыг судлах шаардлага бий болсон.

Эл шалтгаанаар судалгааны хүрээнд хамрагдах цаг хугацаанд улсын хэмжээнд шүүхээс худал мэдээлэл тараах

13, хувь хүний нууцыг задруулах зургаа, хувь хүний нууцад халдах хоёр гэмт хэрэг, нийт 21 хэрэг хянан шийдвэрлэснийг судалж үзтэл эдгээр хэрэгт заналхийлэх гэмт хэрэгтэй давхар зүйлчлэн шийдвэрлэсэн хэрэг байхгүй байсан бөгөөд нэг хэрэгт бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэргийг давхар зүйлчлэн шийдвэрлэсэн байна.

Гэтэл эрүүгийн 2007002560162 дугаартай хэрэгт хохирогч О-гийн өгсөн “...2020 оны 03 дугаар сард “Цагаан бичээч хүц” гэсэн фейсбүцк хаягаас миний “Очир туул туул” хаяг руу найзын хүсэлт явуулахаар нь хүлээж авсан. Тэгтэл над руу мессеж бичсэн ба үүнээс хойш бид хоёр хоорондоо мессеж бичсээр байгаад дотно харилцаатай болж бие биедээ хайртай дуртай гэх үгнүүдийг хүртэл бичилцэх болсон. Гэтэл нөгөө “Цагаан бичээч хүц” гэсэн фейсбүцк хаягтай Э.Б нь надтай видео хийх үедээ нүцгэн биеэ харуулаач гэхээр нь би бүх хувцсаа тайлаад түүнд нүцгэн биеэ харуулдаг байсан. Тэр ч гэсэн өөрийнхөө бэлэг эрхтнийг надад харуулдаг байсан. Гэтэл 2020 оны 05 дугаар сарын эхээр чиний фейсбүцкээр хүн ороод байх шиг байна, хайр нь шалгаад өгье гэхээр нь санаанд оролгүй фейсбүцк хаягийнхаа нууц кодыг өгсөн чинь миний кодыг өөрчлөөд намайг орох боломжгүй болгоод тухайн фейсбүцкийг тэр залуу ашиглах болсон. Тэгээд яагаад миний фейсбүцкийн нууц кодыг өөрчилж байгаа юм бэ гэхээр надад хэлэхгүй байхаар нь чамтай харилцахгүй гэсэн чинь надтай видео хийх үедээ утсан дээрээ хуулж авсан миний нүцгэн зургуудыг өөр фейсбүцк хаягаас над руу явуулаад надтай харилцахгүй гэх юм бол энэ зургуудыг чинь олон нийтийн сүлжээнд тавина гэж айлган сүрдүцлээд байна” гэх хэрэгт²⁰; мөн эрүүгийн 2006018932871 дугаартай хэрэг болох

²⁰ Э.Б-д холбогдох Худал мэдээлэл тараах гэмт хэргийн тухай Ховд аймгийн сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 143 тоот шийтгэх тогтоол.

Э.О-гийн хохирогчоос өгсөн: “Тэр үеэс хойш намайг хэл амаар доромжилж эхэлсэн бөгөөд сүүлдээ сошиалаар миний фейсбүцк цахим хаягийг хуурамчаар нээж олон нийтийн сүлжээнд садар бичлэг болон пост оруулж намайг доромжилсон. Тус Т гэх залуу нь хоёрдугаар сард ийм зүйл тохиолдож цагдаагийн байгууллагад хандаж тус залууг дахин ямар нэгэн пост бичихгүй байх талаар сануулж баталгаа гаргуулж байсан боловч дахин олон нийтийн сүлжээнд миний нэртэй зурагтай шинэ хаяг нээж нэр хүндэд халдаж гутаан доромжилж байгаа тул цагдаагийн байгууллагад хандаж байна”²¹ гэх зэргээр мэдүүлсэн хэргийн дээрх үйлдлүүдэд бусдыг заналхийлж, заналхийлсний дараа олон нийтийн сүлжээнд хувь хүний нууцад хамаарах дүрс бичлэг, зургийг өөрийнх нь орчин тойрны хамаатан садан, ажлын хамт олонд тараасан үйлдэлд нь шүүх заналхийлэх гэмт хэргийг давхар зүйлчлэн шийдвэрлэсэн тохиолдол байхгүй байна.

Худал мэдээлэл тараах гэмт хэргүүдийг судлахад хардалтын улмаас болон хувийн таарамжгүй харилцааны улмаас өөрийн мэдсэн бусдын хувийн нууцад халдах зураг, дуу, дүрс бичлэгийг олон нийтийн сүлжээгээр тарааж хувь хүний нууцад халдаж, мөн цааш нь задруулахаар заналхийлсэн тохиолдол хоёр ч байхад шүүх энэ хэрэгт дүгнэлт хийлгүй хувь хүний нууцад халдах гэмт хэргээр дангаар нь зүйлчлэн шийдвэрлэсэн тохиолдол байна.

Тухайлбал, Эрүүгийн 1902008030292 тоот хэрэгт хохирогч Н.Д-гийн мөрдөн шалгах ажиллагааны үед өгсөн: “...2019 онд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны арван гурав гэсэн нэртэй алт олборлосон газарт ашиглалт явуулаад нөхөн сэргээлт явуулахаар Ерөө сумтай гэрээ байгуулан

²¹ Н.Т-д холбогдох Худал мэдээлэл тараах гэмт хэргийн тухай Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 427 тоот шийтгэх тогтоол.

цйл ажиллагаа явуулахаар болсон. Үйл ажиллагаа явуулах бэлтгэл ажлыг ханган 2019 оны 05 дугаар сарын 20-ны цед ажилчдаа аваад өөрсдийн гэрээнд заагдсан газарт очсон. ...2019 оны 06 дугаар сарын 06 байна уу 07-ы өдөр Дэлхийн монгол ногоон нэгдэл төрийн бус байгууллагын тэргүүн Х.Б гэх хүн өөрийгөө танилцуулаад манай уурхай дээр ирсэн. Тэгээд Х.Б манай компанийг энд юу хийж байгаа юм гэж асуухаар нь би нөхөрлөлөөр гэрээ хийгээд цйл ажиллагаагаа эхлүүлэх гээд байж байна гэж тайлбарласан. ...Анх Х.Б хүмүүсийнхээ хамтаар манай уурхай дээр ирээд надтай манай кемпийн гэрт хоёулхнаа уулзаж байхдаа бичлэг хийж байсан залууг гэрээс гаргаад “та тавиас жаран сая төгрөг өг, тэгвэл цйл ажиллагаа хэвийн явна, тэгэхгүй бол уурхайн олборлох ажил чинь явахгүй шүү дээ” гэж хэлсэн. Тэгээд хот руу оффис дээр ирж уулз гэсэн юм. Тухайн цед би түүний амьг дагуулаад тэгье тэгье, очиж уулзъя гэсэн. Х.Б уурхай дээр байн байн ирж бичлэг хийн намайг дарамталж байгаа талаар манай ажилчид бүгд мэднэ. ...Х.Б-гийн худал мэдээллээс цахим орчинд гүтгэн доромжилж, нэр хүндэд халдсан, уг гүтгэлэг, доромжлолоос болж 2019 оны зун ажлаа эхлүүлж чадаагүй, хот, аймгийн төвийн төрийн байгууллагууд руу явж мэдүүлэг, байцаалт өгч нааш цааш явсаар бие, сэтгэл болоод эд материалаар үнэхээр их хохирсон, төрийн бус байгууллага гэсэн нэрийн дор мөрөөрөө зохих зөвшөөрлийн дагуу ажлаа хийж байгаа уурхайн нөхөрлөлүүдийг дарамталж амь залгуулдаг, энэ хууль бус цйл ажиллагаа явуулж байгаа хүмүүсийг хуулийн дагуу арга хэмжээ авч өгнө үү...” гэх;

Хохирогч Г.Э-гийн мөрдөн шалгах ажиллагааны үед хохирогчоор дахин өгсөн: “...Би Х.Б гэдэг хүнд дарамтлуулж, шантаажлуулаад 58,000,000 төгрөг өгсөн байгаа. Түүнээс биш 2019 оны 06 дугаар сард Х.Б-гийн машинаа манай уурхайн хажуу голд живүүлсэн асуудлаас болж түүнд мөнгө өгөөгүй.

Тэр асуудал бол манай уурхайн цйл ажиллагаатай холбоогүй, бид буруугүй учраас Х.Б-д мөнгө өгөх шаардлага байгаагүй...”²² гэх зэрэг мэдүүлгүүдээс харахад шүүх бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэргийг давхар зүйлчлэн, бусдаас эд хөрөнгө өгөхийг удаа дараа шаардан, хууль ёсны эрх, ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулж болохуйц бичлэг хийж, олон нийтийн сүлжээгээр тараасан үйлдлийг зөв зүйчлэн шийдвэрлэсэн нь шүүх ийм төрлийн гэмт хэргийг хэрхэн яаж шийдвэрлэх сайн жишиг тогтоохоор байна.

ЭХ-ийн 13.5 дугаар зүйлийн заналхийлэх гэмт хэргийн бас нэг өвөрмөц шинж нь бэлгийн хүчирхийлэлтэй ихэвчлэн холбоотой үйлдэгдэх байдал байна. Үүнтэй холбоотойгоор заналхийлэл хүчиндэх гэмт хэрэгтэй нийлмэл хэлбэрээр үйлдэгдсэн дөрвөн тохиолдлыг шүүх шийдвэрлэжээ. Уг дөрвөн тохиолдлоос хоёрынх нь хувьд “холбогдогч этгээд хохирогчийн нүцгэн бичлэг, гэрэл зургийг олон нийтийн сүлжээнд тараахаар айлган сүрдүүлж заналхийлэн, түүнтэй бэлгийн харилцаанд орж хүчирхийлж” үйлдсэн; нэг тохиолдлын хувьд хүчиндэх гэмт хэрэг үйлдэх явцдаа хохирогчийн бичлэгийг хийж “хэрэв хүчиндүүлсэн гэдгээ бусдад хэлэх юм бол бичлэгийг нь олон нийтийн сүлжээнд тавих болно” гэж сүрдүүлсэн; өөр бас нэг тохиолдлын хувьд бага насны хүүхдийг хүчиндэх явцдаа бичлэг хийж “хэрэв ээж, аавдаа хэлэх юм бол бичлэгийг нь олон нийтийн сүлжээнд тавина” гэж заналхийлж үйлдсэн хэрэг байна.

Хүчиндэх гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдэхдээ тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг шаардаж өөрт нь, түүний ойр дотнын хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь

²² Х.Б-д холбогдох худал мэдээлэл тараах гэмт хэргийн тухай Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 2021 (ШЦТ) 193 тоот тогтоол.

хохирол учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн тохиолдолд “Заналхийлэх” гэмт хэргийг давхар зүйлчлэх асуудлыг ялгамжтай байдлаар шийдэж байна. Тухайлбал: “...Э.Ч нь Хөвсгөл аймагт оршин суух насанд хүрээгүй хохирогч А.Э-тэй 2018 оны 08 дугаар сард “Дота мастер” нэртэй фейсбүжк цахим хаягаар харилцаж байгаад А.Э-гийн зургийг эмэгтэй хүний нүцгэн зурагтай эвлүүлсэн дүрс ашиглан “өөрийн нүцгэн зургаа явуул, чадахгүй бол чиний энэ зургийг танай Хөвсгөл аймгийн фейсбүжк групп хуудсанд тавина” гэж бусдыг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг шаардсан, мөн хүүхдэд садар самууныг сурталчилсан зүйлийг зориуд үзүүлсэн” гэмт хэрэгт²³ ЭХ-ийн 13.5.1, 16.8 зүйлүүдийг давхар зүүж шийдвэрлэсэн байхад,

“Шүүгдэгч П.Б нь “Анужин анужин ану” гэх фейсбүжк хаяг цахим сүлжээнд үүсгэн, өөрийгөө эмэгтэй хүн гэж итгүүлэн 2019 оны 4 дүгээр сард 18 насанд хүрээгүй буюу 16 нас 7 сар 29 хоногтой эрэгтэй У-тай дээрх фейсбүжк хаягаас чат бичин танилцаж, түүний нүцгэн зураг болон бичлэгийг авч, улмаар 2019 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Баянгол дүүргийн 10 дугаар хороо, ...дугаар байрны ...дугаар орцны ...давхарт насанд хүрээгүй хохирогч У-тай уулзаж, түүний хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүчээр бэлгийн харилцаанд орсон...”²⁴ хэрэгт заналхийлсэн үйлдэлд нь эрх зүйн дүгнэлт хийлгүй, зөвхөн бусдыг хүчиндсэн хэрэгт гэм буруутайд тооцож шийдвэрлэжээ.

Мөн Эрүүгийн хуулийн 16.8 дугаар зүйлээр нийт 16 хэрэг анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэнээс тодорхой үйлдэл

²³ Э.Ч-д холбогдох хүүхдэд садар самуун сурталчлах гэмт хэргийн тухай Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 2 тоот шийтгэх тогтоол.

²⁴ П.Б-д холбогдох хүүхдэд садар самуун сурталчлах гэмт хэргийн тухай Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 2021 (ШЦТ) 374 тоот тогтоол.

хийхгүй байхыг шаардаж заналхийлсэн гэмт хэрэг үйлдсэн хоёр тохиолдол байна.

Хүүхдэд садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйл зориуд үзүүлсэн, өгсөн, сурталчилсан, хүүхдээр садар самуун үйлдэл хийлгэсэн, хүүхдэд биеэ үнэлэх, бэлгийн харилцаанд орохыг санал болгосон гэмт хэрэг үйлдэхдээ заналхийлж буюу тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг шаардаж өөрт нь, түүний ойр дотнын хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь хохирол учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн гэмт хэргийн шинж агуулсан үйлдэл хийсэн тохиолдолд шүүхээс давхар зүйлчилж шийдвэрлэж байгаа боловч зарим гэмт хэргийн хувьд давхар зүйлчлэхгүйгээр зөвхөн хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэргийг дангаар зүйлчилж шийдвэрлэх тохиолдол гарч байна. Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлснээс хойш ЭХ-ийн 16.8 дугаар зүйлийн хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэрэг нийт 16 шийдэгдсэн байх боловч үүнээс дөрөв нь хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэргийг үйлдэхдээ заналхийлсэн шинжтэй тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг шаардсан байхад шүүхээс энэ үйлдэлд нь эрх зүйн дүгнэлт хийгээгүй байх бөгөөд ялгамжтай байдлаар шийдсээр байна. Тухайлбал: *“Шүцгдэгч С.Ц нь ... тоот гэртээ байхдаа 2020 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хооронд насанд хүрээгүй хүүхэд болох хохирогч Б-д (12 нас, 10 сартай, эмэгтэй) садар самууныг сурталчилсан дүрс бичлэг, бусад зүйлийг зориуд үзүүлсэн, өгсөн, садар самуун үйлдэл хийлгэсэн, бэлгийн харилцаанд орохыг санал болгосон, мөн 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдөр ...дугаарын утаснаас насанд хүрээгүй хүүхэд болох хохирогч Б-гийн ...дугаартай утас руу “надтай холбогдохгүй*

бол бичлэг, зургийг чинь фейсбүцк, олон нийтийн сүлжээнд тавина” гэж мессеж бичиж, тодорхой үйлдэл хийхийг шаардан, эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь хохирол учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн гэмт хэрэгт...”²⁵ ЭХ-ийн 13.5.1 дэх хэсэгт зааснаар заналхийлсэн мөн ЭХ-ийн 16.8 дугаар зүйлд заасан хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэрэгт гэм буруутайд тооцож шийдсэн байхад;

БГД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдэгдсэн “...Шүүгдэгч А нь 2020 оны 04 дүгээр сарын 15-наас 16-ны өдрүүдэд өөрийн ашигладаг “В В” гэх нэртэй цахим фейсбүцк хаягаас бага насны буюу 12 настай эмэгтэй Х-гийн ашигладаг “Ch Ch” гэх цахим фейсбүцк хаягт хандан зүй бус садар самуун үг хэллэг ашиглан бэлгийн харилцаанд орохыг санал болгосон, ...мөн А нь “чи блок хийгээд маяглаад байгаарай, бичсэн чатыг чинь групп дээр тавина шүү” “охин олж өг”, “хагас нүцгэн зургаа явуул, эсвэл өөрийгөө өг, 10 минут л хийнэ”, 10 минут л уулзчих, тэгээд дахиж уулзахгүй, тэгэхгүй бол би чиний бичсэн чатыг групп дээр тавина шүү...”²⁶ гэх хэрэгт зөвхөн ЭХ-ийн 16.8 дугаар зүйлд заасан хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэрэгт шийтгэж, заналхийлсэн үйлдэлд нь ямар нэгэн эрх зүйн дүгнэлт хийгээгүй байна.

Дээрх хоёр хэргийн үйл явдал, хохирогч, гэрч, шүүгдэгч нарын мэдүүлгээс харвал хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэрэг үйлдэхдээ хоёр тохиолдлын хувьд хоёулаа тодорхой үйлдэл хийхийг шаардаж, тухайн үйлдлийг

²⁵ С.Ц-д холбогдох худал мэдээлэл тараах гэмт хэргийн тухай Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 476 тоот шийтгэх тогтоол.

²⁶ Б.А-д холбогдох хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэргийн тухай Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 2020 (ШЦТ) 686 тоот тогтоол.

хийхгүй бол хүүхдийн эрх ашигт халдах баримт сэлт, мэдээллийг цахимаар цацаж буюу олон нийтийн сүлжээнд тавина гэж заналхийлсэн байна.

3.3. ЗАНАЛХИЙЛЭХ ГЭМТ ХЭРГИЙН НУУГДМАЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

Шүүхийн шийдвэрт хийсэн судалгаанаас үүдэн заналхийлэх гэмт хэргийн нуугдмал байдлыг заналхийлэх гэмт хэргийн хохирогчид суурилсан судалгааны арга зүйгээр социал орчинд тандан судалгаа явууллаа. Судалгаанд нийт 145 хүн хамрагдсан байх бөгөөд судалгааг нас, хүйс, мэргэжил гэх зэрэг ерөнхий асуултаас гадна өөрөө болон ойр дотнын хэн нэгэн нь бусдын заналхийлэлд өртөж байсан эсэх, ямар хэлбэрээр заналхийлж байсан, энэ талаар хариу ямар арга хэмжээ авсан буюу цагдаагийн байгууллага, хуульч, өмгөөлөгчид хандсан эсэх, заналхийлэгч этгээд эд хөрөнгө ямар нэг зүйл шаардсан эсэх, түүнийг нь биелүүлсэн эсэх, заналхийллийн улмаас ямар хэлбэрийн хохирол учирсан талаар тандан судаллаа. Судалгаанд оролцогчдын дундах 18-25 насны иргэдийн 61 хувь нь фейсбүүкээр цахим орчинд хувь хүний нууцад халдаж, өөрийнх нь эрх ашигт ноцтой хохирол учруулж болохуйц баримт мэдээллийг цахим орчинд тараах хэлбэрээр заналхийлэхэд өртсөн тухай өгүүлжээ. Гэсэн хэдий ч судалгаанд оролцогчдын 84 хувь нь заналхийлэх нь гэмт хэрэг, өөрөө энэ гэмт хэрэгт өртсөн хохирогч гэдгээ мэддэг боловч тэдгээрийн 61 хувь нь энэ талаар хэнд ч хэлээгүй буюу ямар нэгэн хариу арга хэмжээ аваагүй бөгөөд тэрхүү үйлдлийн улмаас 88 хувь нь сэтгэл санаагаар хохирч байна гэжээ. Иймд энэ гэмт хэргийн нуугдмал түвшнийг дэлгэрүүлэн судалж нийгэмд гаргаж тавих нь зүйтэй гэж үзэж байна (Судалгааны дэлгэрэнгүй дүнг Хавсралтаас үзнэ үү).

ДУГНЭЛТ

Заналхийлэх гэмт явдал манай нийгэмд байсаар ирсэн. Эрүүгийн хариуцлагын хүрээнд зарим хэлбэрийн заналхийлэх үйлдэл, эс үйлдэхүйг эс эрүүжүүлж байсан нь энэ төрлийн гэмт явдлыг арилгасангүй, харин ч эрүүжүүлэх, эс эрүүжүүлэх бодлого ээлжлэн тодорхойгүй байдал үүсгэснээр нийгэмд заналхийлэл гаарах шалтгаан болсон ч байж болохоор байна.

Эрх зүйн уламжлалаас авч үзвэл Монгол Улсад бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага тогтвортой хүлээлгэж ирсэн. Харин эд хөрөнгө авахаас өөр зорилгоор заналхийлэх үйлдэлд 1942-2002 он хүртэл хүнийг алах, хүнд гэмтэл учруулахаар заналхийлэх тохиолдолд гэмт хэрэгт тооцохоор, мөн 1961-2002 он хүртэл төрийн албан хаагчийг заналхийлэх үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилж ирснийг 2002 оны эрүүгийн хуулиар халж, зөвхөн бусдын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлэх үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зааж, заналхийлэх бусад хэлбэрийг эс эрүүжүүлсэн билээ.

Харин 2017 оноос үйлчилж эхэлсэн Эрүүгийн хуулиар эл байдлыг өөрчилж гурван хэлбэрийн заналхийлэх үйлдлийг хуульчилсан, тэдгээр эрүүгийн хариуцлагын арга хэмжээний үр нөлөөг хэмжих бодит боломж бүрдсэн.

Судалгаанаас дараах дүгнэлтэд хүрэв. Үүнд:

Нэг. Заналхийлэх гэмт хэргийг шийдвэрлэх талаар шүүхийн нэгдмэл практик дөнгөж тогтож эхэлж байна. УДШ-ээс заналхийлэх гэмт хэргийг *хэлбэрийн* бүрэлдэхүүнтэй буюу заналхийлсэн үйлдэл хийснээр төгссөнд тооцохоор, мөн заналхийлэх үйлдэл *бодитой хэрэгжих боломжтой* байсан эсэхийг шалгаж тогтоох шаардлагатай талаар тодорхой хэргийг хянан шийдвэрлэх замаар шүүхийн практик тогтоожээ²⁷. Харин анхан болон давж заалдах шатны шүүхүүд эдгээр жишиг шийдвэрийг удирдлага болгож буй эсэх нь эргэлзээтэй байна.

Шүүхээс заналхийлэх гэмт хэргийг шийдвэрлэхдээ хүч хэрэглэж эрүүл мэндийн хохирол учруулсан таван тохиолдолд заналхийлэх болон бусдын эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэгт нь давхар зүйлчилж нэг хэрэгт “бусдыг тодорхой үйлдэл хийхийг шаардаж өөрт нь хүч хэрэглэн заналхийлэн хохирогчийн биед хөнгөн гэмтэл учруулсан нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан заналхийлэх гэмт хэргийн үндсэн шинжид хамаарч байх тул шүүгдэгчийг хүний биед хөнгөн хохирол учруулсан гэх Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар давхар зүйлчлэх шаардлагагүй” гэж дүгнэсэн буюу заналхийлэх гэмт хэргийг үйлдэх явцдаа хүч хэрэглэж бусдын эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэгт давхар зүйлчлэх эсхүл гэмт хэргийн үндсэн шинжид хамаарч байгаа гэж үзэн давхар зүйлчлэх шаардлагагүй гэсэн ялгаатай шийдвэр гарчээ.

УДШ-ээс “заналхийлэхдээ бусдыг тодорхой үйлдэл хийхийг шаардаж сүрдүүлсэн үйлдэл, холбогдлыг хэрэгжүүлсэн эсэхээс үл хамаарч заналхийлэх гэмт хэргийн шинж хангагдсанд тооцогдох бөгөөд хэрэв уг үйлдлээ хийсэн нь тусдаа гэмт хэргийн шинжийг хангасан тохиолдолд Эрүүгийн хуульд заасан

²⁷ УДШ-ийн 2019 оны 553, 2021 оны 181 дүгээр тогтоолыг тус тус үзнэ үү.

тохирох зүйл, хэсгээр давхар зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэх учиртай”²⁸ хэмээн тайлбарлан, энэ төрлийн хэрэгт нийлмэл гэмт хэргийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх шүүхийн практикийг амжилттай тогтоожээ.

Хоёр. Гэхдээ эдгээр гэмт хэргийг шийдвэрлэхтэй холбоотой тодорхойгүй олон асуудлаар шүүхийн нэгдмэл практик тогтоогүй байна. Шүүхээс заналхийлэх гэмт хэргийн бүрэлдэхүүнийг бусад ойролцоо төрлийн гэмт хэргээс ялган зүйлчлэхэд алдаа гаргаж ЭХ-ийн 17.6-гаар зүйлчлэх хэргийг 13.5-аар зүйлчилсэн тохиолдол цөөнгүй байна. ЭХ-ийн 17.6-гаар бус 13.5-аар зүйлчилж шийдвэрлэсэн долоон тохиолдол байна. Шүүх эдгээр хэрэгт авагдсан мэдүүлэг, бусад нотлох баримтаар илэрхийлэгдсэн энэ мэт үйл баримтыг үнэлэхгүйгээр зүйлчлэн, шийдвэр гаргасан хэмээн судалгааны багаас дүгнэв. Бусдыг заналхийлэхдээ эд хөрөнгө авахаар заналхийлсэн тухай хохирогчийн мэдүүлэг нь өөр бусад баримтаар тогтоогдоогүй, иймд ЭХ-ийн 17.6-гаар зүйлчлэх боломжгүй байсан байж болно. Гагцхүү ийнхүү эд хөрөнгө өгөхийг шаардсан нь нотлогдоогүй учир ЭХ-ийн 13.5-аар зүйлчилсэн үү эсхүл өөр ямар үндэслэлийг удирдлага болгон хууль зүйн дүгнэлт хийсэн тухайгаа шийдвэртээ дурдах шаардлагатай.

Гурав. Заналхийлэх гэмт хэрэгтэй нийлмэл байдлаар үйлдэгдсэн гэмт үйлдэлд эрх зүйн дүгнэлт өгч шийдвэрлэх явдал туйлын хангалтгүй байна. Судалгаанд хамрагдсан шийдвэрийн хүрээнд давхар зүйлчилбэл зохих 21 гэмт хэргийг нийлмэл гэмт хэргээр зүйлчлээгүй эсхүл эрх зүйн дүгнэлт өгөхгүй орхигдуулсан байна. Бидний судалгаагаар зөвхөн шүүхээс ЭХ-ийн 13.5, 17.6, 23.7 дугаар зүйлүүдээр шийдвэрлэсэн хэргээр хязгаарлалгүй, практикт эдгээр

²⁸ УДШ-ийн 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 553 дугаар тогтоол. shuuh.mn

заналхийлэх гэмт хэрэгтэй нийлмэл байдлаар үйлдэгдэж буй хэргийг шүүхээс хэрхэн шийдвэрлэсэн байдалтай мөн танилцаж эдгээр хэрэгт авагдсан үйл баримтад эрх зүйн дүгнэлтэд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр дээрх дүгнэлтийг гаргасан болно.

Улсын хэмжээнд шүүхээс худал мэдээлэл тараах 13, хувь хүний нууцыг задруулах зургаа, хувь хүний нууцад халдах хоёр, нийт 21 хэрэг хянан шийдвэрлэснийг судалж үзэхэд эдгээр хэрэгт заналхийлэх гэмт хэрэгтэй давхар зүйлчлэн шийдвэрлэсэн хэрэг байхгүй байсан бөгөөд нэг хэрэгт бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэргийг давхар зүйлчлэн шийдвэрлэсэн байв. Гэтэл шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдийг бидний судалсан заналхийлэх гэмт хэргийн хүрээнд авч үзэхэд:

- нийтийн сүлжээнд хувь хүний нууцад хамаарах дүрс бичлэг, зургийг өөрийнх нь орчин тойрны хамаатан садан, ажлын хамт олонд тараасан үйлдэл - 1;
- хувь хүний нууцад халдаж мэдээлэл олж авсан үйлдэл - 2;
- хүүхдэд садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйл зориуд үзүүлсэн, өгсөн, сурталчилсан, хүүхдээр садар самуун үйлдэл хийлгэсэн, хүүхдэд биеэ үнэлэх, бэлгийн харилцаанд орохыг санал болгосон үйлдэл - 4 хэрэгт тус тус авагдсан баримтаар илэрхий тогтоогдож байхад эдгээр үйлдэлд эрх зүйн дүгнэлт өгч давхар зүйлчлэх эсэх талаар ямар нэгэн дүгнэлт хийгээгүй байв.

Харин бидний судалгаанд хамрагдсан шүүхийн шийдвэрийн хүрээнд бусдыг тодорхой үйлдэл хийлгэхээр заналхийлэхдээ ямар нэг байдлаар гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийхийг шаардсан тохиолдол байгаагүй.

Дөрөв. Шүүхийн шийдвэрт хийсэн судалгаанаас үүдэн заналхийлэх гэмт хэргийн нуугдмал байдлыг заналхийлэх гэмт хэргийн хохирогчид суурилсан судалгааны арга зүйгээр социал орчинд тандан судлав. Энэхүү судалгаагаар заналхийлэх үзэгдэл нийгэмд ихээхэн бугшсан, хавтгайрсан байж болох дүр зураг харагдлаа. Бидний явуулсан нуугдмал гэмт явдлын судалгаанд хамрагдсан 18-25 насны респондентын 61 хувь нь фейсбүүкээр цахим орчинд хувь хүний нууцад халдаж, өөрийнх нь эрх ашигт ноцтой хохирол учруулж болохуйц баримт мэдээллийг цахим орчинд тараах хэлбэрээр заналхийлэлд өртсөн тухайгаа мэдээлсэн билээ (Тандалт судалгааны дүнг Хавсралтаас үзнэ үү).

САНАЛ

Энэхүү судалгааны ажлын хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Судалгааны үр дүнг олон нийтэд танилцуулж, заналхийлэх гэмт хэргүүдийг шийдвэрлэж буй шүүхийн практикийг нэг мөр болгох нийгмийн нөлөөллийн арга хэмжээ авах;
- Шат, шатны шүүхийн төлөөлөл оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулж судалгааны үр дүнг танилцуулан, бодит байдлыг хүлээн зөвшөөрөх, судалгааны ажлын чанар, бодит байдлын талаар санал, шүүмж авч сайжруулах;
- Энэ төрлийн гэмт хэргийг зөв зүйлчлэх, ойролцоо төрлийн, нийлмэл гэмт хэргийн болон өрсөлдөх хэм хэмжээний асуудлаар шүүхийн нэгдсэн практик тогтоох нөлөөллийн ажил зохион байгуулах;
- Нийгэмд нуугдмал байдлаар оршин буй заналхийлэх гэмт явдлын бодит түвшнийг гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа (*crime victimization survey*)-гаар тооцон гаргаж ирэх.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Шүүхийн шийдвэрүүд

Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан (www.shuukh.mn)-д нийтлэгдсэн шүүхийн шийдвэрүүдийг эх сурвалж болгож ашиглав.

1. УДШ-ийн 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 553 дугаар тогтоол.
2. Б.Г-д холбогдох Заналхийлэх гэмт хэргийн тухай Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 03 дугаар сарын 02-ны 39 тоот шийтгэх тогтоол.
3. Ч.Д-д холбогдох Заналхийлэх гэмт хэргийн тухай Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 10 дугаар сарын 02-ны 865 тоот шийтгэх тогтоол.
4. А-д холбогдох Заналхийлэх гэмт хэргийн тухай Баян-Өлгий аймгийн сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 08 дугаар сарын 14-ний 165 тоот шийтгэх тогтоол.
5. Э, Ц нарт холбогдох Заналхийлэх гэмт хэргийн тухай Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 0815 тоот шийтгэх тогтоол.
6. Г.Г-д холбогдох Заналхийлэх гэмт хэргийн тухай Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 407 тоот шийтгэх тогтоол.

7. Ц.М-д холбогдох Заналхийлэх гэмт хэргийн тухай Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 632 тоот шийтгэх тогтоол.
8. Х.Б-д холбогдох Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэргийн тухай Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 2021 (ШЦТ) 193 тоот тогтоол.
9. Ц.А-д холбогдох Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэргийн тухай Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 2020 (ШЦТ) 766 тоот тогтоол.
10. Д.Б-д холбогдох Нийтийн албан тушаалтныг заналхийлэх гэмт хэргийн тухай Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 2020 (ШЦТ) 859 тоот тогтоол.
11. Э.Б-д холбогдох Худал мэдээлэл тараах гэмт хэргийн тухай Ховд аймгийн сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 143 тоот шийтгэх тогтоол.
12. Н.Т-д холбогдох Худал мэдээлэл тараах гэмт хэргийн тухай Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 427 тоот шийтгэх тогтоол.
13. Э.Ч-д холбогдох Хүүхдэд садар самуун сурталчлах гэмт хэргийн тухай Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 2 тоот шийтгэх тогтоол.
14. П.Б-д холбогдох Хүүхдэд садар самуун сурталчлах гэмт хэргийн тухай Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 2021 (ШЦТ) 374 тоот тогтоол.

15. С.Ц-д холбогдох Худал мэдээлэл тараах гэмт хэргийн тухай Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 476 тоот шийтгэх тогтоол.
16. Б.А-д холбогдох Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэргийн тухай Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 07 дугаар сарын 16-ний өдрийн 2020 (ШЦТ) 686 тоот тогтоол.
17. Ж.С-д холбогдох Худал мэдээлэл тараах гэмт хэргийн тухай Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 229 тоот шийтгэх тогтоол.
18. Н.Т-д холбогдох Худал мэдээлэл тараах гэмт хэргийн тухай Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 427 тоот шийтгэх тогтоол.
19. Х.Б-д холбогдох Худал мэдээлэл тараах гэмт хэргийн тухай Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 193 тоот шийтгэх тогтоол.
20. Э.Х-д холбогдох Худал мэдээлэл тараах гэмт хэргийн тухай Сэлэнгэ аймгийн мандал сум дахь сум дундын шүүхийн 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 22 тоот шийтгэх тогтоол.
21. Г.М-д холбогдох Худал мэдээлэл тараах гэмт хэргийн тухай Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 340 тоот шийтгэх тогтоол.
22. Б.У-д холбогдох Худал мэдээлэл тараах гэмт хэргийн тухай Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 09 тоот шийтгэх тогтоол.

23. Б.У-д холбогдох Худал мэдээлэл тараах гэмт хэргийн тухай Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 48 дугаартай шийтгэх тогтоол.
24. Н.М-д холбогдох Худал мэдээлэл тараах гэмт хэргийн Увс аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 106 тоот шийтгэх тогтоол.
25. Т.М-д холбогдох Худал мэдээлэл тараах гэмт хэргийн тухай Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 82 тоот шийтгэх тогтоол.
26. Т.Ц-д холбогдох Худал мэдээлэл тараах гэмт хэргийн Сэлэнгэ аймаг сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 98 тоот шийтгэх тогтоол.
27. Б.Б-д холбогдох Худал мэдээлэл тараах гэмт хэргийн тухай Хөвсгөл аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 112 тоот шийтгэх тогтоол.
28. С.Б-д холбогдох Хувь хүний нууцад халдах гэмт хэргийн тухай Увс аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 05 тоот шийтгэх тогтоол.
29. Ж.Э-д холбогдох Хувь хүний нууцыг задруулах гэмт хэргийн тухай Дархан-Уул аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 68 тоот шийтгэх тогтоол.
30. Б.З-д холбогдох Хувь хүний нууцыг задруулах гэмт хэргийн тухай Дархан-Уул аймаг дахь Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн оны дугаар сарын ...-ны өдрийн тоот магадлал.

31. Н.К-д холбогдох Хувь хүний нууцад халдах гэмт хэргийн тухай Баян-Өлгий аймаг дахь сум дундын шүүхийн 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 111 тоот шийтгэх тогтоол.
32. Д.М-д холбогдох Хувь хүний нууцыг задруулах гэмт хэргийн тухай Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 02 тоот шийтгэх тогтоол.



Монгол Улсын хууль

1. Эрүүгийн хууль 2002, 2015.


Ном

1. Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Нээлттэй Нийгэм Форум, Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2016, 2017, 2018, 2019.
2. Монгол Улсын Хууль зүйн яам, Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал, 1911-2009.


ХАВСРАЛТ. ЗАНАЛХИЙЛЭХ ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААР ХОХИРОГЧИД СУУРИЛСАН ЦАХИМ ОРЧИН ДАХЬ СУДАЛГААНЫ ДҮН




Заналхийлэх гэмт хэргийн талаар мэдэх эсэх




Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдал




Ямар нэгэн хэлбэрийн заналхийлэлд өртөж байсан эсэх




Хэрэв заналхийлэлд өртөж байсан бол ямар хэлбэрээр таныг заналхийлж байсан бэ?




Заналхийлэгч хувь хүний нууцад нь халдаж байсан эсэх




Заналхийлэгч хувь хүний нууцад нь халдаж байсан бол ямар хэлбэрээр халдсан бэ?




Заналхийлэгч этгээдийн зүгээс шаардсан зүйл




Заналхийлж авсан мэдээллээ бусдад тараана гэж айлган сүрдүүлсэн эсэх




Хэрэв айлган сүрдүүлсэн бол заналхийлж авсан мэдээллээ хэнд тараана гэж сүрдүүлсэн бэ?




Заналхийлэл, сүрдүүлэгт өртсөн талаараа хэнд хандаж хэлсэн бэ?



**Найз нөхөд, гэр бүл, ойр дотныхон нь тухайн хүнийг
заналхийлэлд өртсөнийг мэдсэн эсэх**



**Заналхийлэл, сүрдүүлэгт өртсөн тохиолдолд
хуулийн байгууллагад хандах боломжтойг мэдэх эсэх**





2

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

СУДЛААЧДЫН ТАНИЛЦУУЛГА



БУРМААГИЙН ЭРДЭНЭБЭЛЭГ

Санхүү, бизнесийн эрх зүйн судалгааны хүрээлэн ТББ-д зөвлөх, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа “Билиг” Хууль зүйн дээд сургуулийн багш, хуульч, докторант.

Хууль зүйн их, дээд сургуульд “Эрүүгийн процессын эрх зүй”, “Нотлох баримтын онол”, “Хууль зүйн сэтгэл судлал”, “Криминалистикийн арга зүй”, “Криминалистикийн тактик” хичээлүүд заадаг.



БАТСАЙХАНЫ ЭРДЭНЭБАТ

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуульд ахлах багш, судлаачаар ажилладаг. 2010 онд ОХУ-ын Москва хот дахь ДЯЯ-ны харьяа Их сургууль төгссөн, эрх зүйч мэргэжилтэй.

Судлаачид:

Б.Эрдэнэбэлэг
(LL.M. Докторант)

Б.Эрдэнэбат (LL.M.)

АГУУЛГА

УДИРТГАЛ 90

НЭГ. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ ХЯЛБАРШУУЛСАН
ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ
ОЙЛГОЛТ, ХУУЛЬ ЗҮЙН УЧИР ХОЛБОГДОЛ,
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ 100

1.1. Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар
хянан шийдвэрлүүлэх ажиллагааны ойлголт,
мөн чанар, хууль зүйн учир холбогдол 100

1.2. Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар
хянан шийдвэрлүүлэх ажиллагааны эрх зүйн
зохицуулалтын уламжлал, шинэчлэл 104

1.2.1. Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар
хянан шийдвэрлүүлэх ажиллагааны эрх зүйн
зохицуулалтыг Эрүүгийн байцаан шийтгэх
хуульд тусгасан нь 105

1.2.2. Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар
хянан шийдвэрлүүлэх ажиллагааны талаарх
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
тогтоомжийн шинэчлэл, өнөөгийн байдал 111

1.2.3. Эрүүгийн хуулиудад тусгасан эрүүгийн
хэргийг хялбаршуулсан журмаар хянан
шийдвэрлэх ажиллагааны зохицуулалтын
харьцуулалт 118

ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ	121
2.1. Монгол Улс дахь эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн тоон мэдээллийн статистикийн дүн шинжилгээ	121
2.2. Хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлсэн яллагдагчийн хувийн байдлын шинжилгээ	127
2.3. Прокурор, шүүхээс хэргийг нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаасан байдал	132
2.4. Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж байгаа хугацаанд хийсэн дүн шинжилгээ	134
2.5. Шүүх хуралдаанд шүүгдэгч, хохирогч, хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн оролцоо	135
2.6. Гэмт хэрэг үйлдсэнийг тогтоосон нотлох баримтын дүн шинжилгээ	137
2.7. Оногдуулсан ял, албадлагын арга хэмжээ хэрэглэсэн байдлын шинжилгээ	138
2.8. Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд учирч буй хүндрэл бэрхшээл ...	146
ГУРАВ. ЭРХ ЗҮЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА	149
3.1. Английн эрүүгийн процесс	150
3.2. Америкийн эрүүгийн процесс	153
3.3. Францын эрүүгийн процесс	155
3.4. Оросын эрүүгийн процесс	156
3.5. Хятадын эрүүгийн процесс	159
3.6. Өмнөд Солонгосын эрүүгийн процесс	161

ДҮГНЭЛТ, САНАЛ	164
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	170
ХАВСРАЛТ	174

ХҮСНЭГТ, ГРАФИК, ЖИШЭЭ, ХАВСРАЛТ

ХҮСНЭГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	ЭБШтХ-ийн 25 дугаар зүйлийн 1 болон 415 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтууд	109
Хүснэгт 2.	2008-2014 онд эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шүүхээр хянан шийдвэрлэсэн байдал	110
Хүснэгт 3.	Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлд заасныг үндэслэн ял оногдуулах зохицуулалт	112
Хүснэгт 4.	ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэрэг	115

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1.	ЭХХЖ-аар хянан шийдвэрлэгдсэн хэргийг анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэгтэй харьцуулсан байдал	94
График 2.	ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэргийг шүүхээс дангаар болон бүрэлдэхүүнтэй шийдвэрлэсэн хэрэгтэй харьцуулсан байдал	94
График 3.	ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэргийн ангиллын харьцуулалт	95
График 4.	ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэрэг (нутаг дэвсгэрийн шүүхээр)	96

График 5.	Давж заалдах шатны шүүж болон ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх хэрэгтэй холбогдуулан гаргасан гомдол, эсэргүүцлийн харьцуулалт	97
График 6.	Давж заалдах шатны шүүхийн шийдвэрт гаргасан гомдол, эсэргүүцэл (нутаг дэвсгэрийн шүүхээр)	98
График 7.	Хяналтын шатны шүүхийн нийт шийдвэрт ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэргийн эзлэх хувь	99
График 8.	2020 онд ЭХХЖ-аар хянан шийдвэрлэгдсэн хэргийн тоо	121
График 9.	2008 оноос хойш шүүхээр шийдсэн хэрэг болон ЭХХЖ-аар хянан шийдвэрлэгдсэн хэргийн харьцуулалт	122
График 10.	ЭХХЖ-аар хянан шийдвэрлэгдсэн хэргийн зүйлчлэлийн харьцуулалт	123
График 11.	Давж заалдах шатны шүүхийн шийдвэрт гаргасан гомдол, эсэргүүцэл	124
График 12.	Анхан шатны шүүхийн шийдвэрт гаргасан гомдол, эсэргүүцлийг давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн байдал	125
График 13.	Хяналтын шатны шүүхэд гаргасан прокурорын эсэргүүцэл, шүүгдэгч, түүний өмгөөлөгчөөс гаргасан гомдлыг шийдвэрлэсэн байдал	126
График 14.	Анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхүүдэд ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэрэгтэй холбогдуулан гаргасан гомдол, эсэргүүцэл	126

График 15.	Шүүхээр 2020 онд шийдвэрлэсэн хэрэгт давж заалдах болон хяналтын шатны шүүхэд гаргасан гомдол, эсэргүүцлийг ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэргийн гомдол, эсэргүүцэлтэй харьцуулсан байдал	127
График 16.	Сонгон судалсан хэргийг үйлдсэн этгээдүүдийн иргэний харьяаллын байдал	128
График 17.	Сонгон судалсан хэргийг үйлдсэн этгээдүүдийн хүйсийн байдал	128
График 18.	Сонгон судалсан хэргийг үйлдсэн этгээдүүдийн насны байдал	129
График 19.	Сонгон судалсан хэргийг үйлдсэн этгээдүүдийн боловсролын байдал	129
График 20.	Сонгон судалсан хэргийг үйлдсэн этгээдүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал	130
График 21.	Сонгон судалсан хэргийг үйлдсэн этгээдүүд ял эдэлж байсан эсэх	130
График 22.	Сонгон судалсан хэргийг үйлдэх үед согтууруулах ундаа хэрэглэсэн эсэх	131
График 23.	Нотлох баримт дутуу гэх үндэслэлээр буцаасан тухай шүүгчийн шийдвэрт гаргасан гомдол, эсэргүүцэл	133
График 24.	ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн хугацаа	134
График 25.	ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэргийг эрүүгийн хэрэг үүсгэснээс хойш шийдвэрлэсэн байдал	135
График 26.	ЭХХЖ-аар хянан шийдвэрлэгдсэн хэргийн шүүх хуралдаан дахь оролцоо (хот болон орон нутгаар)	136



График 27.	ЭХХЖ-аар хянан шийдвэрлэгдсэн хэргийн нотлох баримтын үнэлгээ	138
График 28.	ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэрэгт оногдуулсан ял, албадлагын арга хэмжээ	139
График 29.	ЭХХЖ-аар шийдвэрлэсэн хэрэгт торгох ял оногдуулсан байдал	140
График 30.	ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэрэгт эрх хасах ял (нэмэгдлээр) оногдуулсан байдал	140
График 31.	ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэрэгт хорих ял оногдуулсан байдал	141
График 32.	ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэрэгт тэнсэх арга хэмжээ оногдуулсан байдал	141
График 33.	ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэрэгт үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах арга хэмжээ авсан байдал	142
График 34.	ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэрэгт прокурортой тохиролцон шүүхээс ял оногдуулсан эсэх	143

СУДАЛГААНД АВЧ ҮЗСЭН ЖИШЭЭ

Жишээ 1.	Өмнөговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн Б.Э-д холбогдох эрүүгийн 029000320048 дугаартай хэрэг	132
Жишээ 2.	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн шүүгдэгч Х.Б-д холбогдох эрүүгийн 2006 00000 2244 дугаартай хэрэг	136



Жишээ 3.	Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн шүүгдэгч Х.Б-д холбогдох эрүүгийн 2035000000158 дугаартай хэрэг	143
Жишээ 4.	Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн шүүгдэгч Х.Б-д холбогдох эрүүгийн 2035000000158 дугаартай хэрэг	144
Жишээ 5	Улсын Дээд шүүхээр шийдвэрлэгдсэн шүүгдэгч Г.Е-д холбогдох эрүүгийн 2009008250431 дугаартай хэрэг	145
Жишээ 6.	Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн 1902000000344 дугаартай хэрэг	146
Жишээ 7.	Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн 1902000000201 дугаартай хэргийн талаар. Сүхбаатар аймаг дахь Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэгдсэн Б.С-д холбогдох хэрэг	146
Жишээ 8.	Сүхбаатар аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Б.С-д холбогдох хэрэг	148

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1.	Анхан шатны шүүхээс хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн ерөнхий судалгаа	174
-------------	---	-----

Хавсралт 2.	Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэрэгтэй холбогдуулан эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн хэргийн өнгөөр хийсэн судалгаа	178
Хавсралт 3.	Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэрэгтэй холбогдуулан эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн хэргийн судалгаа	180
Хавсралт 4.	Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэрэгтэй холбогдуулан эрүүгийн хэргийн хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн хэргийн дэлгэрэнгүй судалгаа	181

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн нэгдсэн улс
СДШ	Сум дундын шүүх
СДЭХАШШ	Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
ҮСГ	Үндэсний статистикийн газар
ЦБ	Цагдаагийн байгууллага
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ЭБШТХ	Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль
ЭПХ	Эрүүгийн процессын хууль
ЭХАШШ	Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
ЭХТА	Эрүүгийн хуулийн тусгай анги
ЭХҮ	Эрүүгийн хэрэг үүсгэх
ЭХХЖ	Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журам
ЭХХША	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ЭХХЖХША	Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа

УДИРТГАЛ

Судалгааны үндэслэл

Нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн бөгөөд төрөөс нийгмийн дэг журмыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх бодлогыг тодорхойлон, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, сайжруулах талаар олон талт арга хэмжээ хэрэгжүүлж байна. Үүний нэг тод жишээ нь Эрүүгийн багц хуулийн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиуд хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн явдал билээ.

Шинээр хэрэгжиж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (цаашид ЭХХШтХ гэх)-ийн зорилго нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх¹ явдал юм. Уг хууль нь өмнө мөрдөгдөж байсан Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль (цаашид ЭБШтХ гэх)-аас хэлбэр, агуулга, зарчмын хувьд ихээхэн өөрчлөгдсөн. Тухайлбал, ЭБШтХ-ийн 48 дугаар бүлэг болох “Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”-ны эрх зүйн

¹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.1 дүгээр зүйл, 2017.

зохицуулалтыг ЭХХШтХ-д илүү боловсронгуй болгож оруулсан. Эрүүгийн хуулийн тусгай анги (ЭХТА)-д дээд тал нь найман жилийн хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн бөгөөд гэм буруугаа хүлээн зөвшөөрч, хохирлоо нөхөн төлсөн эсхүл нөхөн төлөхөө илэрхийлсэн яллагдагч хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх тухай хүсэлт гарган, шийдвэрлүүлэхээр хуульчилжээ.

Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа (цаашид ЭХХЖХША гэх) нь цаг хугацаа, зардал хэмнэх төдийгүй хэргийг бүхий л үе шатанд хялбаршуулсан байдлаар, чирэгдэл багатай шийдвэрлэх давуу талтай ч өнөөгийн практикт төдий л бүрэн дүүрэн ач холбогдолтой байж чадахгүй байна гэж судлаачдын зүгээс дүгнэж байна. Иймд шүүхээс хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэж буй нөхцөл байдлыг авч судлан амьдралд хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлийг илрүүлэн, хууль эрх зүйн орчныг илүү нарийвчлан боловсронгуй болгох, ЭХХЖХША-г хэрэгжүүлэгчдийн мэдлэг, мэргэшлийн ур чадвар, хандлагыг шинэтгэх шаардлагатай байгаа юм.

Энэхүү судалгааны ач холбогдол нь шүүхээр шийдвэрлэгдсэн тодорхой эрүүгийн хэргийн хүрээнд ЭХХШтХ-д заасан эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эрх зүйн зохицуулалтыг нэг мөр ойлгон хэрэглэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийн, хэрэг шийдвэрлэх явцад хууль ёсны эрх, ашгийг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чиглэсэн санал дэвшүүлэхэд оршино.

Судалгааны зорилго, зорилтууд

Уг судалгааны хүрээнд шүүхээс Эрүүгийн хуулийн хялбаршуулсан журам (ЭХХЖ)-аар хянан шийдвэрлэхэд

хуулийг хэрхэн хэрэглэж байгаа талаарх онол ба хууль хэрэглээний холбоо хамаарлыг судлах, шүүхийн шийдвэрийн шийдэл ба үндэслэлд үнэлэлт, дүгнэлт өгч, хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд учирч буй бэрхшээл, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар үндэслэл бүхий дүгнэлт гаргах зорилго дэвшүүлж ажиллалаа.

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллав. Үүнд:

- Монгол Улс дахь гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн тоон мэдээлэлд статистикийн боловсруулалт хийх;
- Хялбаршуулсан журмаар хэргээ хянан шийдвэрлүүлсэн яллагдагчийн хувийн байдалд шинжилгээ хийх;
- Оногдуулсан ял, шийтгэлд дүн шинжилгээ хийх;
- Прокурор, шүүхээс нэмэлт ажиллагаа хийхээр буцаасан хэрэгт дүн шинжилгээ хийх;
- Хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж байгаа хугацаанд дүн шинжилгээ хийх;
- Шүүх хуралдаанд оролцож байгаа шүүгдэгч, хохирогч, хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн байдалд дүн шинжилгээ хийх;
- Гэмт хэрэг үйлдсэнийг тогтоосон нотлох баримтад дүн шинжилгээ хийх;
- Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд учирч буй хүндрэл бэрхшээлд дүн шинжилгээ хийх.

Судалгааны хүрээ, арга зүй

1. Тоон судалгаа

Судалгааны хүрээнд эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн нөхцөл байдлыг тодруулах, түүнд дүн шинжилгээ хийхийн тулд Үндэсний статистикийн газар (цаашид ҮСГ гэх), Цагдаагийн ерөнхий газар (цаашид ЦЕГ гэх), Шүүхийн ерөнхий зөвлөл (цаашид ШЕЗ гэх)-өөс гаргадаг албан ёсны тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийв.

Судалж буй хэргийн цагдаа, шүүхийн захиргааны байгууллага, shuuh.mn сайтын тоо, мэдээ, статистик зөрүүтэй гардаг тул тухайн байгаа тоон мэдээг засварлахгүйгээр авч дүгнэлт хийлээ.

2. Чанарын судалгаа


ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэрийн шинжилгээ

ЭХХШТХ-д 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтад өөрчлөлт орж, 2020 оны 2 дугаар сарын 24²-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилсэн тул энэ өдрөөс хойших ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэргүүдийг сонгон судалсан болно. Сонгон судалсан хугацаанд 9,962³ хэргийг анхан шатны шүүхээр шийдвэрлэсний дотор 3,470 хэрэг нь ЭХХЖ-аар хянан

² 2020 оны Улсын Их Хурлын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 5 дугаар зүйлд заасны дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль нь 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 1109 дугаартай "Төрийн мэдээлэл" сэтгүүлд хэвлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа шийдвэрлэгдсэн хэргүүдийг судлав.

³ Монгол Улсын шүүхийн цахим шийдвэрийн сан shuuh.mn сайт. <https://shuukh.mn/cases/2/1>

шийдвэрлэгджээ. Судалгааны ажлын зорилгын хүрээнд тухайн хугацаанд анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн нийт 189 хэргийн буюу таван хувьтай (Хавсралт 1) тэнцэх хэмжээний шийтгэх тогтоолыг санамсаргүй түүврийн аргаар сонгон, урьдчилан боловсруулсан асуумжийн хүрээнд дүн шинжилгээ хийх аргаар судаллаа. Судалгааны үр дүнг дараах графикуудад харуулав.



Графикаас харахад сонгон судалсан хугацаанд нийт шийдвэрлэсэн хэргийн 34.8 хувийг ЭХХЖ-аар хянан шийдвэрлэжээ.




Сонгон судалсан ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн 188 хэргийг шүүгч дангаар, нэг хэргийг бүрэлдэхүүнтэй шийдвэрлэсэн байна.



Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хөнгөн хэрэг 187, хүнд хэрэг хоёр байна.

График 4. ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэрэг (нутаг дэвсгэрийн шүүхээр)




- Хялбаршуулсан журмаар шийдсэн хэрэг, хувиар (2020.02.23-12.31)
- Нийт шийдсэн хэрэг, хувиар (2020.02.23-12.31)

ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх давж заалдах шатны шүүхийн шийдвэрт хийсэн судалгаа

Сонгон судалсан хугацаанд эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхэд ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн 116⁴ хэргийн магадлал байгаагаас 22 хэргийн магадлал нь уг журмаар хянан шийдвэрлэхтэй хамааралгүй, гурван хэрэг нь давхацсан байдлаар орсон тул 91 хэрэгтэй холбогдуулан гаргасан магадлалтай (Хавсралт 3-ыг харна уу) танилцан судлав.

ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэргүүдтэй холбогдуулан гаргасан гомдол, эсэргүүцлийн байдлыг дараах графикуудад харуулав.



Сонгон судалсан хугацаанд нийт 2031 хэрэгт гомдол, эсэргүүцэл гарснаас 91-ийг нь ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэрэгтэй холбогдуулан гаргасан байна.

⁴ Монгол Улсын Шүүхийн цахим шийдвэрийн сан shuuh.mn сайт <https://shuukh.mn/cases/2/2>

График 6. Давж заалдах шатны шүүхийн шийдвэрт гаргасан гомдол, эсэргүүцэл (нутаг дэвсгэрийн шүүхээр)




Аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхэд ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн 22 хэрэгт, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхэд ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн 69 хэрэгт гомдол, эсэргүүцэл гаргасан байна.

ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хяналтын шатны шүүхийн шийдвэрийн судалгаа

Сонгон судалсан хугацаанд эрүүгийн хэргийн хяналтын заалдах шатны шүүхээр ЭХХЖ-аар хянан шийдвэрлэгдсэн 13⁵ хэргээс таван хэргийн магадлал хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэрэгтэй хамааралгүй байсан тул найман хэргийн тогтоолтой (Хавсралт 4-ийг харна уу) танилцан судалгаа хийв. Хяналтын шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдээс хэд нь ЭХХЖ-аар хянан шийдвэрлэгдсэнийг дараах графикаас харна уу?

⁵ Монгол Улсын Шүүхийн цахим шийдвэрийн сан shuuh.mn сайт <https://shuukh.mn/cases/2/3>

График 7. Хяналтын шатны шүүхийн нийт шийдвэрт ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэргийн эзлэх хувь



Сонгон судалсан хугацаанд Хяналтын шатны шүүхэд нийт 568 гомдол, эсэргүүцэл гарснаас ЭХХЖ-аар хянан шийдвэрлэгдсэн найман хэрэг байсан байна.

Сэдвийн судлагдсан байдал

ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагаа эрүүгийн процессын салбарт хожуу буюу 2007 оны нэмэлт өөрчлөлтөөр хуульчлагдсан тул дагнасан нэг сэдэвт бүтээл гараагүй, эрүүгийн процессын эрх зүйн хүрээнд л ерөнхийлөн судлагджээ. Түүнчлэн цөөн тооны судлаач болон магистрант эрдэм шинжилгээний ажил хийсэн байх бөгөөд Монголын хуульчдын холбооны Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих хороо, Улсын ерөнхий прокурорын газар, МУИС-ийн Хууль зүйн сургууль хамтран “Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт онол-практикийн хэлэлцүүлгийг⁶ 2019 онд зохион байгуулсан байна.

⁶ Хэлэлцүүлгийн талаар мэдээ, МХХ-ны цахим хуудас, <https://mglbar.mn/news/3311>

НЭГ. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ОЙЛГОЛТ, ХУУЛЬ ЗҮЙН УЧИР ХОЛБОГДОЛ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ

1.1. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ОЙЛГОЛТ, МӨН ЧАНАР, ХУУЛЬ ЗҮЙН УЧИР ХОЛБОГДОЛ

Эрх зүйт төрийг төлөвшүүлэхэд зайлшгүй хийх алхам нь нийгмийн харилцааг захиргааны хэм хэмжээ тогтоосон актаар бус, хуулиар зохицуулдаг болох явдал гэж эрх зүйн онолд үздэг. Материаллаг хуулийн хэм хэмжээгээр тодорхойлогдсон агуулгыг хэзээ, хаана, яаж (ямар арга, хэлбэрээр) хийж гүйцэтгэхийг гагцхүү процессын хэм хэмжээгээр л журамлан, тохируулах боломжтой.

Эрүүгийн процессын хууль тогтоомж нь нэгэнт үйлдэгдсэн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулан нотлогдвол зохих байдлыг тогтоон шүүхээр хянан шийдвэрлэх, хууль ёсны, бодит үндэслэлтэй шийтгэх тогтоол гаргах замаар Эрүүгийн хуулийг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх бүхий л нөхцөл, баталгааг бий болгоход чиглэгдсэн билээ. Энэ ч утгаар эрүүгийн процессын хууль тогтоомж нь мөрдөн шалгах ажиллагааны хэм хэмжээг чанд сахих замаар гэмт хэргийг илрүүлэх, гэм буруутай этгээдэд эрүүгийн зохих хариуцлага хүлээлгэн учирсан хохирлыг нөхөн төлүүлж төр, хуулийн этгээд, иргэнийг

гэмт халдлагаас хамгаалж чадахуйц процесс ажиллагааны журам (тогтолцоо)-ыг тогтоон мөрдөхөд зориулагддаг төдийгүй хууль бусаар эрүүгийн хариуцлагад татах, хилсээр ял шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэн, үндэслэлгүйгээр мөрдөгдөж шийтгүүлсэн хэнийг ч болов цагаатгах явдлыг хангах үүрэгтэй юм.

Улс төр, нийгэм, эдийн засгийн тогтолцоо, нийгмийн харилцаа, оюун санаанд гарч буй хувьсал өөрчлөлт, хөгжил дэвшлийн үйл явцтай уялдаад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт, чиг үүрэг өөрчлөгдсөөр⁷ ирсэн.

ЭХХШ гэх ажиллагаа нь ихээхэн хүч, хөдөлмөр, хөрөнгө зардал шаарддаг ажиллагаа бөгөөд гадаад улсад, тодруулбал, хүнд гэгдэх ангиллын “дундаж” нэг хэргийг шалган шийдвэрлэхэд Англид 80 мянга орчим фунт, Канадад 250 мянган канад доллар зарцуулдаг. Харин манай улсад судалгааны түвшинд хийгдээгүй ч Авлигатай тэмцэх байгууллагын 2017 оны тайлангийн хуралдаанд Олон нийтийн зөвлөлийн дарга нь “тус байгууллага шүүхэд шилжүүлсэн нэг хэрэгт дунджаар 280 сая төгрөг зарцуулсан байна” хэмээн шүүмжилсэн нь хэдийгээр албан бус статистик ч манай улсад анхны “үнэлгээт нэхэмжлэл” юм⁸.

XXI зуунд олон улсын хэмжээнд төрийн тогтолцоо, иргэний харьяаллыг үл харгалзан иргэншил, соёл, мэдээлэл, эдийн засаг, санхүү, хуулийн бодлого, иргэний нийгэм, ялангуяа эрх зүй улам бүр дэлхий нийтийн шинжтэй болж, тэр утгаараа Монгол Улс ч олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орж үндэсний хууль тогтоомжоо тэдгээрт нийцүүлэх шаардлагатай болж

⁷ Ж.Болдбаатар нар, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, УБ., 2020, 12 дахь тал.

⁸ Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан, Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал, УБ., 2018, 70 дахь тал.

байна. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.⁹ Энэ нь олон улсын эрүүгийн процесс үндэсний эрүүгийн процесст шингэж, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, ялангуяа эрүүгийн процессын түргэн шуурхай, үр нөлөөтэй ажиллагааг өөрийн орны эрүүгийн процессын онцлогт нийцүүлэн нутагшуулахыг шаардаж байна.

Олон улсын жишигт гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа этгээд нь үйлдсэн гэмт хэргээ сайн дураараа илчлэн ирсэн, нөгөө талаар сэжигтэн, хохирогчтой эвлэрч, хохирлыг сайн дураараа барагдуулж, гэм буруугаа хүлээвэл эрүүгийн хариуцлагын онцлог эсхүл гэмт хэргийн ангилал үл харгалзан шүүхийн шатанд шийдвэрлэхдээ тухайн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлэн **хуульд зааснаас хөнгөн ял оногдуулах** механизм бүрдүүлсэн байдаг. Энэ нь иргэдийн хууль ёсны ашиг сонирхлыг төрөөс хамгаалж байгаагийн нэг илрэл бөгөөд эрүүгийн процессын зардлыг хэмнэн, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (ЭХХША)-г түргэн шуурхай болгож байгаа явдал юм.

Манай улсын практикт гэмт хэрэг нэг бүрийг тухайн эрүүгийн хэрэгт нотлогдвол зохих байдлыг тогтоон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг яллах, цагаатгах болон эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох талаар байцаан шийтгэх тодорхой ажиллагаа нэг бүрийг ЭХХШтХ-д заасан үндэслэл, журмын дагуу явуулдаг байсан нь зарим талаар хэт их цаг хугацаа болон хөрөнгө хүч зарсан ажиллагаа болдог байна.

ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагааны гол зорилго нь:

⁹ Үндсэн хууль, 10 дугаар зүйл, 3 дахь хэсэг.

- Эрүүгийн процесс ажиллагааны зардлыг хэмнэх, хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын ажлын ачааллыг бууруулах;
- Гэмт хэрэг үйлдсэн хүн гэм буруугаа хүлээн зөвшөөрснөөр төрийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлогын энэрэнгүй хандлагыг мэдрэх;
- Хохирлоо нөхөн төлөх, хор уршгаа арилгах зэрэг “зөөллөх” алхмуудыг дэмжих замаар нийгмийн амьдралын сөрөг уур амьсгалыг намжаах;
- Эрүүгийн процессын ажиллагааг хэрэгжүүлэгчдийн хүнд суртал, дарамтаас ангижрах;
- ЭХХША-г шуурхай, хялбар, энгийн ойлгомжтой, хүртээмж хүрэлцээтэй болгосноор гэмт хэрэгт холбогдсон хүн ажиллах, суралцах, хөдөлмөрлөх бололцоог нээх.

Энэ ч утгаар хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох болон ЭХХША-нд мэтгэлцэх зарчмуудын ололттой талыг улам бүр баталгаажуулан сөрөг үр дагаврыг саармагжуулж, эрүүгийн процессын хуулийг шинэтгэн боловсронгуй болгох шаардлага тавигдаж байна.

Иймээс ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагааны олон улсын жишиг хандлага нь дараах онцлогтой байна. Үүнд:

- Хуульд зааснаар тодорхой төрлийн эсхүл ангиллын эсхүл хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл (оногдуулах ялаас)-өөс шалтгаалан ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагаа явагдах;
- Яллагдагч, шүүгдэгч үйлдсэн хэрэгтээ чин сэтгэлээсээ гэмшин гэм буруугаа хүлээн зөвшөөрч, өөрийн хүсэл зоригоор ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах хүсэлт гаргасан байх;

- Эрүүгийн хэрэгт нотлогдвол зохих байдал (хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох зарчим)-ыг бүрэн тогтоохыг шаарддаггүй. Өөрөөр хэлбэл, мөрдөгч яллах, цагаатгах болон эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх бүхий л нотлох баримтыг цуглуулах үүрэг хүлээхгүй;
- ЭХХША-ны нийтлэг хугацаанаас богино хугацаанд явагддаг;
- Гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо нөхөн төлсөн эсхүл нөхөн төлөхөө илэрхийлсэн байхыг яллагдагч, шүүгдэгчээс шаарддаг;
- Хүлээлгэх эрүүгийн хариуцлага, тэр дундаа ял тохиролцох;
- Гэмт хэрэгтэй тэмцэх, тэр дундаа таслан зогсоох, илрүүлэхэд хэргийн холбогдогчтой амлалтад хүрч ялыг хөнгөрүүлэх, чөлөөлөх.

1.2. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ

Монгол Улсын Үндсэн хууль нь эрх зүйт төрийн ёс, ардчиллын зарчмаар тодорхойлогдсон бөгөөд түүний агуулга, мөн чанарыг эрүүгийн бодлого нь илэрхийлэн эрх зүйт төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Монгол улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 19 дүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц, эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө төр хариуцна” гэсэн тулгуур заалт нь төрийн эрүүгийн бодлогын (*kriminalpolitik*)

үндсэн агуулга юм. Эрүүгийн бодлого нь төрийн бодлогод эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, нийгмийн үйл явцад нөлөөлөх аргаараа бусад салбарын бодлогоос өвөрмөц онцлогтойгоос гадна Эрүүгийн эрх зүйн, Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн, Шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүйн, Криминологийн гэсэн хэд хэдэн чиглэлийн тусгай бодлогыг өөртөө багтаадаг.

Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан нь гэмт явдалтай тэмцэх талаар төрийн эрүүгийн бодлогыг хэрэгжүүлэх, эрүүгийн хуулийн үр нөлөөг дээшлүүлэх зорилтыг хангахад үйлчилдгийн нэгэн адил Эрүүгийн хууль тогтоомжийг батлан гаргах явдал нь чухал төдийгүй түүнийг нийгмийн амьдралд хэрэгжүүлэх, ялангуяа амьдралын хөрсөнд буун нийцэж байж хэрэгжих, хүний эрх чөлөөг хамгаалах баталгаа нь болдог.

1.2.1. Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгасан нь

Монголын эрх зүйн хөгжил нь эх газрын эрх зүйн тогтолцоог баримжаалж хөгжсөн ч XXI зуунд Англи-Саксоны эрх зүйн үнэт зүйлсийг нутагшуулах (рецепци), эрх зүйн конвергенц хийхдээ өөрийн орны өвөрмөц онцлогийг тусгах, уламжлалт эрх зүйн онцлогт нийцүүлэх гэсэн оролдлогоос шалтгаалан эрх зүйн онолын болон шинжлэх ухааны үндэслэл, судалгаагүйгээс 2002 оны ЭБШТХ-д алдаатай, хэрэгждэггүй зүйл, заалт, хэсгүүд хуульчлагдсан байна. Тухайлбал, ЭХХЖ-аар хянан шийдвэрлэгдэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт 2002 оны ЭБШТХ анх батлагдахад хуульчлагдаагүй бөгөөд Улсын Их Хурлаас 2007 оны 8 дугаар сарын 9-ний өдөр Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар “Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэсэн 48 дугаар бүлгийг шинээр нэмж 414-418 дугаар зүйлээр уг ажиллагааны нөхцөл, журмыг анх удаа хуульчилсан.

Хууль тогтоогчид эрүүгийн процессын энэхүү шинэлэг зохицуулалтыг ЭБШТХ-д оруулахдаа Англи, Америк зэрэг улсад түгээмэл хэрэглэгддэг ял тохиролцох болон түргэвчилсэн ажиллагааны зарим нөхцөл, зарчмыг тусгахыг эрмэлзсэн боловч Франц, ОХУ-ын Эрүүгийн процессын тусгай журмаар хэрэгжүүлэх түргэвчилсэн ажиллагааны жишгийг илүү харгалзан үзэж маш хязгаарлагдмал хүрээнд цөөн тооны хөнгөн хэргийг нэр заан, явцуу байдлаар хуульчилсан. Тодруулбал, Эрүүгийн хуульд заасан 65 зүйл, ангиар хуульчилсан хөнгөн хэргээс дараах 41 хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж байхаар тогтоосон боловч энэхүү журмыг сонгосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дээрдүүлэх буюу ялаас чөлөөлөх, хөнгөн ял оногдуулах механизмыг 2002 оны Эрүүгийн хуульд тусгаагүй байна.

2002 оны Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлийн 17.2. “Энэ хуулийн тусгай ангид нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэхээр заасан гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэнэ” хэмээн тодорхойлсон бөгөөд үүнд дараах зүйл анги хамаарч байв. Үүнд: 99.1 (Бусдын бие мах бодид хөнгөн гэмтэл санаатай учруулах), 103.1 (Бэлгийн замын халдварт өвчнөө эмчлүүлэхээс зайлсхийх, халдаах), 110 (Доромжлох), 111.1 (Гүтгэх), 118 (Асран хамгаалах үүргээ урвуулах), 120¹ (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх), 123.1 (Садар самууныг сурталчлах), 130.1 (Иргэн сонгуулийн эрхээ эдлэхэд болон сонгуулийн хорооны ажилд саад хийх), 132 (Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг зөрчих), 135.1 (Иргэний захидал, харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчих), 137.1 (Иргэний орон байрны халдашгүй байдлыг зөрчих), 139.1 (Сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийх), 142 (Хүний шашин шүтэх, эс шүтэх эрхийг зөрчих), 143 (Шүтэж байгаа шашнаар

нь хүнийг ялгаварлан гадуурхах, мөрдөн мөшгөх), 145.1 (Бусдын эд хөрөнгийг хулгайлах), 151 (Алдуул мал, гээгдэл буюу санамсаргүй олдсон эд хөрөнгө завших), 152 (Хадгалуулсан буюу бусад зорилгоор итгэмжлэн өгсөн бусдын эд хөрөнгө завших), 155.1 (Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах), 187.1 (Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг хамгаалах үүрэгт ажилдаа хайнга хандах), 197.1 (Хууль бусаар эмчлэх), 201.1 (Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах), 215.1 (Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих), 216.1 (Зам тээврийн осол гарсан газрыг санаатай орхих), 220.1 (Бүрэн биш тээврийн хэрэгслийг ажилд гаргах, жолоодох эрхгүй хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулах), 222.1 (Жолоогоо бусдад шилжүүлэх), 223.1 (Авто тээврийн хэрэгслийг авч зугтаах), 230.1 (Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх), 231.1 (Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг доромжлох), 233.1 (Хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах), 234.1 (Баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягтыг хулгайлах, устгах, гэмтээх, нуух), 236 (Дураараа аашлах), 239 (Төрийн дайчилгаанаас зайлсхийх), 243.1 (Мөрийтэй тоглох), 244 (Битүүмжилсэн эд зүйлийг дур мэдэн зарцуулах), 245.1 (Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанд саад учруулах), 255 (Гэрч, хохирогч, мэдүүлэг өгөхөөс, шинжээч дүгнэлт гаргахаас татгалзах, зайлсхийх), 259 (Шүүгч, иргэдийн төлөөлөгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийг гүтгэх), 275.1 (Захирагчийн тушаал биелүүлэхгүй байх), 277.1 (Захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх), 278.1 (Бие биедээ захирагдахгүй цэргийн алба хаагчид харилцахдаа дүрмийн заалт зөрчих), 284.1 (Байлдааны машин жолоодох болон ашиглалтын журам зөрчих зэрэг хэрэг хамаарч байв.



2007 оны 8 дугаар сарын 9-ний өдөр ЭБШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах хуулиар хялбаршуулсан замаар шийдвэрлэх хэрэг дараах онцлогтой байсан. Үүнд:

- Хуулиар харьяалуулсан хөнгөн гэмт хэрэг байх;
- Гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, хохирогч харилцан зөвшөөрч, хүсэлт гаргасан;
- Сэжигтэн, яллагдагч гэмт хэрэг үйлдсэнээ хүлээн зөвшөөрсөн;
- Хохирогч хохирлын талаар маргаангүй;
- Насанд хүрээгүй этгээдэд холбогдох хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэдэггүй;
- Прокурорын санал болгосон ялыг хүлээн зөвшөөрсөн байх.

Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн үндэслэлийг 2002 оны ЭБШТХ-ийн 48 дугаар бүлэгт шинээр оруулахдаа ЭБШТХ-ийн 25 дугаар зүйлийн зохицуулалтыг хэвээр үлдээсэн нь зарим талаар хоёрдмол шинжтэй процедур бий болгон хууль хэрэглээний хувьд хүндрэлтэй буюу нэг мөр, шууд хэрэглэх боломжийг хязгаарласан.

Зарим судлаач 2002 оны Эрүүгийн хуульд заасан тодорхой төрлийн гэмт хэрэгт хариуцлагаас чөлөөлөх үндэслэлийг ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагаатай адилтган ойлгож дүгнэсэнтэй санал нийлэх боломжгүй юм. Тухайлбал, ЭБШ хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу хэрэг бүртгэлтийн шатанд прокурорын шийдвэрээр хэрэгсэхгүй болгосныг цагдаа, прокурорын статистикт эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн гэж дүгнэж байсан байна.

Хүснэгт 1. ЭБШтХ-ийн 25 дугаар зүйлийн 1 болон
415 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтууд

<p>ЭБШтХ-ийн 25 дугаар зүйл. Хохирогч нь яллагдагч, шүүгдэгчтэй эвлэрснээр хэргийг хэрэгсэхгүй болгох</p>	<p>ЭБШХ-ийн 415 дугаар зүйл. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ерөнхий нөхцөл</p>
<p>25.1. Яллагдагч, шүүгдэгч нь Эрүүгийн хуульд заасан хөнгөн гэмт хэргийг анх удаа үйлдсэн бөгөөд учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгасан нөхцөлд хохирогч нь яллагдагч, шүүгдэгчтэй сайн дураараа эвлэрсэн бол хэргийг хэрэгсэхгүй болгоно.</p>	<p>415.2. Энэ хуулийн 414.1-д заасан гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, хохирогч харилцан зөвшөөрч, хүсэлт гаргасан бөгөөд сэжигтэн, яллагдагч гэмт хэрэг үйлдсэнээ хүлээн зөвшөөрсөн, хохирогч хохирлын талаар маргаангүй бол хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх бөгөөд хэрэг бүртгэх ажиллагааг эрүүгийн хэрэг үүсгэснээс хойш нэн даруй гүйцэтгэнэ.</p>

Харин доорх шүүхийн статистикаас харахад энэхүү хялбаршуулсан журам нь амьдралд нийцээгүй, иргэдийн эрх зүйн мэдлэг дутмаг, өмгөөлөгчдийн үйлчилгээ хангалтгүйгээс жил бүр тогтмол буурч байжээ.



*Хүснэгт 2. 2008-2014 онд эрүүгийн хэргийг хялбаршуулсан
журмаар шүүхээр хянан шийдвэрлэсэн байдал¹⁰*

Он	Нийт эрүүгийн хэрэг	ЭХХЖ-аар шийдвэрлэсэн хэрэг	
		Хэрэг	Хүн
2008	5812	30	30
2009	5407	18	18
2010	5460	17	17
2011	5877	2	2
2012	6161	5	5
2013	6169	4	4
2014	6375	2	2

Статистикаас дүгнэвэл 2008-2014 онд ЭБШТХ-д заасан ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг сонгосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дээрдүүлэх буюу ялаас чөлөөлөх, хөнгөрүүлэх үндэслэлийг материаллаг хууль болох Эрүүгийн хуульд тусгаагүйгээс олон улсын жишиг хялбаршуулсан журам байгаагүй гэж дүгнэж болохоор байна.

Монгол Улсын Эрүүгийн хуульд тодорхойлсноор хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдэн, учруулсан хохирлоо сайн дураараа барагдуулсан бол зохих байгууллага албан тушаалтанд мэдэгдсэн эсхүл хохирогчтой сайн дураараа эвлэрсэн тохиолдлуудад эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх бөгөөд энэ үндэслэл ч ЭБШТХ-д баталгаажсан байсан. Эндээс дүгнэхэд

¹⁰ Шүүхийн ерөнхий зөвлөлийн Судалгааны хүрээлэнгийн тайлан 2008-2014 он, Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шүүхээр шийдвэрлэсэн байдал.

хялбаршуулсан журам нь дээрх тохиолдлуудад хамаарахгүй бөгөөд шүүхээр эрүүгийн хэргийг эцэслэн эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмын хэрэгжилтийг хангах агуулгатай байна.

2015 оны Эрүүгийн болон 2017 оны ЭХХШТХ-д эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх дээрх үндэслэл, журмууд хуульчлагдаагүй билээ.

1.2.2. Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх ажиллагааны талаарх ЭХХШТХ тогтоомжийн шинэчлэл, өнөөгийн байдал

Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх зохицуулалтыг анх удаа 2015 онд Эрүүгийн хуульд баталгаажуулан улмаар 2017 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”-ны зохицуулалтыг боловсронгуй болгон хуульчилсан нь 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

ЭХХШТХ-ийн шинэчлэлээр урьд байсан хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах хэргийн харьяаллыг Эрүүгийн хуулийн тодорхой зүйл, заалтаар тогтоож байсныг хэвээр үлдээж, дээр нь нэмж гэм буруугаа сайн дураараа хүлээсэн яллагдагч хүсэлт гаргасан нөхцөлд хэргийг хялбаршуулсан журмаар явуулахаар тусган, энэхүү ажиллагааны явцад яллагдагчийн эдлэх эрх, гэм буруугаа хүлээн зөвшөөрсний хууль зүйн үр дагаврыг яллагдагчид танилцуулах шаардлагыг тусгажээ¹¹.

¹¹ Б.Оюунболд нар, Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном, УБ., 2019, 45 дахь тал.

*Хүснэгт 3. Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлд заасныг
үндэслэн ял оногдуулах зохицуулалт*

№	Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн агуулга	Хариуцлагын төрөл
	Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан шүүх дараах байдлаар хорих ялыг хөнгөрүүлж, ялаас чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэж болно:	
1	1.1. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг гурван жил хүртэл, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн хүн тухайн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж эсхүл гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол	- Ялаас чөлөөлөх; - Гурван жил хүртэл хугацаагаар тэнсэх; - Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ.
2	1.2. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг таван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн хүн тухайн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж эсхүл гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол	- Таван жил хүртэл хугацаагаар тэнсэх; - Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ.
3	1.3. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг хоёр жилээс дээш, дээд хэмжээг найман жил хүртэл хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн хүн тухайн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн бол	- Ялын дээд хэмжээний 2/1-ээс хэтрэхгүй, доод хэмжээний 2/1-ээс багагүй ял оногдуулах.

4	1.4. Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг арван хоёр жил эсхүл арван таван жил хүртэл хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн хүн тухайн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн бол тухайн зүйл, хэсэг, заалтад заасан	- Ялын дээд хэмжээний 2/3-оос хэтрүүлэхгүйгээр, ялын доод хэмжээний 2/3-оос багагүй ял оногдуулах.
5	1.5. Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг хорин жил хүртэл хугацаагаар тогтоосон ба бүх насаар хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн хүн тухайн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн бол	- Ялын дээд хэмжээний 3/4-аас хэтрүүлэхгүйгээр, ялын доод хэмжээний 3/4-аас багагүй ял оногдуулах.
6	2. Зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүн гэмт хэргээ илчлэн ирсэн, зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн, мэдээлэл өгсөн, эрх бүхий байгууллагатай хамтран ажилласан бол түүнийг гэм буруугаа хүлээсэнд тооцон ял оногдуулж, хөнгөрүүлж, чөлөөлөхдөө дээрх журмыг баримтална.	
7	Энэ хуулийн тусгай ангид бүх насаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн хүн өөрийн гэм буруутай болохыг хүлээн зөвшөөрсөн бол түүнд хугацаатай хорих ял оногдуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ.	

ЭХХШТХ-д Эрүүгийн хуулийн тусгай ангид наймаас доош жилийн хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан хэргүүдийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхээр заасан байх бөгөөд Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.4, 1.5 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаж байгаа тохиолдолд шүүх хуульд зааснаар ялыг хөнгөрүүлэх боломжтой байна. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа сайн дураар хүлээсэн, учруулсан хохирлоо барагдуулсан, хэргийн талаар ямар нэгэн “маргаан” гаргаагүй, шүүхэд мэтгэлцэх шаардлагагүй гэж яллагдагчаас

үзсэн тохиолдолд хялбаршуулсан журмаар шүүх хэргийг хянан шийдвэрлэж болохоор тусгасан (Зөвхөн яллагдагч хэргээ өөрөө хүлээсэн нь яллах үндэслэл болохгүй зарчим).

Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх хүрээг нэмэгдүүлснээр шүүхийн ачаалал тодорхой хэмжээгээр хөнгөрч, шүүхийн үйлчилгээний зардал, чирэгдэл багасна гэж тооцсон байна¹². Энэ нь ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагааг сонгосон эсэхээс үл хамааран шүүхийн шатанд гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан шүүх тухайн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх зохицуулалттай гэж дүгнэж болохоор байна.

ЭХХШТХ-д зааснаар ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах тохиолдлыг дараах онцлогтойгоор хуульчилжээ. Үүнд:

- Эрүүгийн хуулийн тусгай ангид наймаас доош жилийн хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан хэргүүдэд яллагдагчаар татагдсан байх;
- Яллагдагч гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээн зөвшөөрч, хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх тухай хүсэлт прокурорт гаргах;
- Хүсэлтийг мөрдөн байцаалтын эхний шатнаас шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хүртэл хугацаанд гаргах;
- Энэхүү хүсэлтийг өөрийн сайн дурын үндсэн дээр ямар нэгэн албадлага, шахалтгүйгээр гаргасан байх;
- Эрүүгийн хуульд зааснаар хохирлоо төлсөн эсхүл нөхөн төлөхөө илэрхийлсэн байх;

¹² Б.Оюунболд нар, Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном, УБ., 2019. 45-46 дахь тал.

- Хохирогчийн гомдол, эвлэрсэн эсэхээс үл хамаарах;
- Прокурорын сонгосон ял, албадлагын арга хэмжээг хүлээн зөвшөөрсөн байх.

Хүснэгт 4. ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэрэг¹³

Он	Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг		Хялбаршуулсан журмаар шүүх шийдвэрлэсэн		
	Хэргийн тоо	Хүний тоо	Хэргийн тоо	Хувь	Хүний тоо
2017.07.01	8839	10040	1886	21.3	2152
2018	12551	14925	5029	40	5525
2019	13427	15366	4290	31.9	4333
2020	13469	17029	4654	34.5	5287

Статистикаас дүгнэхэд 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс Эрүүгийн хуульд гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх зохицуулалт тусгагдсанаар ЭХХШТХ-ийн хэрэгжилтийн явцад ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагааны үр нөлөө сайжирсан ч олон улсын жишиг үзүүлэлтээс доогуур байгаа нь мөрдөгч, прокурор, шүүгч, өмгөөлөгчдийн болон иргэдийн мэдлэг, эрх зүйн ухамсар, хандлагаас улбаатай байна. Тодруулбал, 2019 онд хийсэн судалгаагаар Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар ялаас чөлөөлөх, тэнсэх, хуульд зааснаас

¹³ Шүүх, прокурорын статистик мэдээ, 2017-2020.

доогуур хорих ял оногдуулах журмыг хэрэглэсэн нийт хэргийн зөвхөн 20 хувьд нь прокурор яллагдагчтай ял тохирсон, үлдсэн 80 хувьд нь шүүх санаачилгаараа уг журмыг хэрэглэсэн байна. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийн оролцоо 13 хувьтай буюу хангалтгүй байжээ¹⁴.

2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжсэн Эрүүгийн болон ЭХХШтХ, Зөрчлийн болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудад 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр хууль тогтоох байгууллагаас тодорхой нэмэлт, өөрчлөлт оруулсан билээ. Үүнд: ЭХХШтХ-ийн 17.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар яллагдагч хохирогчтой эвлэрсэн тухай баталгааг хавсаргах шаардлага тавигдаж байсныг хассан нь хохирогч гомдолтой, эвлэрдэггүй эсхүл хохирогч учирсан хохирлоос илүүтэй мөнгө, эд зүйл нэхэх зэргээр хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэхгүй байх нөхцөл бүрдүүлж байсантай холбоотой. Иймд хүсэлтэд хохирлоо төлсөн баримт хавсаргах нь чухал боловч энэхүү хохирлын хэмжээг мөрдөгч, прокурор тогтоох эсэх, хохирогч хохирлоо бүрэн төлсөн эсэх талаар гомдолтой бол хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй байна. 2017 оны 5 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан ЭХХШтХ-ийн агуулгаар хялбаршуулсан мөрдөн байцаалт нь дараах хоёр агуулгыг илэрхийлж байсан. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлд заасан агуулга;
2. Хуулиар харьяалуулсан зарим төрлийн тодорхой хэргийг Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлд заасан шаардлага хангагдаагүй ч гэсэн шуурхай шийдвэрлэх.

Хуулиар харьяалуулсан зарим төрлийн тодорхой хэргийг Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлд заасан шаардлага

¹⁴ Б.Оюунболд нар, Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном, УБ., 2019. 46 дахь тал.

хангагдаагүй ч гэсэн шуурхай шийдвэрлэх ажиллагаа нь мөрдөн байцаалт 14 хоног, прокурорын хяналт хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох зарчмыг зөрчсөн гэх яллагдагч, түүний өмгөөлөгчийн шүүмжлэлийг дагуулж ирсэн. Иймд хуулийн нэмэлт өөрчлөлтөөр ЭХХШТ хуулийн 17.5 дахь зүйлийн зарим гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх журмыг хүчингүй болгосон байна. Үүнд:

- Прокурор хэргийн зүйлчлэл, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний талаарх саналыг зөвхөн яллагдагчид танилцуулж байсныг өөрчлөн яллагдагч, түүний өмгөөлөгчид танилцуулахаар болсон нь эрүүгийн хэрэгт заавал өмгөөлөгч оролцох тохиолдол биш байсан ч хялбаршуулсан журмаар хэргээ шийдвэрлүүлэх яллагдагч заавал өмгөөлөгчтэй байх шинжийг агуулжээ.
- Шүүх тухайн хэргийг шууд хянан шийдвэрлэх боломжтой гэж үзвэл хүлээн авсан даруй шүүх хуралдаан зарлан явуулж болно гэж заасныг “эсхүл долоо хоногийн дотор ял оногдуулах” гэж эцсийн хугацааг хуанлийн хоногоор хуульчлан тогтоожээ.

Урьд нь гагцхүү прокурорын сонгосон ялыг хүлээн зөвшөөрсөн эсэхийг шүүх хянаж байсан бол цаашид ял, албадлагын арга хэмжээг хүлээн зөвшөөрсөн эсэхийг хянаж улмаар хохирогчтой эвлэрсэн эсэхийг хянах шаардлагагүй болсон байна. Тухайлбал, прокурор хялбаршуулсан журмаар мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн материалтай даруй танилцаж Эрүүгийн хуулийн 5.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 5.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 5.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 6.7 дугаар зүйлд заасан нөхцөл хангагдсан эсэхийг хянаж гаргасан прокурорын саналын хүрээнд шүүх нь шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай шийдвэр гаргахаар нэмэлт оруулжээ.

Энэ нь шүүхээс прокурорын саналын хүрээнд буюу яллагдагч, түүний өмгөөлөгчийн тохиролцсон зөвшөөрсөн нөхцөлөөс хүндрүүлж ял оногдуулахгүй бөгөөд харин хөнгөрүүлж болно гэсэн агуулгыг илэрхийлж байна. Тодруулбал, Эрүүгийн хуульд заасан зорчих эрхийг хязгаарлах ял, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх талаар орсон нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан прокурор, шүүхээс яллагдагчид энэхүү Эрүүгийн хуулийн 5.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 6.7 дугаар зүйлд заасныг үндэслэн ял оногдуулах, ялаас чөлөөлөх, ял оногдуулахгүй тэнсэж албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай болон ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх үндэслэл, журмыг танилцуулахаар нэмэлт өөрчлөлт оруулжээ.

1.2.3. Эрүүгийн хуулиудад тусгасан эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалтын харьцуулалт¹⁵

2002 оны ЭБШТХ-д хуулиар харьяалуулсан 41 хөнгөн гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхээр байсныг 2017 оны хуулиар өргөжүүлэн Эрүүгийн хуульд наймаас доош жилийн хорих ял оногдуулах боломжтой гэмт хэрэгт хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжтой гэж хуульчилсан нь тухайн зохицуулалтыг практикт хэрэглэх боломжийг нэмэгдүүлсэн зохицуулалт болсон юм. Улмаар яллагдагчид гэмт хэрэг үйлдсэн гэм буруут нь хүлээн зөвшөөрүүлэхээр тулган шаардах, албадахыг хориглох талаар хуульчилсан нь хүний эрхийг хангах, эрүү шүүлтээс ангид байх зарчмын хэрэгжилтийг бататгаж өгсөн явдал билээ. Үүнд ямар нэг насны хязгаарлалт тогтоогоогүй нь өсвөр насны яллагдагчийн эрх зүйн байдлыг дээрдүүлж эрүүгийн процесс түргэн шуурхай явагдах зарчмыг хангасан

¹⁵ Хүснэгт 3-аас харьцуулалтыг үзнэ үү.

бөгөөд “Хохирогч хохирлын талаар маргаангүй” гэдэг зохицуулалтыг хассан нь хохирогчийн хүсэл зоригоос үл хамаарч, тухайн ажиллагаа явагдах боломжийг хангасан. Түүнчлэн яллагдагчийн мэдэх эрх буюу тэд ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шат, тэдгээрийн хугацаа, эрүүгийн хариуцлага хүлээх хууль зүйн үр дагаврыг тайлбарлуулан танилцах эрхээр хангагдсан байна.

Ийнхүү прокурор, шүүх ЭХХЖ-аар хянах, шийдвэрлэхэд харгалзан үзэх нөхцөл байдлыг хуульчилсан нь тодорхой, ойлгомжтой зохицуулалт болсон төдийгүй хэргийг мөрдөн шалгах, хянах, шийдвэрлэх ажиллагаанд баримтлах зарчмын хэрэгжилтийг хангахад хууль зүйн учир холбогдолтой болсон.

ЭХХШТХ-ийн 17 дугаар бүлэг “Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” зохицуулалт нь бүхэлдээ тодорхой хэмжээнд хэрэгжиж, өмнөх хуулийн зохицуулалт, практиктай харьцуулахад мэдэгдэхүйц ахиц дэвшил гарчээ. Тухайлбал, шүүхээс Эрүүгийн хуулийн 5.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 5.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 5.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 6.7 дугаар зүйлд заасныг баримтлан эрүүгийн хариуцлага оногдуулах нөхцөл журмыг нарийвчлан тусгасан нь хууль хэрэглээний түвшинд үр дүнтэй зохицуулалт болсон.

Зарим судлаач¹⁶ 2002 оны Эрүүгийн хуульд заасан тодорхой төрлийн гэмт хэрэгт хариуцлагаас чөлөөлөх үндэслэлийг ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагаатай адилтган ойлгож дүгнэсэнтэй санал нийлэхгүй байна.

Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх зохицуулалтыг анх удаа 2015 онд Эрүүгийн хуульд баталгаажуулан улмаар 2017 онд Эрүүгийн хэрэг хянан

¹⁶ Б.Ганболд, Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй (Тусгай анги), УБ., 2010.

шийдвэрлэх тухай хуульд “Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”-ны зохицуулалтыг боловсронгуй болгон хуульчилсан нь хуульд заасан процессыг цаг хугацааны хувьд болон шүүн таслах ажиллагааг хялбарчилж мөн хохирогч, шүүгдэгч хоёуланд нь ашигтай байдлаар ял тохиролцох хэлбэрийг нутагшуулсан байна.

ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1. МОНГОЛ УЛС ДАХЬ ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ ХЯЛВАРШУУЛСАН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ТООН МЭДЭЭЛЛИЙН СТАТИСТИКИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Цагдаагийн байгууллагаас 2020 онд эзэн холбогдогч нь тодорхой 18,536¹⁷ гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 13,391 хүн, таван хуулийн этгээдэд холбогдох 13,469 эрүүгийн хэргийг шийдвэрлэжээ¹⁸ Үүний 4,654 нь ЭХХЖ-аар хянан шийдвэрлэгдсэн байна.



¹⁷ Цагдаагийн байгууллагад 2020 онд хөнгөн 19,247; хүнд 3,817; нийт 23,064 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 40.8 хувь нь буюу 9,410 гэмт хэрэг нууц, далд аргаар эзэн холбогдогч нь тодорхойгүй үйлдэгдсэнээс илрүүлэлт улсын хэмжээнд 51.9 хувьтай буюу 48883 гэмт хэргийг илрүүлсэн.


¹⁸ Монгол Улсын Шүүхийн тайлан, 2020.

2020 онд анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хэргийн 34 хувийг, сонгон судалсан хугацаанд шийдвэрлэсэн хэргийн 34 хувийг ЭХХЖ-аар хянан шийдвэрлэжээ.



2008-2020 онд ЭХХЖ-аар хянан шийдвэрлэгдсэн хэргийн тоо өссөн нь гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, хорих ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх зохицуулалт Эрүүгийн хууль болон ЭХХШтХ-д тодорхой хуульчлагдсантай холбоотой. Тухайлбал, 2020 онд анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хэргийн гуравны нэг буюу 35 хувь (сонгосон судалгааны хугацаанд 35 хувь)-ийг ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэрэг эзэлж байгаа нь ЭХХШтХ-ийн 17 дугаар бүлэгт заасан “Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” зохицуулалт үр нөлөөтэй хэрэгжиж байгааг харуулж байна.

График 10. ЭХХЖ-аар хянан шийдвэрлэгдсэн хэргийн зүйлчлэлийн харьцуулалт



Сонгон судалсан хэргүүдээс ЭХТА-ийн 11.6 дугаар зүйлд заасан хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэрэг 48.6 хувь, 27.10 дугаар зүйлд заасан авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 13.7 хувь буюу дийлэнх нь байна.



Давж заалдах шатны шүүхэд ЭХХЖ-аар хянан шийдвэрлэгдсэн хэрэгтэй холбогдуулан прокурорын эсэргүүцэл 54, хохирогч, түүний өмгөөлөгчийн гомдол 11, шүүгдэгч, түүний өмгөөлөгчийн гомдол 26 тус тус гаргажээ.

Нийт 13 аймгийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн гаргасан шийдвэрт нэгээс дөрвөн удаа, Улаанбаатар хот дахь анхан шатны шүүхүүдийн шийдвэрт 69 удаа гомдол, эсэргүүцэл гарган (Хавсралт 3-ыг харна уу), тэдгээр гомдол, эсэргүүцэл давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэгдсэн байна.

График 12. Анхан шатны шүүхийн шийдвэрт гаргасан гомдол, эсэргүүцлийг давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн байдал



Давж заалдах шатны шүүхэд хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэрэгтэй холбогдуулан прокурорын эсэргүүцлийн 53.7 хувийг бүрэн, 5.5 хувийг хэсэгчлэн хангасан бол хохирогч, түүний өмгөөлөгчийн гомдлын 63.6 хувийг, шүүгдэгч, түүний өмгөөлөгчийн гомдлын 57.6 хувийг тус тус ханган шийдвэрлэжээ.




Хяналтын шатны шүүхэд талууд тус бүр дөрвөн эсэргүүцэл, гомдол гаргаснаас шүүгдэгч, түүний өмгөөлөгчийн нэг хүсэлтийг хүлээн авахаас татгалзжээ. Хүлээн авсан гомдол, эсэргүүцлийн хувьд тус бүр нэгийг цагаатган шийдвэрлэжээ.





Анхан шатны шүүхээр хялбаршуулсан журмаар 3,470, давж заалдах шатны журмаар 91, хяналтын шатны шүүхэд найман хэрэг тус тус шийдвэрлэжээ.



Давж заалдах шатны шүүхэд ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэргийн гурван хувьд гомдол, эсэргүүцэл гаргасан бөгөөд үүнээс 3 нь уг шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй хяналтын шатны шүүхэд гомдол, эсэргүүцэл дахин гаргасан байна.

2.2. ХЭРГЭЭ ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛҮҮЛСЭН ЯЛЛАГДАГЧИЙН ХУВИЙН БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

Сонгон судалсан 189 хэрэг буюу таван хувьд асуумжийн хүрээнд судалж үзэхэд хялбаршуулсан журмаар хэргээ хянан шийдвэрлүүлсэн 189 иргэний 188 нь Монгол Улсын иргэн, нэг гадаад улсын иргэн байна (График 16-г харна уу).

График 16. Сонгон судалсан хэргийг үйлдсэн этгээдүүдийн иргэний харьяаллын байдал






График 17. Сонгон судалсан хэргийг үйлдсэн этгээдүүдийн хүйсийн байдал




Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн нийт 189 хэргийн 89 хувийг эрэгтэйчүүд үйлдсэн бол 11 хувийг эмэгтэй хүмүүсийн үйлдсэн хэрэг эзэлж байна.

График 18. Сонгон судалсан хэргийг үйлдсэн этгээдүүдийн насны байдал



Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэргийг 18-24 настай 33, 25-29 настай 26, 30-34 настай 39, 35-39 настай 25 этгээд үйлдсэн нь хамгийн өндөр үзүүлэлттэй буюу нийт хэргийн 65 хувийг үйлдсэн байна.


График 19. Сонгон судалсан хэргийг үйлдсэн этгээдүүдийн боловсролын байдал



Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэрэг үйлдсэн этгээдүүдийн талаас олонх буюу 82 нь бүрэн дунд боловсролтой хүмүүс байгаа бол 45 нь дээд боловсролтой хүмүүс байна.




ЭХХЖ-аар хянан шийдвэрлэгдсэн хэргийн шүүгдэгчдийн 64.5 хувь нь хөдөлмөр эрхэлдэг ба хувийн хэвшлийн ажилтан 63, хувиараа хөдөлмөр эрхлэгч 23 байна.





ЭХХЖ-аар хянан шийдвэрлэгдсэн хэрэг үйлдсэн шүүгдэгчдийн 30 хувь нь нэг ба түүнээс дээш удаа ял эдэлж байжээ.



ЭХХЖ-аар хянан шийдвэрлэгдсэн хэргийн 79 нь буюу 41 хувь нь согтууруулах ундаа хэрэглэсэн үед үйлдэгдсэн байна.

Эрүүгийн хуульд заасан найм хүртэлх жилийн хорих ялтай гэмт хэрэг үйлдсэн яллагдагч¹⁹ нь иргэншил, нас, хүйсийн байдал, эрхэлж байгаа ажил, албан тушаал, боловсрол, урьд нь ял шийтгэл эдэлж байсан эсэхээс үл хамаарч тухайн журмаар хэргээ шуурхай шийдвэрлүүлэх боломжтой байна. ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагаа нь цаг хугацаа хэмнэдэг тул тухайн иргэн тухайн журмыг сонгон хүсэлт гаргаж, хэргээ шуурхай шийдвэрлүүлэх нь Үндсэн хуульд заасан хөдөлмөрлөх, суралцах зэрэг иргэний үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэх боломж олгодог байна.

¹⁹ ЭХ-ийн 6.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг “ял оногдуулахыг тэнсэж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан хугацаанд шүүхээс даалгасан үүргийг биелүүлээгүй хүнд ял оногдуулахад энэ бүлэгт заасан журмыг хэрэглэхгүй”.


2.3. ПРОКУРОР, ШҮҮХЭЭС ХЭРГИЙГ НЭМЭЛТ АЖИЛЛАГАА ХИЙЛГЭХЭЭР БУЦААСАН БАЙДАЛ

Хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж байгаа хугацаа, хэргийг прокурор, шүүхээс нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаасан байдалд дүн шинжилгээ хийхээр эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн санамсаргүй түүврийн аргаар судалсан дээрх 189 шийтгэх тогтоолтой танилцахад тодорхой мэдээлэл байхгүй байсан болно.

Жишээ 1. Өмнөговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн Б.Э-д холбогдох эрүүгийн 029000320048 дугаартай хэргийн талаар

Шүүгдэгч Б.Э нь 2020 оны 1 дүгээр сарын 17-18-нд шилжих шөнө согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ нийгмийн хэв журам зөрчин бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан, цагдаагийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг хүч хэрэглэн эсэргүүцсэн эрүүгийн 029000320048 дугаартай Өмнөговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 35 дугаартай магадлал (144/2020/0062/Э)-д ЭХХШтХ-ийн 17.4 дүгээр зүйлийн 4.1-д заасан “...шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн нь нотлох баримтаар нотлогдсон эсэх шаардлага бүрэн хангагдаагүй, хэргийн бодит байдал бүрэн тогтоогдоогүй” гэсэн үндэслэлээр прокурорт буцааж шийдвэрлэснийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан байна.

График 23. Нотлох баримт дутуу гэх үндэслэлээр буцаасан тухай шүүгчийн шийдвэрт гаргасан гомдол, эсэргүүцэл



Анхан шатны шүүхээс нотлох баримт дутуу гэх үндэслэлээр 15 хэргийг буцаахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан давж заалдах шатны шүүхэд гомдол, эсэргүүцэл гаргажээ.


Прокуророос шилжүүлсэн эрүүгийн хэргийн хүрээнд буюу хэрэгт цугларсан нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн, бодитой шалгаж, хянасны үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоон, үйл баримтад хууль зүйн дүгнэлт хийж шийдвэрлэх боломжтой байтал ЭХХШТХ-ийн 17.4 дүгээр зүйлийн 4.1-д заасан “...шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн нь нотлох баримтаар нотлогдсон эсэх шаардлага бүрэн хангагдаагүй, хэргийн бодит байдал бүрэн тогтоогдоогүй” гэсэн үндэслэлээр прокурорт буцаах²⁰ тохиолдлууд байна. Сонгон судалсан хэргүүдэд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулсан, яллагдагч, тэдний өмгөөлөгчөөс санал хүсэлт гаргасан эсэхийг шалгах боломжгүй байлаа.

²⁰ Шүүгдэгч Б.Э нь 2020 оны 1 дүгээр сарын 17-18-нд шилжих шөнө согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ нийгмийн хэв журам зөрчиж бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан үйлдлийг нь шалгах талаар цагдаагийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг хүч хэрэглэн эсэргүүцсэн 029000320048 дугаартай Өмнөговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 35 дугаартай магадлал (144/2020/0062/Э).

2.4. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ШИЙДВЭРЛЭЖ БАЙГАА ХУГАЦААНЫ ДҮН ШИНЖИЛГЭЭ


Хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж байгаа хугацаа, хэргийг прокурор, шүүхээс нэмэлт ажиллагаа хийхээр буцаасан байдалд дүн шинжилгээ хийхээр эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн санамсаргүй түүврийн аргаар судалсан дээрх 189 шийтгэх тогтоолтой танилцахад тодорхой мэдээлэл байхгүй байснаас гадна шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулсан, яллагдагч, тэдний өмгөөлөгчдөөс санал, хүсэлт гаргасан эсэхийг шийтгэх тогтоолоос дүгнэх боломжгүй байв. Тухайлбал, ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн ажиллагаа нь ЭХХШТХ-ийн 17 дугаар бүлэгт заасан даруй буюу долоо хоногийн дотор явагдсан эсэхийг дүгнэх боломжгүй байна.

График 24. ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн хугацаа



Сонгон судалсан хэргүүдийн 87.9 хувийг шүүх нэгээс долоо хоногийн хугацаанд, үлдсэн 12.1 хувийг найм ба түүнээс дээш хоногт шийдвэрлэжээ.

График 25. ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэргийг эрүүгийн хэрэг үүсгэснээс хойш шийдвэрлэсэн хугацаа



Сонгон судалсан хэргүүдийн 67 хувийг нэгээс хоёр сарын дотор, 19.5 хувийг гурваас дөрвөн сарын дотор, 4.7 хувийг таваас зургаан сарын дотор, 6.8 хувийг долоо ба түүнээс дээш сарын дотор шийдвэрлэсэн байна.

2.5. ШҮҮХ ХУРАЛДААНД ШҮҮГДЭГЧ, ХОХИРОГЧ, ХУУЛЬ ЁСНЫ ТӨЛӨӨЛӨГЧ, ӨМГӨӨЛӨГЧИЙН ОРОЛЦОО

Хөдөө орон нутагт шийдвэрлэсэн хэргийн шүүгдэгчдийн 78 хувь, хохирогчдын 1.2 хувь нь, Улаанбаатар хотод шийдвэрлэгдсэн хэргийн шүүгдэгчийн 9,9 хувь, хохирогчийн 0,9 хувь нь өмгөөлөгчтэй шүүх хуралдаанд оролцжээ (График 26-г харна уу). Энэ нь Улсын Ерөнхий Прокурорын газраас 2019 онд хийсэн судалгаагаар ЭХХЖ-аар хянан шийдвэрлэгдсэн хэргийн яллагдагчдын 13 хувь, ердийн журмаар явуулсан шүүх хуралдаанд яллагдагчдын 25 хувь нь өмгөөлөгчтэй оролцож байсантай харьцуулахад харьцангуй бага үзүүлэлт юм.



Жишээ 2. Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн шүүгдэгч Х.Б-д холбогдох эрүүгийн 2006 00000 2244 дугаартай хэрэг

Х.Б нь согтуурсан үедээ 2020 оны 8 дугаар сарын 4-ний өдөр Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны нутаг дэвсгэрт иргэн С.Т-гийн хөл хэсэг рүү өшиглөж, цээж болон толгойн тус газарт цохисны улмаас эрүүл мэндэд нь хүндэвтэр хохирол санаатай учруулсан эрүүгийн 2006000002244 дугаартай Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 1324 дугаартай магадлал (105/2020/1557/Э)-д ЭХХШТХ-ийн 17.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан “...Шүүх хуралдаанд прокурор, шүүгдэгч, түүний өмгөөлөгч эсхүл хууль ёсны төлөөлөгч оролцоно. Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч оролцох хүсэлт гаргасан бол оролцуулна”, 8.2 дугаар зүйлийн 1 дэх

хэсэгт заасан “...шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдаанд оролцох...”, “...гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах...” зэрэг хохирогчийн үндсэн эрхээ эдлэх боломжийг хязгаарласан байна гэж үзсэн.

ЭХХШТХ-ийн 17.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Прокурор хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх үндэслэлтэй гэж үзвэл хэргийн зүйлчлэл, түүнд оногдуулах ялын төрөл, хэмжээ эсхүл ялаас чөлөөлөх эсхүл ял оногдуулахгүй тэнсэж, албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай саналыг яллагдагч, түүний өмгөөлөгчид танилцуулж...”, 17.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан “...Шүүх хуралдаанд прокурор, шүүгдэгч, түүний өмгөөлөгч эсхүл хууль ёсны төлөөлөгч оролцоно” гэж заасныг дүгнэвэл тухайн яллагдагч, шүүгдэгч заавал өмгөөлөгчтэй байх агуулга илэрхийлэгдэж байна.

Сонгон судалсан хэргүүдэд хөдөө орон нутагт шийдвэрлэсэн хэргийн шүүгдэгчдийн 22 хувь, Улаанбаатар хотод шийдвэрлэсэн хэргийн шүүгдэгчдийн 90.1 хувь нь шүүх хуралдаанд өмгөөлөгчгүй оролцсон нь ЭХХШТХ-д зааснаар яллагдагч, шүүгдэгч ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагаанд заавал өмгөөлөгчтэй байх агуулга илэрхийлэгдэж байгаа ч энэхүү хуулийн хэрэгжилт хангалтгүй мөн яллагдагч, шүүгдэгч үйлдсэн хэргээ хүлээн зөвшөөрсөн, хохирогч учирсан хохирлоо эргүүлэн авсан зэрэгтэй холбоотой байна.

2.6. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭНИЙГ ТОГТООСОН НОТЛОХ БАРИМТЫН ШИНЖИЛГЭЭ

ЭХХЖ-аар хянан шийдвэрлэгдсэн хэргийн нотлох баримтаар мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, хэргийн газрын үзлэг болон бусад үзлэгийг нотлох баримтаар дийлэнх тохиолдолд тооцсон байна (График 27-г харна уу).



Практикт хялбаршуулсан журмаар шийдвэрлэж байгаа хэргийн яллагдагч гэмт хэрэг үйлдсэн нь нотлох баримтаар нотлогдсон талаар нэг мөр ойлголт байхгүйгээс шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээс хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах, анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тухайн шүүгдэгчийн хувьд прокуророос шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэргийн хүрээнд²¹ шийдвэрлэнэ гэснийг үл харгалзан шүүхээс буцаасан тохиолдол байна.

2.7. ОНОГДУУЛСАН ЯЛ, АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЛЭСЭН БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

Сонгон судалсан хэргүүдэд дүн шинжилгээ хийхэд 139 хүнд торгох ял, 10 хүнд нийтэд тустай ажил хийлгэх ял, 14 хүнд эрх хасах ял нэмэгдлээр оногдуулсан нь Эрүүгийн хуулийн үзэл баримтлалтай нийцэхгүй байна.

²¹ ЭХХШТХ-ийн 34.14 дүгээр зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэмжээ хязгаар.

График 28. ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэрэгт оногдуулсан ял, албадлагын арга хэмжээ



Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан шүүх дараах байдлаар **хорих ялыг хөнгөрцүлж, ялаас чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэхээр** хуульчилсан билээ. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлд “Торгох”, “Нийтэд тусгай ажил хийлгэх”, “Эрх хасах” ял оногдуулах эрх зүйн зохицуулалтыг огт хуульчлаагүй тул дээрх хэргүүдийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн гэж үзэх хууль зүйн үндэслэл алга байна. Түүнчлэн хялбаршуулсан журмаар шийдвэрлэх саналтай ирсэн хэргийг ердийн журмаар шийдвэрлэсэн тохиолдлууд сонгон судалсан шийтгэх тогтоолыг судлах явцад гарсан нь шүүх хуралдааны нарийн бичгийн даргын техник алдаа эсвэл хууль буруу хэрэглэсэн байх талтай.




ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн 139 хэрэг буюу 73.5 хувьд торгох ял оногдуулсан байна. Үүнээс 126 хэрэгт 100-1000, 12 хэрэгт 1001-10000, нэг хэрэгт 10001-40000 нэгжээр торгох ял тус тус оногдуулжээ.




ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн 14 хэрэг буюу 7.2 хувьд энэ ялыг (нэмэгдлээр) оногдуулснаас 13 хэрэгт нэгээс гурван жил, нэг хэрэгт гурваас таван жилийн хугацаатай эрх хасах ял оногдуулсан байна.




Цаашид Эрүүгийн хуульд гагцхүү хорих ялыг хөнгөрүүлэн ялаас чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэхээр хуульчилсан нь учир дутагдалтай бөгөөд бусад төрлийн ялыг хөнгөрүүлэх, чөлөөлөх талаар зохих судалгаа хийж холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг нягтлах нь зүйтэй юм.



ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн найман хэрэг буюу 4.2 хувьд хорих ял оногдуулснаас зургаан хэрэгт нэг жил хүртэлх хугацаагаар, хоёр хэрэгт гурван жил хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулжээ.



ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн 26 хэрэгт гурван жил хүртэлх хугацааны хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх арга хэмжээ авсан байна.



ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн дөрвөн хэрэгт зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэх, найман хэрэгт согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах арга хэмжээ авсан байна.

График 34. ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн хэрэгт прокурортой тохиролцон шүүхээс ял оногдуулсан эсэх



ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн 166 хэрэгт прокурортой тохиролцон түүний санал болгосон ял оногдуулж, 22 хэрэгт прокурор ял тохиролцсон эсэх нь тодорхойгүй байна. Шүүхээс нэг хэрэгт прокурортой тохиролцсоноос бага ял оногдуулжээ.

Жишээ 3. Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн шүүгдэгч Х.Б-д холбогдох эрүүгийн 203500000158 дугаартай хэрэг

Шүүгдэгч Х.Б нь Увс аймгийн Зүүнхангай сумын 4 дүгээр багийн нутаг “Улаан дэл” гэх газарт 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр хохирогч Б.Д-г зодож, түүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулсан гэмт хэрэгт Увс аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 12 дугаар сарын 28 өдрийн 01 дугаартай магадлал (177/2020/0150/Э)-аар Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д заасныг журамлан шүүгдэгч Х.Б-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ял оногдуулахыг нэг жил зургаан сарын хугацаагаар тэнсэж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.3 дугаар зүйлийн 3 дахь

хэсгийн 3.3-т зааснаар шүүгдэгч Х.Б-д тэнсэгдсэн хугацаанд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох хязгаарлалт тогтоох албадлагын арга хэмжээ авч шийдвэрлэсэн байна.

Давж заалдах шатны шүүхээс хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ прокурорын саналын хүрээнд шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулан алдаа гаргасан талаар дурдан, эрүүгийн хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр мөн шүүхэд буцаах тухай шийдвэр гаргасан нь ЭХХЖ-аар явуулах хянан шийдвэрлэх ажиллагааг хийсэн байна.

Жишээ 4. Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн шүүгдэгч П.Ш-д холбогдох эрүүгийн 2035000000158 дугаартай хэрэг

Шүүгдэгч П.Ш нь 2019 оны 8 дугаар сарын эхээр Төв аймгийн Эрдэнэсант сумын Баргилт 2 дугаар багийн нутагт иргэн Б.Одончимэгийн хашаанд орж ирсэн иргэн Л.А-гийн хоёр гахайн торойг хулгайлж, 994,700 төгрөгийн хохирол учруулсан Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 2020/ДШМ/57 дугаартай магадлал (2034001050140)-аар Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-ыг баримтлан шүүгдэгч П.Ш-ийг Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 2 (хоёр) жилийн хугацаагаар тэнсэж, албадлагын арга хэмжээ авч шийдвэрлэсэн байна.

Шүүгдэгч П.Ш-ийн гаргасан “...прокурорын нэг жилийн хугацаагаар тэнсэх, албадлагын арга хэмжээ авхуулах саналтайгаар шүүхэд шилжүүлсэн. Шүүхээс хоёр жилийн хугацаагаар тэнсэх, албадлагын арга хэмжээ авсан тул өөрчилж өгнө үү” гэсэн гомдлын дагуу анхан шатны шүүхийн

шийдвэрийг өөрчилсөн нь ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагаа буруу явуулсныг илтгэж байна.

Жишээ 5. Улсын Дээд шүүхээр шийдвэрлэгдсэн шүүгдэгч Г.Е-д холбогдох эрүүгийн 2009008250431 дугаартай хэрэг

Шүүгдэгч Г.Е-г бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүй ч нууцаар, хууль бусаар авсан эрүүгийн 2009008250431 дугаартай Улсын Дээд шүүхийн 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 477 дугаартай (185/2020/0308/Э/) тогтоолд прокурорын гаргасан эсэргүүцлийн дагуу ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх хэрэгт Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.1, 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан ял оногдуулсныг “Эрүүгийн хуулийг буруу хэрэглэжээ” гэсэн тогтоол гаргасан нь ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагааг буруу явуулсан гэж үзэх үндэстэй байна.

Сонгон авсан хэргүүдийн хувьд хорих ял оногдуулсан байдлыг судлахад прокурор шүүхийн ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн ажиллагааг Эрүүгийн хууль, ЭХХШТХ-д тусгасан үзэл баримтлал, хандлагыг буруу ташаа ойлгосноос хуулийг хэрэглэх явцдаа зарим төрлийн алдаа гаргасан байна гэж дүгнэж болохоор байна. Тодруулбал, прокурорын тохиролцон, санал болгосон ялаас шүүх хүндрүүлж ял оногдуулан, шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулах, хорих ял оногдуулах санкцгүй хэрэгт ял тэнсэх, Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлд “Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, хорих ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх”-ийг заасан атал нэмэлтээр 7.1-ийг баримтлан хууль буруу хэрэглэж байна.



2.8. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХЭД УЧИРЧ БУЙ ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ

Жишээ 6. Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн 1902000000344 дугаартай хэрэг

Шүүгдэгч Н.У, Э.Х, Г.Ж, Г.А, Ш.М, Ж.Ц, Б.Ц нар ашигтай шийдвэр гаргуулна гэж гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийлгүүлэхээр урьдчилан амлаж, бусдад хахууль өгсөн гэх эрүүгийн 1902000000344 дугаартай Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн 974 дугаартай магадлал (2020/ДШМ/974)-д шүүгдэгч “хялбаршуулсан журмаар хэргээ шийдүүлнэ гэхэд үгүй гэсэн. Хэрэв энэ үед зөвшөөрсөн бол миний эрх зүйн байдал дээрдэх байсан гэж бодож байна” гэжээ.

Жишээ 7. Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн 1902000000201 дугаартай хэрэг

“Шүүгдэгч Б.У нь өөрийн хамаарал бүхий ... ХХК-д 800,000,000 төгрөгийн урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох шийдвэр гаргаж, бусдад буюу Б.У өөртөө болон гэр бүлдээ эдийн засгийн давуу байдал бий болгосон эрүүгийн 1902000000201 дугаартай хэргийг шийдсэн Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 2020/ДШМ/1340 дугаартай магадлал (105/2020/1443/Э)-д шүүгдэгчийн өмгөөлөгч П.Б “Бидний зүгээс хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэхээр хүсэлт өгсөн. Гэтэл прокуророос “Турван жил хорих ял оногдуулна. Өөр асуудал байхгүй” гэсэн тул аргагүйн эрхэнд бид хэргийг ердийн журмаар шийдвэрлүүлсэн” гэжээ.

Мөрдөгчтэй хийсэн ярилцлагаас:

Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх зохицуулалт нь их үр дүнтэй, хугацаа, зардал хэмнэх ач холбогдолтой зохицуулалт болж, ажил их хөнгөвчилж байгаа. Прокурорууд ч гэсэн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхдээ таатай байдаг. Яллагдагч “Хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх тухай хүсэлт” гаргахад зарим прокурор танилцаад “Дараа долоо хоногт гарга, энэ долоо хоногт завгүй байгаа” эсвэл “Наад хэргийг чинь хялбаршуулснаар шийдвэрлэхгүй” зэрэг дурын шийдвэрээ амаар өгдөг. Энэ нь их хүндрэлтэй байдаг.

ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах хүсэлтийг хүлээн авсан прокурор хуульд заасан үндэслэлгүй байвал уг ажиллагааг явуулахаас татгалзан, энэ тухай үндэслэл бүхий тогтоол гаргана. Энэхүү шийдвэрт яллагдагч, түүний өмгөөлөгчид хуульд заасны дагуу дээд шатны прокурорт гомдол гаргах эрхтэй боловч прокурор хүсэлтийг хүлээн авахаас үндэслэлгүй татгалзах, энэ тухай бичгээр шийдвэр гаргахгүй байх, зарим тохиолдолд хойшлуулж байгаа нь зарим шүүхийн шийдвэрт тусгагдсан байна.

Яллагдагч нь ЭХХЖ-аар хянан шийдвэрлүүлэх тухай хүсэлт гаргахад хэрхэн бүртгэж авах, хуульд заасны дагуу прокурорт танилцуулах, хэрхэн шийдвэр гаргах, уг ажиллагаанд хяналт тавих зэргийг тодорхойлохгүй бол тухайн ажиллагааны мөн чанар зарим үед алдагдаж байна.

Жишээ 8. Сүхбаатар аймаг дахь Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэгдсэн Б.С-д холбогдох хэрэг

Шүүгдэгч Б.С нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ Сүхбаатар аймгийн 7 дугаар багийн нутаг дэвсгэрт 2020 оны 6 дугаар сарын 30-ны 20 цагийн орчимд иргэн Х.Б-г зодож эрүүл мэндэд нь хөнгөн хохирол учруулсан хэрэгт Сүхбаатар аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 24 дугаартай магадлал (174/2020/0155/э/)-д хохирогч “прокурорын болон шүүхийн шатанд С нь миний эрүүл мэндэд учруулсан хохирлоо нөхөн төлнө гэж хүсэлт гаргаж бид хоёр эвлэрч хэргийг түргэн шуурхай шийдвэрлүүлэхээр болсон боловч хохирол төлбөрийн талаар юу ч ярихгүй, өнөөдрийг хүртэл намайг хохироосоор байна” гэх гомдол гаргасан.

Уг гомдлын дагуу шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 6 дахь заалтын “...шүүгдэгч Б.С энэ тогтоолоор бусдад төлөх төлбөргүй буюу хохирогч Х.Б гомдолгүй, нэхэмжлэх зүйлгүй” гэснийг “шүүгдэгч Б.С нь гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, хор уршиг болох 300,000 төгрөгийг 2020 оны 7 дугаар сарын 15-ны дотор нөхөн төлөхөө илэрхийлсэн болохыг тус тус дурдсугай” гэж өөрчилсөн шийдвэр гарсан байна.

ЭХХШТХ-д 17 дугаар бүлэгтэй холбоотой зарим зүйл заалтыг тодорхойлон тайлбарлаж, хийгдэх ажиллагааг журамлах шаардлагатай байна. Тодруулбал, “Хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлж байгаа” нь зөвхөн яллагдагчийн хэлсэн үг, бичгээр гаргасан баталгаа төдийгөөр шүүхээр шийдвэрлэгдэж байгаа нь хохирогчийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдөн, улмаар давж заалдах шатны болон хяналтын шатны шүүхэд гомдол гаргах шалтгаан болж байна.

ГУРАВ. ЭРХ ЗҮЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Орчин үед гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсооход үндэсний эрх зүйн механизмаас гадна олон улсын эрх зүйн хөшүүргийг зайлшгүй харгалзан харьцуулж үзэх шаардлага үүсэж байна. Энэ бүлэгт Англи, Америк, Франц, Орос, Хятад болон Өмнөд Солонгосын эрүүгийн процессыг харьцуулан олон улсад ямар жишиг, загвар баримталж байгааг судаллаа.

Англид эрүүгийн шүүхийн түргэвчилсэн процессыг олон жилийн турш хэрэгжүүлж байгаа бол АНУ-д ял тохиролцох журмыг эрүүгийн процесст түгээмэл хэрэглэдэг. Харин Англи-Америкийн эрх зүйн системийн орнууд болох Австрали, Канад, Шинэ Зеланд, Энэтхэг зэрэг улсад ял тохиролцох болон түргэвчилсэн журам нэвтрэн хэрэгжиж байна.

Дэлхий дахинд түргэвчилсэн болон хялбаршуулсан процессын хэв маяг, загварыг хандлагаар нь дараах байдлаар ангилж болно. Үүнд:

1. Америкийн ял тохиролцох загвар (*Plea bargaining system*);
2. Английн түргэвчилсэн шүүхийн загвар (*Summary trial procedure*);
3. Францын алтернатив процессын загвар (*Procedure alternatives*);

4. Оросын хялбаршуулсан ажиллагааны загвар²² (*Особый порядок судебного разбирательства и упрощенный процесс*).

3.1. АНГЛИЙН ЭРҮҮГИЙН ПРОЦЕСС

Англи нь хэдийгээр эрүүгийн процессын нэгдмэл ба төрөлжсөн хуульгүй ч эрүүгийн процессын голлох эх сурвалжуудад Улсын Дээд шүүхийн тухай (1981), Тангарагтны шүүхийн тухай (1974), Магистратын шүүх²³-ийн тухай (1994), Эрүүгийн нотлох баримтын болон Цагдаагийн тухай (1985), Цагдаагийн болон Цагдаагийн процессын тухай (1994), Эрүүгийн процессын болон мөрдөн шалгах журмын тухай (1996)²⁴ хуулиуд багтана.

Английн эрүүгийн процесс нь шүүхийн өмнөх ба шүүхийн гэж нарийвчлан зааглагдаагүйн дээр прокурорын институт байдаггүйгээрээ онцлогтой. Эрүүгийн процесс нь төрлийн хувьд хоёр үндсэн ангилалд хуваагддаг. Үүнд:

1. Яллах акт бүхий эрүүгийн процесс;
2. Түргэвчилсэн журам бүхий эрүүгийн процесс.

Эхний процесс нь онц хүнд болон ноцтой хэргийн хувьд төрийн яллах албаны мөрдөн шалгах ажиллагаагаар дамжин, тангарагтны шүүхийн оролцоотой хэрэгждэг ажиллагаа юм. Түргэвчилсэн процесс нь тангарагтны шүүхээр орохгүйгээр явагдах хүнд биш хэргийн ажиллагаа юм²⁵. Энэ ажиллагааг автын ослын болон эрүүгийн жижиг хэргүүдэд өргөн хэрэглэдэг.

²² Б.Бат-Орших. Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үндсэн асуудал. УБ., 2021, 81 дэх тал.

²³ Магистратын шүүх гэдэг нь өөрийн эрх хэмжээнд мөрдөн шалгах онцгой эрхтэй ба тангарагтан оролцуулахгүй шийдвэрлэх бүрэн эрх бүхий шүүх юм.

²⁴ Д.Баярсайхан. Гадаад орнуудын эрүүгийн процесс. УБ., 2015, 88-89 дэх тал.

²⁵ А.К.Романов, Английн эрхийн тогтолцоо (орчуулга Т.Доохүү), УБ., 2002, 199 дэх тал.

Английн эрүүгийн процесст тухайн гэмт хэргийн шинж төрөл, гэм буруугаа хүлээж байгаа эсэхээс хамааран гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагааны арга, хэлбэр тодорхойлогдоно. Иймээс дээр дурдсан хоёр хэлбэрийн процедур бүхий ЭБША нь тус тусдаа ялгагдах зарим шалгуур шинжтэй байдаг.

Түргэвчилсэн журмаар явагдах эрүүгийн процессын онцлог шинжүүд:

- Тухайн хэрэг нь хүнд биш, үр дагавар, хохирол нь ноцтой биш байх бөгөөд урьдчилсан нөхцөлүүд нь яллах актаар шийдвэрлэх шаардлагагүй факт, баримтаар илэрч нотлогдсон байдаг.
- Хэрэгт холбогдсон этгээд ихэнхдээ гэм буруугаа хүлээсэн, хохирлоо төлсөн буюу бусдад төлж чадахаа нотолж, баталсан байна.
- Уг хэрэг нь гарсан орчин, нөхцөлийн хувьд ил, тодорхой ба процессын удаан хугацааны ажиллагаа заавал явуулах шаардлагагүй.
- Энэ ажиллагааг үүсгэн явуулах субъект нь зөвхөн цагдаагаар хязгаарлагдахгүй бөгөөд хэрэг, явдлын онцлог байдлаас хамаарч шуудангийн ажилтан, жирийн иргэн, засаг захиргааны болон бүртгэлийн ажилтан зэрэг янз бүрийн этгээд санаачлан уг ажиллагааг үүсгэх эрхтэй байдаг.
- Энэхүү ажиллагааны эцсийн үр дүнг Магистратын шүүх тодорхойлох ба нэгэнт ил тодорхой нөхцөл байдал бүхий хэргийг процессын нарийвчилсан үе шатгүйгээр шууд шийдвэрлэх аргаар хэргийг эцэслэн шийддэг.

- Дээр дурдсанчлан түргэвчилсэн шийдвэрлэх ажиллагаа нь хохирогч этгээдийн үүсгэсэн хэргийн нэхэмжлэл болон гэм буруугаа хүлээсэн этгээдийн баталгаа, цагдаа болон яллах субъектийн рапорт, тэмдэглэл, хэргийн мэдүүлгээр өгсөн баримтууд (*reports*) зэрэг нотолгооны эх сурвалжид голлон тулгуурлаж явагддаг²⁶.

Нийт шалгагдаж байгаа хэргийн 90 хувь нь түргэвчилсэн журмаар шийдэгддэг бөгөөд гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээсэн этгээдийн хүсэлтийн дагуу Магистратын шүүх шуурхай байдлаар шийдвэрлэдэг байна²⁷. Энэ журмаар шийдвэрлэх боломжтой хэргүүд нь таван жилээс илүүгүйгээр хорих ял шийтгэхээр заасан хэргүүд байдаг. Гэм буруугаа хүлээхгүй маргаж буй ноцтой хэргээс бусад ихэнх тохиолдолд хялбаршуулсан процедурын түргэвчилсэн шийдэх нөхцөлөөр зохицуулсан байдал нь статус ба хэсэгчилсэн хуулиудаас гадна олон арван шүүхийн прецедент, жишиг журмуудаар тодорхойлогддог.

Түргэвчилсэн журмаар мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа формал байдлаар, түргэн шуурхай явуулахыг зорьдог байна. Тухайн хэргийг шийдвэрлэх гол нотлох баримт нь цагдаагийн албан хаагчийн тэмдэглэл, рапорт мөн тэдний гэрчээр өгсөн мэдүүлгүүд болдог. Түргэвчилсэн журмаар шийдвэрлэж буй хэргүүдийн онцлог нь мөрдөн шалгах ажиллагаа болон нотлох баримт бэхжүүлэх ажиллагаа явуулалгүй шийдвэр гаргадаг.²⁸

Яллах акт бүхий хүнд ноцтой хэргүүдийг заавал шүүх хурлаар оруулах замаар тодорхой процедурын нөхцөл үе шатыг дамжин тангарагтны шүүх мэтгэлцээний үндсэн дээр

²⁶ Д.Баярсайхан, Гадаад орнуудын эрүүгийн процесс, УБ., 2015, 89-90 дэх тал.

²⁷ Н.Г.Стойко, А.С.Шагинян, Уголовный процесс Англии и Уэльса, Бельгии и Дании: сравнительно-правовой аспект, Красноярск, 2007, с.59.

²⁸ Stones Justice Manual, London, 1994, p.88-90.

шийдвэрлэнэ. Харин хүнд биш (авто осол, эрүүгийн жижиг хэрэг) хэргийг эрүүгийн процессын түргэвчилсэн журмаар хялбаршуулж шийдвэрлэнэ. Хэрэв түргэвчилсэн журмаар шийдвэрлэх боломжгүй бол хэргийг Магистратын шүүх харьяаллын дагуу давж заалдах шатны шүүх рүү шилжүүлдэг байна.

Магистратын шүүх нь яллах нотолгооны хураангуйлсан баримт сэлт, эх сурвалжуудыг хэсэгчлэн үнэлэх замаар боломжит богиносгосон нөхцөлөөр (бага зардал, бага хугацаа) шийдвэрлэдэг.

3.2. АМЕРИКИЙН ЭРҮҮГИЙН ПРОЦЕСС

Америк нь Эрүүгийн процессын хувьд эрүүгийн хэргийг олон шат дамжлагагүй, түргэн шуурхай шийдвэрлэх, ялын олон сонголттой нөхцөл бий болгон хялбаршуулж шийдвэрлэх талаар туршлага хуримтлуулсан орон гэж үздэг. Тус эрүүгийн процесс нь Английн эрүүгийн шүүхийн нийтлэг жишгийн уламжлалд тулгуурлан прецедентийн хэв маягт түшиглэж, түүнийг уламжлан хөгжсөн. Эрүүгийн процессын эрх зүйн голлох эх сурвалжуудаас нь дурдвал Үндсэн хууль (1787), Хүний эрхийн билл (1791), Холбооны Улсын хуулиудын нэгдсэн 28 дахь эмхэтгэл (1974-1978), Эрүүгийн нотлох баримт, нотолгооны жишиг дүрэм (1972), Онц ноцтой гэмт хэргийг шүүн таслах ажиллагааны тухай холбооны нэгдсэн дүрэм (1980), Мирандагийн жишиг дүрэм (1966), Давж заалдах шатны чиглэмж, дүрэм (1980), мөн Дээд шүүхийн тухай (1980), Гэмт явдлын тархалт, илрүүлэлтэд хяналт тавих тухай (1984 он), Холбооны эрүүгийн загвар (1962) хуулиуд гэх мэт байдаг. Дээр дурдсан эх сурвалжаас гадна Холбоонд нэгдсэн муж улсуудын эрүүгийн хууль, шүүн таслах ажиллагааны зарчим, дүрэм, түүнчлэн холбооны хэмжээнд дагаж мөрдөхөөр Дээд шүүхээс тогтоосон прецедентүүд шууд хамааралтай үйлчилнэ.

Америкийн эрүүгийн процесст нэгэнт ил тодорхой болсон буюу хохирол нь төлөгдөж, ял тохиролцох боломжтой хэргүүдийг түргэвчилсэн журмаар шийдвэрлэх зарчмыг шүүн таслах ажиллагаанд заавал хангах нөхцөл болгон тогтоосон байдаг²⁹.

ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагааг Шүүхийн тухай хууль, Прецедентийн дүрэм зэргээр зохицуулсан байдаг. Энэ ажиллагаа нь процедурын хувьд дараах хоёр түвшинд ялгавартайгаар явагддаг. Үүнд:

1. Түргэвчилсэн журмаар явагддаг шүүх хуралдаан (*Summary trial*);
2. Яллах дүгнэлт бүхий хэргийн ердийн журмаар явагддаг шүүх хуралдаан (*Indictement*).

Гэмт хэрэгт холбогдсон буюу түүнийг үйлдсэн этгээд гэм буруугаа хүлээн зөвшөөрч хохирол, үр дагавраа ухамсарласны үндсэн дээр яллах тал ба өмгөөлөгчтэй харилцан тохиролцсоны дагуу ялын санкцыг тогтоох талаар шүүхийн шатнаас өмнө урьдчилан хэлэлцэж байгаа нь эрүүгийн процессыг хэмнэлттэй, шуурхай явуулахад үлэмж ач холбогдолтой ажээ.

Түргэвчилсэн журмаар явагддаг шүүх хурал нь таван жилээс дээшгүй хорих ял оногдуулахаар заасан хэргийг нарийвчилсан процесс явуулахгүйгээр шуурхай, түргэвчилсэн байдлаар хэлэлцэн шийдвэрлэхэд чиглэгдэнэ. Нотолгооны ач холбогдол бүхий эх сурвалжууд нь цагдаагийн рапорт, яллах ажиллагааны протокол, тэмдэглэл, цагдаагийн болон гэрчийн мэдүүлгүүд байдаг. Ер нь жижиг, дунд зэргийн хэргүүдийн хувьд нотлох ажиллагааны урьдчилсан хэлэлцүүлэг заавал явуулах шаардлагагүй гэж үздэг. Энэ хурал нь тангарагтны оролцоогүй хийгдэх ба ихэвчлэн тухайн хэсэг, нэгжийн

²⁹ Д.Баярсайхан, Гадаад орнуудын эрүүгийн процесс, УБ., 2015, 71-73 дахь тал.

шүүхийн шүүгч дангаараа шийдвэрлэнэ.

Түргэвчилсэн журмын шүүх хуралдаан нь эхлээд яллах талын, дараа нь өмгөөлөх талын нотолгоог сонсон, шүүгдэгчээс гэм буруугаа хүлээсэн эсэхийг асууж, ялын нөхцөл, хэмжээг тохиролцох, мэтгэлцүүлэх замаар явагдаж ялын талаарх шийдвэрээ гаргадаг бол тангарагтан оролцсон ердийн шүүх хуралдаан нь нарийвчилсан процедур бүхий дэс дарааллын дагуу явагддаг байна.

3.3. ФРАНЦЫН ЭРҮҮГИЙН ПРОЦЕСС

Франц улс нь эрүүгийн болон эрүүгийн процессын анхны төрөлжсөн хуулийг бүтээгч, эх газрын системийг үүсгэн хөгжүүлсэн орны хувьд гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагааны арвин баялаг туршлагатай орон юм.

Францын эрүүгийн процессын эрх зүйн эх сурвалжуудыг тухайн холбогдох хэм хэмжээтэй нь уялдуулан авч үзэх нь чухал ач холбогдолтой. Эрүүгийн процесст шууд хамааралтай эрх зүйн голлох эх сурвалжийг дурдвал Үндсэн хууль (1958), Эрүүгийн процессын хууль (1958), Иргэний болон хүний эрхийн тунхаглал (1789), Шүүхийн тухай хууль (1978), Хүний үндсэн эрхийн тухай Европын конвенц (1950), Засгийн газар, Төрийн зөвлөлийн тогтоол, декретэд тусгагдсан процессын журмууд гэх гэт.

Хүнд биш, хөнгөн жижиг хэргүүдийг ихэнхдээ анхны мэдээллийн эх сурвалжуудыг шалган бэхжүүлсэн протокол, хэрэг зөрчлийн тайлангууд (*Repors*), мэдүүлгийн жагсаалтад үндэслэн, хялбаршуулсан журмаар, түргэвчилсэн уян хатан зарчмаар шуурхай шийдвэрлэдэг³⁰.

³⁰ Д.Баярсайхан. Гадаад орнуудын эрүүгийн процесс. УБ., 2015, 66-69 дэх тал.

Францын 1958 оны *Эрцүгийн процессын төрөлжсөн хуулийн* 41 дүгээр зүйлийн 1-д “Алтернатив процедурыг хэрэгжүүлэх” нь прокурорын чиг үүрэг болохыг заажээ. Дээрх журам нь хэргийг хялбаршуулж шийдвэрлэх үндсэн нөхцөлийг тодорхойлох бөгөөд гурван хэлбэрээр дамжин хэрэгждэг байна. Үүнд:

1. Сануулах арга хэмжээ (*Informal warning*);
2. Эрүүгийн хэргийн тохиролцон шийдвэрлэлт (*Out of court settlement in criminal matters*);
3. Эрүүгийн хэргийн эвлэрүүлэн зуучлал (*Victim offender mediation*);
4. Хэргийн холбогдогчийн үйлдсэн гэмт үйлдэл хэрэв нотлогдвол таван жилээс дээшгүй хорих ял болон өөр хөнгөн төрлийн ял оногдуулах нөхцөл бүхий хэрэгт алтернатив процедур хэрэгжүүлдэг байна³¹.

3.4. ОРОСЫН ЭРҮҮГИЙН ПРОЦЕСС

Оросын эрүүгийн процесс нь кодификацчилал болон эрх зүйн эх сурвалж талаас нь авч үзвэл эх газрын системийн хүрээнд хамаарагддаг боловч эрүүгийн процессын суурь зарчим, субъектийн болон чиг үүргийн хуваарилалт, агуулга, мөн чанарын хувьд ялгаатай гэж үзэж болно. Оросын эрүүгийн процессын эрх зүйн голлох эх сурвалжийг дурдвал³² Үндсэн хууль (1993), Эрүүгийн процессын хууль (2001), Прокурорын тухай (2001), Шүүхийн бүрэн эрх, хараат бус байдлын тухай (2002), Сэжигтнийг баривчлах журмын тухай (2002), Өмгөөлөх байгууллага ба өмгөөллийн үйл ажиллагааны тухай (2002),

³¹ Б.Бат-Орших. Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үндсэн асуудал. УБ., 2021, 92 дахь тал.

³² Stephn C.Thaman, Comparative criminal procedure C.A., 2002, p.91.

Эвлэрүүлэх шүүхийн тухай (2003) гэх мэт хуулиуд.

Оросын Эрүүгийн процессын хууль болон холбогдох хуулиудад дараах гурван онцлог журмыг хэрэг хялбаршуулж шийдвэрлэх ажиллагааны үндсэн төрөл болгон зохицуулсан байна. Үүнд:

1. Түргэвчилсэн хэрэг бүртгэлт (*Дознание в сокращенной форме*)³³;
2. Шүүн таслах ажиллагааны онцгой журам (*Особые порядки судебного разбирательства*)³⁴.

Дээрх хоёр хэлбэр нь процессын арга, зарчмын хувьд хоорондоо ялгаатай боловч хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан тодорхой төрлийн хэргийг ердийн журмаас ялгаатайгаар тусад нь авч үзэн хялбаршуулж шийдвэрлэх зорилготой.

Түргэвчилсэн хэрэг бүртгэлтийн ажиллагааны гол онцлогийг түүнийг хэрэгжүүлэх журмыг хуульчилсан байдлаас тодорхой харж болно. Процессын хугацааны хувьд сэжигтэн энэхүү ажиллагааг явуулах тухай хүсэлт гаргаснаас хойш 15 хоногийн дотор мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч нь хэргийг яаралтай горимоор шийдвэрлүүлэхээр прокурорт шилжүүлнэ. Прокурор хэргийг хүлээн авснаас хойш 10 хоногоос хэтрүүлэхгүйгээр (тав хоногт нь материалыг талуудад танилцуулна) яллах тогтоол үйлдэнэ. Нэн шаардлагатай тохиолдолд таваас хорь хоногоор сунгаж болдог байна. Эрүүгийн процессын хуульдаа нэгэнт илэрч тогтоогдсон хэргийн талаарх мөрдөн байцаалтын протокол, мэдүүлгээс гадна хэргийн хохирол, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн баримт зэргийг шүүх дээр нэг бүрчлэн

³³ “Уголовно-процессуальный кодекс Российской Федерации” от 18.12.2001, N 174-ФЗ, УПК, РФ, Статья 226.6, Срок дознания в сокращенной форме.

³⁴ “Уголовно-процессуальный кодекс Российской Федерации” от 18.12.2001. N 174-ФЗ. УПК, РФ, Глава 40, Особые порядки судебного разбирательства.

хэлэлцэхгүй, прокурорын тогтоолын хэмжээнд шийдвэрийг нь баталгаажуулах байдлаар шийдвэрлэхээр тусгажээ. Ял оноохдоо хуульд заасан ялын хэмжээний талаас дээшгүй хэмжээнд тооцон оногдуулна.

Шүүн таслах ажиллагааны онцгой журам нь түргэвчилсэн буюу хялбаршуулсан журмаар шийдвэрлэх процессын нэг төрөл яах аргагүй мөн бөгөөд гол үндэслэл нь яллагдагч яллах талын гаргаж буй гэмт хэргийн зүйлчлэл, ялын нөхцөл, хэмжээ, хохирол зэргийг ямар ч маргаангүйгээр бүрэн хүлээн зөвшөөрөх бөгөөд Эрүүгийн хуульд заасан 10 жилээс дээшгүй хорих ял бүхий хэргийг мөрдөн шалгаж дуусаад шүүхэд шилжүүлэх үед хэрэглэгдэнэ. Шүүх хуралдааныг ердийн журмаар хийхгүйгээр тухайн шүүхийн процессыг хялбаршуулж онцгойлсон журмаар хийнэ. Нотлох баримтыг шинжлэх ялын шүүмжлэл хэлэлцэх зэргээр явуулахгүй. Ялыг хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдал, хэргийн зүйлчлэл, хохирол зэргийг нарийвчлан хэлэлцэхгүй. Энэ ажиллагааг эхлэхийн өмнө мөрдөн байцаалтын ажиллагаа дуусан, урьдчилан сонсох ажиллагаа явагдаж өнгөрсөн байх ёстой бөгөөд яллагдагч онцгой журмаар шүүн таслах ажиллагаа явуулах тухай хүсэлт бичгээр гаргасан байна.

Шүүх прокурорын яллах дүгнэлтийг сонсож, яллагдагчийн хүсэлт болон хэргийн байдлыг танилцуулсны дараа шүүхийн өмнөх шатанд яллах ба өмгөөлөх талын хамтын ажиллагааны талаарх хэлэлцээрийг тодорхой нөхцөлүүдээр хэрхэн хангасныг сонсож хэлэлцэнэ. Ингээд хэргийн талаар шийдвэр гаргах ажиллагаанд орох ба шүүхийн шийтгэх тогтоолд нотлох баримтыг үнэлсэн, дүн шинжилгээ хийсэн талаар дурдахгүй. Эрүүгийн хуульд заасан тухайн хорих ялын гуравны хоёроос дээшгүй хэмжээнд уг ялыг оногдуулах эсэхийг шийдвэрлэнэ.

3.5. ХЯТАДЫН ЭРҮҮГИЙН ПРОЦЕСС

Хятад нь хэдийгээр социалист дэглэмтэй ардчилсан бус орон боловч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд нь инквизицийн мөрдөн шалгах уламжлалыг аккусацийн мэтгэлцүүлэн шүүх зарчимтай маш өвөрмөц аргаар хослуулж, эрүүгийн хэргийн нотлох ажиллагааны хаалттай нөхцөлийг улс, орны онцлогт нийцсэн байдлаар зохицуулж иржээ. Шинэ үеийн онцлогийг тусгасан Эрүүгийн процессын хуулийг 1979 онд батлан, 1980 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж байна³⁵.

Хятад улс нь хэдийгээр эрх зүйн социалист тогтолцооны зарим суурь зарчим, чиг хандлагыг баримталж, хүний эрхийн олон улсын стандарт, хэм хэмжээг хангалтгүй сахиж ирсэн боловч эрүүгийн процессын хууль тогтоомждоо хэргийг хялбаршуулж шийдвэрлэх журмыг зохих хэмжээнд хуульчлан хэрэгжүүлж иржээ. 1979 онд шинээр баталж, 1996 оны 3 дугаар сарын 17-ны өдөр шинэчлэн баталсан “Эрүүгийн процессын тухай” хуулийн гуравдугаар бүлгийн 174, 175, 176, 177, 178 дугаар зүйлүүдэд хэргийг түргэн шуурхай, шууд хялбаршуулах замаар шийдвэрлэх журмыг хуульчилсан байна.¹⁷³ Энэ хуулийн 174 дүгээр зүйлийн 174.1 дэх хэсэгт “Хэрэв шүүгдэгч нь гурван жил, түүнээс доош хорих ял бүхий хэрэг эсхүл баривчлах, зорчих эрхийг хязгаарлах, торгох ял оногдуулахаар заасан хэрэг үйлдсэнийг прокурорын зөвлөмж, зөвшөөрлийн дагуу хэргийг нь хялбаршуулсан журмаар шүүхэд хянан шийдвэрлүүлэхээр хүсэлт гаргаснаар нэг шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр таслан шийдвэрлэнэ” гэж заажээ. Энэхүү ажиллагаа нь дор дурдсан онцлог зохицуулалттай байх ажээ. Үүнд:

³⁵ Д.Баярсайхан, Гадаад орнуудын эрүүгийн процесс, УБ., 2015, 66-69 дэх тал.

- Хөнгөн хэргийн тухайд хохирогчийн болон өмгөөлөгчийн санал тухайн хялбаршуулсан ажиллагааны нөхцөлийг тогтооход шийдвэрлэх үүрэгтэй. Хохирогч өөрөө шийтгэх тогтоолын агуулгыг тодорхойлоход саналаа тусгах эрхтэй.
- Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэж байгаа тохиолдолд шүүгдэгчийг байцаах, гэрчээс мэдүүлэг авах, шинжээчийн дүгнэлт унших, нотлох баримтыг танилцуулах, мэтгэлцэн хэлэлцэх зэрэг процессын ажиллагааг шүүх хуралдааны үед явуулахгүй (ЭПХ-ийн 177.1), ердийн журмаас өөр тусгайлсан шуурхай горимын дагуу явагдана.
- Хялбаршуулсан журмаар хэргийг 20 хоногт багтаан шийдвэрлэх юм.

Хятадын эрүүгийн шүүхийн практикт дээрх журам төдий л хангалттай буюу түгээмэл хэрэгжиж чаддаггүй, нэлээд эргэлзээтэй, зарим талаар шүүмжлэлд өртдөг байна. Учир нь эрүүгийн процессын практикт хялбаршуулсан журмаар ял тохиролцох агуулга бүхий энэ процесст ял хөнгөрүүлэх асуудал нь шүүгдэгч өмгөөлөгчтэй зөвлөлдсөний эцэст гэм буруугаа хүлээсэн эсвэл өмгөөлөгчгүй өөрөө гэм буруугаа хүлээсэн хоёр нөхцөл байдаг. Өөрөөр хэлбэл, энэ процесст өмгөөлөгчийн оролцоо идэвхтэй бөгөөд шийдвэрлэх нөхцөл болдог.

Хятадын эрүүгийн процессын хялбаршуулсан ажиллагааны журам нь өмгөөлөгчийн санаачилга, идэвхтэй үйл ажиллагаанаас ихээхэн хамаардаг ба тус улсын хуульч, хууль зүйн эрдэмтэн, судлаачид энэ асуудлыг шүүмжилж, зөвхөн хөрөнгө мөнгөтэй, өмгөөлөгч авах чадвартай шүүгдэгчид л өөрсдөө илүү давуу байдал олж байгааг нэг бус удаа тэмдэглэсэн нь бий.

3.6. ӨМНӨД СОЛОНГОСЫН ЭРҮҮГИЙН ПРОЦЕСС

Өмнөд Солонгосын Эрүүгийн процессын хууль нь АНУ-ын аккаусацийн мэтгэлцэх зарчмыг бэхжүүлэхийн зэрэгцээ Баруун Европын мөрдөн шалгах тогтолцооны олон элементийг нэмж тусгасан байдаг. 2007 онд шинээр баталсан эрүүгийн процессын хуулиар Америкийн системийн мэтгэлцэх зарчмыг зохистой хэмжээнд хязгаарлан, мөрдөн шалгах ажиллагааны явцад заавал хийгдэх ажиллагааг зааж ЭБША-г бүхэлд нь шинэчилсэн.

Хялбаршуулсан журмын хувьд (*Act of the proceeding for summary judgment*) мөрдөн шалгах ажиллагааг оролцогчдын хүсэлт, саналын дагуу юуны өмнө торгох ялаар орлуулан сольсноор уг ажиллагааг зогсоож, цагдаагийн хэлтсийн дарга шүүхэд хүсэлт гаргаснаар явагддаг ажиллагаа юм. 200,000 хүртэл “вонн”-оор торгуулах зөрчлийн хэргүүд үүнд хамаарагдана³⁶.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулах шаардлагагүй, тэр тусмаа жижиг, хөнгөн хэргүүдийг цагдаа өөрийн бүрэн эрхийн хэмжээнд бие даан шийдвэрлэнэ. Шуурхай шалгаж торгууль ногдуулах, хохирлыг шууд төлүүлэх ажиллагаа явуулна. Түргэвчилсэн журмын хувьд (*Summary order*) прокурор байлцуулахгүйгээр шүүхээс торгох ял оногдуулахад чиглэгдсэн ажиллагаа юм. Яллагдагч торгох ялын эсрэг саналтай бол мөрдөн шалгах ажиллагааг ердийн журмаар явуулж шийдвэрлэнэ³⁷.

БНСУ-ын эрүүгийн процесст зарим гэмт хэргийн (хулгай, залилан, хүнд, хөнгөн гэмтэл учруулах, эд хөрөнгө

³⁶ Б.Бат-Орших. Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үндсэн асуудал. УБ., 2021, 103-104 дэх тал.

³⁷ Д.Баярсайхан. Гадаад орнуудын эрүүгийн процесс. УБ., 2015, 117, 129 дэх тал.



эвдэх, завших, дээрэм гэх мэт) улмаас учирсан хохирлыг хялбаршуулсан нөхцөл, журмын дагуу барагдуулах журам үйлчилдэг. Өөрөөр хэлбэл, нэгэнт ил тодорхой илчлэгдэж, нотлогдсон дээрх гэмт хэргийн хохирлыг хохирогчийн хүсэлтийн дагуу Эрүүгийн шүүхийн журмаар хохирол барагдуулах тогтоолыг 10-14 хоногт багтаан гаргадаг.

ДҮГНЭЛТ

Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх нь дэлхийн хөгжингүй орнууд болох Америк, Англи, Орос, Өмнөд Солонгос, мөн эрүүгийн процессын эрх зүй харьцангуй сүүлд хөгжсөн Хятадад процесс ажиллагааг түргэвчлэх, хялбарчлах, шуурхайлах зорилго, агуулга бүхий журам, зохицуулалтууд бүхий ажиллагаа байна. Энэ ажиллагаа нь Англид түргэвчилсэн журмаар хэрэг хянан шийдвэрлэх, Америкт ял наймаалцах, Францад сонголттой нөхцөлөөр ял тохиролцох, ОХУ-д хялбаршуулсан онцгой журмаар хэрэг хянан шийдвэрлэх нэрээр явагддаг, агуулга зорилго нь адил төстэй боловч арга хэлбэр, нөхцөл, журам нь ялгаатай зохицуулалт бүхий процессын хэв маяг болсон байна. Харьцуулан судалсан орнуудын эрүүгийн процесст Монгол Улсын хуульд нутагшуулан хэрэгжүүлж болох дараах онцлог зохицуулалтууд тусгагджээ. Тодруулбал:

1. Англи, Франц зэрэг улсын эрүүгийн процесс дахь жишгээр хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг хөнгөн, хүнд гэмт хэргээр ангилан, хөнгөн гэмт хэргийг анхан шатны мөрдөн шалгах ажиллагаагаар цугларсан нотлох баримтад үндэслэн шуурхай шийдвэрлэдэг, хүнд гэмт хэрэгт шаардлагатай мөрдөн шалгах ажиллагааг тодорхой хугацаанд явуулан, нэмэлт нотлох баримт цуглуулан шийдвэрлэдэг жишгийг

хэрэгжүүлэх нь хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг улам үр дүнтэй болгох боломжтой байна.

2. Мөн Америкийн эрүүгийн процесст нэгэнт ил тодорхой болсон буюу хохирол нь төлөгдөж, **ял тохиролцох боломжтой** хэргүүдийг түргэвчилсэн журмаар шийдвэрлэх агуулгыг шүүн таслах ажиллагаанд **заавал хангах** зохицуулалтын дагуу, нэгэнт нотлогдсон хэргийг тодорхой хугацаанд шийдвэрлэх тухай хуульчлах нь хиймэл ачаалал үүсгэхгүй, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа шуурхай явагдах нөхцөлийг хангасан байна.
3. Оросын жишгээр хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломжтой хэргийн ялын доод хязгаарыг нэмэгдүүлэн, 10-12 жилийн хорих ял оногдуулахаар заасан гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжтой зохицуулалтыг хуульчлах нь тухайн ажиллагаа явагдах хүрээ нэмэгдэх боломжтой байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Монголын эрх зүйн хөгжил нь эх газрын эрх зүйн тогтолцоонд багтан салбар эрх зүйг хөгжүүлж ирсэн ч 2002 оноос хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх тухай зохицуулалтыг анхлан авч үзсэн байдаг. Гэвч судалгаа шинжилгээний дутмаг байдал, практик хэрэглээг дэмжих хөшүүрэг хангалтгүйгээс эдгээр зохицуулалт хангалттай хэрэгжиж чадаагүй юм.

Улмаар 2017 онд ЭХХШТХ-д “Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”-ны зохицуулалтыг боловсронгуй болгон хуульчилсан нь үр дүнгээ өгч, ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх хэргийн тоо эрс өссөн нь гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, хорих ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх зохицуулалт Эрүүгийн хууль, ЭХХШТХ-д тодорхой хуульчлагдсантай холбоотой байна гэж дүгнэж байна. Тухайлбал, 2020 онд ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар анхан шатны шүүхээр 4,750 (35 хувь) буюу гуравны нэгийг, давж заалдах шатны журмаар 91 (3 хувь), хяналтын шатны шүүхэд 8 (3.2 хувь) хэрэг тус тус шийдвэрлэсэн нь ЭХХШТХ-ийн 17 дугаар бүлэгт заасан “Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”-ны зохицуулалт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа төдийгүй сонгон судалсан шүүхийн шийтгэх тогтоол, магадлалуудад дараах нөхцөл байдал дүгнэгдэж байна. Үүнд:

1. ЭХХШТХ-д Эрүүгийн хуулийн тусгай ангид наймаас доош жилийн хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан хэргүүдийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхээр заасан байх бөгөөд 2020 оны 2 дугаар сарын 23-ны өдрийг хүртэл зөвхөн Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлд заасан нөхцөл хангаж байгаа тохиолдолд шүүх хуульд зааснаар зөвхөн хорих ялыг хөнгөрүүлэх, чөлөөлөх боломжтой байсан байна.

Харин 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн ЭХХШТХ-д орсон нэмэлт, өөрчлөлтөөр хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад прокурор, шүүхийн хянавал зохих байдалд Эрүүгийн хуулийн 5.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 5.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 5.5 дугаар зүйлийн 4 дэх хэсгүүдийг буюу торгох, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх ялуудыг нэмсэн байна. Түүнчлэн ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагааг сонгосон эсэхээс үл хамааран шүүхийн шатанд гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан шүүх тухайн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх зохицуулалттай гэж дүгнэж болохоор байна.

2. Эрүүгийн хуульд заасан найм хүртэлх жилийн хорих ялтай гэмт хэрэг үйлдсэн яллагдагч³⁸ нь иргэншил, нас, хүйсийн байдал, эрхэлж байгаа ажил, албан тушаал, боловсрол, урьд нь ял шийтгэл эдэлж байсан эсэхээс үл хамаарч тухайн журмаар хэргээ шуурхай шийдвэрлүүлэх боломжтой байна. ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх

³⁸ ЭХ-ийн 6.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг "...ял оногдуулахыг тэнсэж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан хугацаанд шүүхээс даалгасан үүргийг биелүүлээгүй хүнд ял оногдуулахад энэ бүлэгт заасан журмыг хэрэглэхгүй".

ажиллагаа нь цаг хугацаа, зардал хэмнэдэг тул иргэн тухайн журмыг сонгон хүсэлт гаргаж, хэргээ шуурхай шийдвэрлүүлэх нь Үндсэн хуульд заасан хөдөлмөрлөх, суралцах зэрэг иргэний үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэх боломж олгодог байна.

3. Сонгон судалсан хэргүүдэд дүн шинжилгээ хийхэд 139 хүнд торгох ял, 10 хүнд нийтэд тустай ажил хийлгэх ял, 14 хүнд эрх хасах ял нэмэгдлээр оногдуулсан нь Эрүүгийн болон ЭХХШтХ-д 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотой байна. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан шүүх **хорих ялыг хөнгөрүүлж, ялаас чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэхээр** хуульчилсан билээ. Өөрөөр хэлбэл, 2020 оны 2 дугаар сарын 23-ны өдрийг хүртэл эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхэд гагцхүү Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийг баримтлах агуулгатай байсан нь “Торгох”, “Нийтэд тусгай ажил хийлгэх”, “Зорчих эрхийг хязгаарлах” ялыг оногдуулах хууль зүйн үндэслэлгүй байсан. Түүнчлэн хялбаршуулсан журмаар шийдвэрлэх саналтай ирсэн хэргийг ердийн журмаар шийдвэрлэсэн тохиолдлууд сонгон судалсан шийтгэх тогтоолыг судлах явцад гарсан нь шүүх хуралдааны нарийн бичгийн даргын техник алдаа эсвэл хууль буруу хэрэглэсэн эсэх нь тодорхойгүй байна.
4. Түүнчлэн прокурор, шүүх Эрүүгийн болон ЭХХШтХ-уудад тусгасан ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагааны үзэл баримтлал, хандлагыг ташаа ойлгосноос хууль хэрэглэх явцдаа процессын алдаа

гаргаж байна. Тодруулбал, прокурорын санал болгосон ялаас шүүх хүндрүүлж ял оногдуулан шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулах, хорих ял оногдуулах санкцгүй хэрэгт ял тэнсэх, Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйл буюу гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, хорих ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэхэд нэмэлтээр Эрүүгийн хуулийн 7.1-ийг давхар журамласан гэх мэт.

5. Хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж байгаа хугацаа, хэргийг прокурор, шүүхээс нэмэлт ажиллагаа хийхээр буцаасан байдалд дүн шинжилгээ хийхээр эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн санамсаргүй түүврийн аргаар судалсан 189 шийтгэх тогтоолтой танилцахад тодорхой мэдээлэл байхгүй байснаас гадна шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулсан, яллагдагч, тэдгээрийн өмгөөлөгчөөс санал, хүсэлт гаргасан эсэхийг шийтгэх тогтоолоос дүгнэх боломжгүй байв. Тухайлбал, ЭХХЖ-аар хянан шийдвэрлэсэн ажиллагаа нь ЭХХШТХ-ийн 17 дугаар бүлэгт заасан даруй буюу долоо хоногийн дотор явагдсан эсэхийг дүгнэх боломжгүй байна.
6. Сонгон судалсан хэргүүдэд хөдөө орон нутагт шийдвэрлэсэн хэргийн шүүгдэгчдийн 22 хувь, Улаанбаатар хотод шийдвэрлэсэн хэргийн шүүгдэгчдийн 90.1 хувь нь шүүх хуралдаанд өмгөөлөгчгүй оролцсон нь ЭХХШТХ-д зааснаар яллагдагч, шүүгдэгч ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагаанд заавал өмгөөлөгчтэй байх агуулга илэрхийлэгдэж байгаа ч тус хуулийн хэрэгжилт хангалтгүй, мөн яллагдагч, шүүгдэгч үйлдсэн хэргээ хүлээн зөвшөөрсөн, хохирогч учирсан хохирлоо эргүүлэн авсан зэрэгтэй холбоотой байна.

7. ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэглээ практикт нэг мөр хэрэгжихгүй байгаа нь ЭХХША хэрэгжүүлэгчдийн мэдлэг, ур чадвар, хандлагаас ихээхэн хамааралтай байна. Тухайлбал, ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах хүсэлтийг хүлээн авсан прокурор хуульд заасан үндэслэлгүй байвал уг ажиллагаа явуулахаас татгалзан, энэ тухай үндэслэл бүхий тогтоол гаргана. Энэхүү шийдвэрт яллагдагч, түүний өмгөөлөгчид хуульд заасны дагуу дээд шатны прокурорт гомдол гаргах эрхтэй боловч прокурор хүсэлтийг хүлээн авахаас үндэслэлгүй татгалзах, энэ тухай бичгээр шийдвэр гаргахгүй байх, зарим тохиолдолд хойшлуулж байгаа нь зарим шүүхийн шийдвэрт тусгагджээ.
8. ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагааны явцад “хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлж байгаа” эсхүл “хохирлоо төлсөн” гэх агуулга нь хохирогчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хөндөх нөхцөл байдал бий болгож, хохирол эцэслэн тогтоох боломжгүй байдаг тухай шүүхийн шийдвэрүүдэд тусгагдсаныг тэмдэглэх нь зүйтэй. Тодруулбал, ЭХХШТХ-ийн 17.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх тухай хүсэлтэд хохирлоо нөхөн төлсөн баримтыг хавсаргана”, 17.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 4.5-д “гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, хор уршгийг нөхөн төлсөн, нөхөн төлөхөө илэрхийлсэн эсэх” гэж заасан байна.

Цаашид сонгон судалсан шүүхийн шийдвэрүүдэд тогтоогдсон нөхцөл байдлыг үндэслэн 2015 оны Эрүүгийн хууль, 2017 оны ЭХХШТХ-д заасан гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх зохицуулалт, үндэслэл, журмыг боловсронгуй болгох хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Эрүүгийн хуульд хорих ял, зорчих эрхийг хязгаарлах ялыг хөнгөрүүлэн, ялаас чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэхээр хуульчилсан нь бусад төрлийн ялыг хөнгөрүүлэх, чөлөөлөх талаар цаашид зохих судалгаа хийж хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг тодорхойлох;
- ЭХХШТХ-ийн 17.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “... саналыг яллагдагч эсхүл түүний өмгөөлөгчид танилцуулж...”, 17.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан “...шүүгдэгч эсхүл түүний өмгөөлөгч ...” гэж өөрчлөн найруулах;
- Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлд тусгагдсан “Хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн” томъёоллыг Улсын Дээд шүүхээр тайлбарлуулах;
- Яллагдагч нь ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх тухай хүсэлт гаргахад хэрхэн бүртгэж авах, хуульд заасны дагуу прокурорт танилцуулах, хэрхэн шийдвэр гаргах, уг ажиллагаанд хяналт тавих стандартыг УЕП-ын тушаалаар батлагдах “Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавих прокурорын аргачилсан журам”-д нэмэлтээр оруулах;
- ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагааны талаар сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулан, тус ажиллагааны мөн чанарыг таниулах шаардлагатай. Тухайлбал, Монголын Хуульчдын холбооны хуульчийн үргэлжилсэн сургалтад “ЭХХЖ-аар хянан шийдвэрлэх ажиллагааны мөн чанар, хууль зүйн учир холбогдол” сэдвээр сургалтын хөтөлбөр боловсруулан баталж, сургалтыг танхим, цахим, видео хэлбэрээр зохион байгуулах нь ач холбогдолтой.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Хууль, эрх зүйн акт

1. Эрүүгийн хууль, УБ., 2002.
2. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, УБ., 2002.
3. Улсын Их Хурлын тухай (шинэчилсэн найруулга) хууль, УБ., 2020.
4. Эрүүгийн хууль, УБ., 2015.
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, УБ., 2017.
6. ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2015.
7. “Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналтын аргачилсан заавар” УЕП-ын 2020.07.17-ны өдрийн А/67 тоот тушаал.
8. УЕПГ-ын 2021.04.09-ний өдрийн №5/10 дугаартай “Аймаг, Нийслэл, Тээвэр, Дүүрэг, Сум дундын прокурорын газруудад хүргүүлсэн мэдээлэл”.
9. “Уголовно-процессуальный кодекс Российской Федерации” от 18.12.2001, N 174-ФЗ.
10. БНСУ-ын Эрүүгийн процессын хууль, 2007.
11. АНУ-ын Нотлох баримтын тухай холбооны журам, 1972.
12. Английн Цагдаагийн үйл ажиллагаа болон эрүүгийн нотлох баримтын тухай хууль, 1985.

13. Эрүүгийн 029000320048 дугаартай хэрэгт холбогдуулан гаргасан Өмнөговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 35 дугаартай магадлал (144/2020/0062/Э).
14. Эрүүгийн 2006 00000 2244 дугаартай хэрэгт холбогдуулан гаргасан Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 1324 дугаартай магадлал (105/2020/1557/Э)
15. Эрүүгийн 2035000000158 дугаартай хэрэгт холбогдуулан гаргасан Увс аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 01 дугаартай магадлал
16. Эрүүгийн 2035000000158 дугаартай хэрэгт холбогдуулан гаргасан Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 2020/ДШМ/57 дугаартай магадлал (2034001050140”).
17. Эрүүгийн 2009008250431 дугаартай хэрэгт холбогдуулан гаргасан Улсын Дээд шүүхийн 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 477 дугаартай (185/2020/0308/Э/) тогтоол.
18. Эрүүгийн 1902000000344 дугаартай хэрэгт холбогдуулан гаргасан Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 974 дугаартай магадлал (2020/ДШМ/974).
19. Эрүүгийн 1902000000201 дугаартай хэрэгт холбогдуулан гаргасан Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 2020/ДШМ/1340 дугаартай магадлал (105/2020/1443/Э).
20. Б.С-д холбогдох хэрэгт холбогдуулан гаргасан Сүхбаатар аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 24 дугаартай (174/2020/0155/э/) магадлал.

2. Ном, сурах бичиг, эрдэм шинжилгээний бүтээл

1. Б.Батзориг, Э.Зууннасан, БНХАУ-ын Эрүүгийн ба Эрүүгийн заргын хууль, УБ., 2006.
2. Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан, Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал, УБ., 2018.
3. Ж.Болдбаатар нар, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, УБ., 2020.
4. Д.Баярсайхан, Гадаад орнуудын эрүүгийн процесс, УБ., 2015.
5. Ш.Баасандорж, Ром-Германы эрүүгийн процесс: Францын эрүүгийн процессын түүхэн уламжлал, шинэчлэл, УБ., 2018.
6. Б.Оюунболд нар, Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном, УБ., 2019.
7. Б.Оюунболд, “Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэгжилт, үр дүн”, судалгааны тайлан, УБ., 2019.
8. Дорин Чен, Б.Сарантуяа, Монгол Улс дахь гэр бүлийн хүчирхийллийн хэргийн шүүх хуралдааны ажиглалт, судалгааны тайлан, УБ., 2021.
9. БНСУ ба Монгол Улсын эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн тогтолцоо: тулгамдсан асуудал ба сорилт. УБ., 2014.
10. Б.Бат-Орших. Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үндсэн асуудал. УБ., 2021.

3. Цахим эх сурвалж

1. <http://www.Shuuh.mn/>
2. <http://www.1212.mn/>

3. <http://www.judoinstitute.mn/>

4. Гадаад хэлээрх эрх сурвалж

1. Правовые системы стран мира: Энциклопедический справочник под ред. Сухарева А.Я., М., 2000.
2. Н.Г.Стойко, А.С.Шагинян, Уголовный процесс Англии и Уэльса, Бельгии и Дании: сравнительно-правовой аспект, Красноярск, 2007.
3. Н.Г.Стойко, О.Б.Семухина, Уголовный процесс в США, Красноярск, 2000.
4. В.Н.Бибило, Судебные системы зарубежных государств, Учебно-методическое пособие для студентов юридических специальностей, БГУ, Минск, 2012.
5. Батлер У.Э., Бойцова В.В., Решетников Ф.М., Правовые системы стран мира: Энциклопедический справочник под ред. Сухарева А.Я., М., 2001.
6. Stones Justice Manual, London, 1994.
7. Stephn C.Thaman, Comparative criminal procedure, C.A., 2002.



ХАВСРАЛТ

Хавсралт 1. Анхан шатны шүүхээс хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн ерөнхий судалгаа

№	Шүүх	Нийт шийдсэн хэрэг (2020.02.23-2020.12.31)	Хялбаршуулсан журмаар шийдсэн хэрэг, хувь (2020.02.23-2020.12.31)	Судалгаанд хамрагдсан таван хувь
Хөдөө орон нутгийн сум дундын шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн судалгаа				
1	Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	194	84 (43.3%)	4
2	Баян-Өлгий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	183	59 (32.2%)	3
3	Баянхонгор аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	297	103 (34.7%)	5
4	Булган аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	199	59 (29.6%)	3
5	Говь-Алтай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	91	41 (45.1%)	2

Хавсралт 1-ийн үргэлжлэл

6	Говьсүмбэр аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	91	48 (52.7%)	3
7	Дархан-Уул аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	143	35 (24.5%)	2
8	Дорноговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	105	23 (21.9%)	2
9	Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	269	120 (44.6%)	6
10	Дундговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	56	24 (42.9%)	2
11	Завхан аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2	2 (100.0%)	2
12	Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	221	42 (19.0%)	2
13	Өвөрхангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	24	4 (16.7%)	1
14	Өмнөговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	124	55 (44.4%)	3
15	Сүхбаатар аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	129	82 (63.6%)	4
16	Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	73	21 (28.8%)	2



Хавсралт 1-ийн үргэлжлэл

17	Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	247	82 (33.2%)	4
18	Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	137	31 (22.6%)	2
19	Ховд аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	177	115 (65.0%)	6
20	Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	318	65 (20.4%)	3
21	Хэнтий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	157	53 (33.8%)	2
22	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх	82	20 (24.4%)	2
23	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх	44	21 (47.7%)	2
24	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх	89	14 (15.7%)	2
25	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүх	142	28 (19.7%)	2
26	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх	108	25 (23.1%)	2
27	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүх	42	12 (28.6%)	3
28	Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх	17	11 (64.7%)	1
29	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүх	57	34 (59.6%)	2
Нийт		3818	1313(38.0)	79

Хавсралт 1-ийн үргэлжлэл

Улаанбаатар хотын шүүхээр шийдвэрлэсэн хэргийн судалгаа				
30	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1765	693 (39.3%)	36
31	Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	700	283 (40.4%)	13
32	Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	772	289 (37.4%)	15
33	Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	870	302 (34.7%)	15
34	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	648	213 (32.9%)	11
35	Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1109	297 (26.8%)	15
36	Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	94	29 (30.9%)	2
37	Багахангай дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	5	0 (0.0%)	0
38	Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	181	51(28.2%)	3
Нийт		6144	2157 (30.1%)	110
БҮГД		9962	3470 (34%)	189



Хавсралт 2. Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэрэгтэй холбогдуулан эрцүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн хэргийн өнгөөр хийсэн судалгаа

№	Хэргийн зүйл анги	Хэдэн хэрэгт гомдол, эсэргүүцэл гаргасан болох
1	ЭХТА-ийн 11.3. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах	1
2	ЭХТА-ийн 11.4. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах	5
3	ЭХТА-ийн 11.6. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах	35
4	ЭХТА-ийн 13.5. Заналхийлэх	1
5	ЭХТА-ийн 17.1. Хулгайлах	8
6	ЭХТА-ийн 17.2. Дээрэмдэх	1
7	ЭХТА-ийн 17.3. Залилах	3
8	ЭХТА-ийн 17.4. Хөрөнгө завших	4
9	ЭХТА-ийн 17.5. Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших	2
10	ЭХТА-ийн 17.12. Мал хулгайлах	4
11	ЭХТА-ийн 18.3. Татвар төлөхөөс зайлсхийх	1
12	ЭХТА-ийн 18.6. Мөнгө угаах	1
13	ЭХТА-ийн 20.16. Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	1
14	ЭХТА-ийн 20.7. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	3
15	ЭХТА-ийн 22.1. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах	1
16	ЭХТА-ийн 22.4. Хахууль авах	4

Хавсралт 2-ын үргэлжлэл

17	ЭХТА-ийн 22.5. Хахууль өгөх	4
18	ЭХТА-ийн 22.12. Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах	1
19	ЭХТА-ийн 23.1. Хууль сахиулагчийг эсэргүүцэх	1
20	ЭХТА-ийн 23.2. Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах	1
21	ЭХТА-ийн 23.7. Нийтийн албан тушаалтныг заналхийлэх	1
22	ЭХТА-ийн 24.3. Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах	1
23	ЭХТА-ийн 24.6. Хууль бусаар мод бэлтгэх	1
24	ЭХТА-ийн 27.10. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	6
Нийт		91



*Хавсралт 3. Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн
хэрэгтэй холбогдуулан эрүүгийн хэргийн давж заалдах
шатны шүүхээр шийдвэрлэсэн хэргийн судалгаа*

№	Шүүхийн нэр	Шийдвэрлэсэн хэргийн тоо
1	Архангай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1
2	Баянхонгор аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1
3	Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1
4	Говьсүмбэр аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1
5	Өмнөговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1
6	Ховд аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1
7	Хөвсгөл аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1
8	Дундговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	2
9	Өвөрхангай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	2
10	Сүхбаатар аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	2
11	Увс аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	2
12	Орхон аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	3
13	Хэнтий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	4
14	Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	69
Нийт		91

Хавсралт 4. Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэрэгтэй холбогдуулан эрүүгийн хэргийн хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн хэргийн дэлгэрэнгүй судалгаа

№	Тогтоолын дугаар	Гомдол, эсэргүүцэл гаргасан	Урьд шийдвэрлэсэн шүүх	Хэргийн өнгө
1	125	Шүүгдэгч, түүний өмгөөлөгч	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	11.6
2	472	Прокурор	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	11.6
3	268	Шүүгдэгч, түүний өмгөөлөгч	Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	17.1
4	477	Прокурор	Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	17.1
5	335	Шүүгдэгч, түүний өмгөөлөгч	Завхан аймгийн анхан шатны шүүх, тус аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	11.6
6	382	Прокурор	Хэнтий аймгийн анхан шатны шүүх, тус аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	17.5

Хавсралт 4-ийн үргэлжлэл

7	301	Шүүгдэгч, түүний өмгөөлөгч	Ховд аймгийн анхан шатны шүүх, тус аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	24.5
8	287	Прокурор	Булган аймгийн анхан шатны шүүх, тус аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	24.6

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА ХАРИУЦСАН РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

ДАШНЯМЫН ЗОЛЖАРГАЛ (LL.M, MBA)
Өмгөөллийн DB>S ХХН-ийн гишүүн хуульч



Өмгөөллийн DB>S ХХН-ийн Гүйцэтгэх захирал тэрээр Монголын санхүү, банк, хөрөнгийн зах зээлийн чадварлаг мэргэжилтний нэг бөгөөд компанийн эрх зүй, эрчим хүч, эрдэс баялгийн салбараар мэргэшсэн хуульч юм. Хуулийн зөвлөх үйлчилгээний хувийн салбарт 15 дахь жилдээ ажиллаж байгаа. Түүнээс өмнө Монголын томоохон арилжааны банканд хуульчаар ажиллахын зэрэгцээ МУИС-ийн Хууль зүйн сургууль, “Билиг” дээд сургуульд хичээл зааж байсан түршлагатай. МУИС-ийн Хууль зүйн сургуулийг олон улсын эрх зүйн бакалавр, АНУ-ын Оклахомагийн Их сургуулийг бизнесийн удирдлагын магистр, АНУ-ын Харвардын Их сургуулийн Хуулийн сургуулийг хууль зүйн магистр зэрэгтэй тус тус дүүргэсэн. Chambers & Partners, Legal500, IFLR зэрэг олон улсын хуульчдын зэрэглэл тогтоодог байгууллагаас Д.Золжаргал, түүний удирдаж ирсэн хуулийн фирмийг олон жилийн түрш өндөр үнэлсэн байдаг.

АЛТАНГЭРЭЛИЙН БЯМБАЖАРГАЛ (S.J.D.)



МУИС-ийн Хууль зүйн сургуульд төрийн захиргаа, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй, Үндсэн хуулийн процессын эрх зүй, харьцуулсан эрх зүйн хичээл заадаг. Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн даргын хувиар эрдэм шинжилгээний ажил, бүтээл түүрвил, улирал тутмын “Эрх зүй” сэтгүүлийг эрхлэн гаргах ажил хариуцан ажиллаж байв. 2021 оноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн хууль зүйн бодлогын зөвлөхөөр томилогдон ажиллаж байна.

МУИС-ийн Хууль зүйн сургуулийг дүүргэж, БНСУ-ын Күүкманий Их сургуульд хууль зүйн докторын зэрэг хамгаалсан.

НАРАНЧУЛУУНЫ ОТГОНЧИМЭГ (LL.M.)



Захиргааны эрх зүйн чиглэлээр мэргэшсэн судлаач бөгөөд УДШ-ийн Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал, УИХ-ын Тамгын газар, олон улсын хөгжлийн хөтөлбөрүүдэд зөвлөх зэргээр мэргэжлээрээ 23 жил ажилласан туршлагатай хуульч юм. 2021 оны 11 дүгээр сараас Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна. МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр, магистрын зэрэгтэй, Лондоны Kings college-ийг хууль зүйн магистр зэрэгтэй төгссөн.

ГАНЧУЛУУНЫ ОЮУНБОЛД (LL.M.)



Криминологи, эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын чиглэлээр мэргэшин судалдаг ба практик болон судалгааны байгууллагад 20 жил ажилласан туршлагатай. Цагдаагийн академийг эрх зүйч, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийг англи хэл-менежерийн бакалавр зэрэгтэй төгсөж, 2007 онд “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хугацаа” сэдвээр хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан. Түүнчлэн академик болон бодлогын судалгааны чиглэлээр дангаар, бусадтай хамтран 40 орчим судалгааны ажил, 20 гаруй сурах бичиг, гарын авлага боловсруулж нийтийн хүртээл болгосон. Хуульч, хууль сахиулагчийг чадавхжуулах хүрээнд 10 орчим жил сургагч багшаар ажиллаж байна.

СҮХЭЭГИЙН БИЛГҮҮН (LL.M.)

ШЕЗ-ийн Тамгын газрын дарга



ШЕЗ-ийн Тамгын газрын дарга тэрээр хууль зүйн судалгаа, сургалт, шүүхийн захиргааны чиглэлээр ажилладаг.

МУИС-ийн Хууль зүйн сургуульд суралцаж “Монгол Улсад эрх зүйн зайлшгүй процессыг төлөвшүүлэх нь” сэдвээр, Япон Улсын Кьюсюгийн Их сургуульд суралцаж “Монгол Улс дахь нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн хамгаалах тогтолцоог бэхжүүлэх нь” сэдвээр хууль зүйн магистрын зэрэг тус тус хамгаалсан. Харьцуулсан эрх зүй, хүний эрхийн чиглэлээр судалгаа хийдэг.

ISBN 978-9919-9840-8-3



9 789919 984083